

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 - 81
1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	8 - 16
2. Үндэсний баялгийн сангийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.03-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	17 - 81

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 04-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, А.Адъяасүрэн, П.Анужин, Х.Баделхан, Б.Баярсайхан, С.Бямбацогт, Ц.Идэрбат, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Жавхлан;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Д.Батлут, Э.Батиугар, Т.Доржханд, Ш.Раднаасэд, Ц.Сэргэлэн;

Тасалсан: Б.Дэлгэрсайхан;

Хоцорсон: Г.Амартүвшин – 06 минут, Ц.Анандбазар – 09 минут, Э.Бат-Амгалан – 06 минут, Ж.Батсуурь – 09 минут, Б.Бейсен – 06 минут, Х.Болорчулуун – 12 минут, Х.Булгантуяа – 07 минут, С.Ганбаатар – 1 цаг 05 минут, Д.Ганбат – 09 минут, Н.Ганибал – 03 минут, Х.Ганхуяг – 12 минут, Б.Жаргалмаа – 02 минут, Л.Мөнхбаатар – 10 минут, Ц.Мөнх-Оргил – 34 минут, Г.Мөнхцэцэг – 05 минут, Ц.Мөнхцэцэг – 05 минут, С.Одонтуяа – 11 минут, М.Оюунчимэг – 28 минут, Д.Өнөрболор – 49 минут, Ж.Сүхбаатар – 28 минут, Ч.Ундрал – 3 цаг 27 минут, Д.Цогтбаатар – 1 цаг 19 минут, О.Цогтгэрэл – 15 минут, Ж.Чинбүрэн – 01 минут, Т.Энхтүвшин – 10 минут, Ж.Эрдэнэбат – 06 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээс ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Нэг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, мөн хорооны Хяналт шалгалтын газрын дарга Б.Долгорсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор, мөн хэлтсийн зөвлөх Н.Ундраа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Г.Дамдинням нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.34-4.1.39 дэх заалтын дугаарыг “4.1.35-4.1.40” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 19 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.8 дахь хэсгийн “задруулахыг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 21
Бүгд: 44
52.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан дуусаагүй байгаатай холбогдуулан хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 23
Бүгд: 45
48.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг хэлэлцэж дуустал чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулахаар тогтов.

Хуралдаан 10 цаг 52 минутад завсарлаж, 11 цаг 50 минутаас үргэлжлэв.

Хоёр.Үндэсний баялгийн сангийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.03-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Г.Давааням, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Б.Жаргалмаа, Ц.Мөнхцэцэг, Ж.Батжаргал, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 54 минут үргэлжилж, 13 цаг 10 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 03 минутад эхлэв.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Г.Ганболд, Ц.Сандаг-Очир, Б.Баттөмөр, Т.Энхтүвшин, Н.Энхболд, Д.Сарангэрэл, Б.Бейсен, Д.Тогтохсүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, С.Амарсайхан, Б.Энх-Амгалан, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 50 минут үргэлжилж, 72 гишүүнээс 51 гишүүн хүрэлцэн ирж, 70.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 18 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Ирц 40 гишүүн ирсэн. 55.0 хувийн ирцтэй байна.

Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Зарчмын зөрүүтэй хоёр саналтай байгаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Маргаашийн хуралдаанаар Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуулиудыг хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүний хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнээс албан бичиг ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танаа Миний бие 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн чуулганы хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлэх тул зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ оруулж ирж байгаа хуулиудтай холбоотой бас нэг хуулийг хэлэх хэрэгтэй байна.

Миний бие болоод Л.Мөнхбаатар дарга, Г.Тэмүүлэн гишүүн, Ч.Ундрам, Н.Ганибал гишүүд бид хэд хамтраад нэг хууль өргөн барьсан.

Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах хууль өргөн барьсан юм.

Тэгээд энэ нь юу гэж байгаа, ямар хууль юм гэхээр малчдын өвөлжөө, хаваржааны газартаа нэг га газарт ногоон тэжээл тариалах ийм боломжийг нь олгож байгаа ийм хууль байгаа юм.

Тэгээд сая энэ өвөл, хавар их хүнд боллоо шүү дээ.

Урьд өмнө болж байгаагүй ийм хатуу өвөл боллоо.

Одоо нийт масс юу ярьж байна гэхээр, нийт малчдын хувьд юу ярьж байна гэхээр ерөөсөө малаа тэжээдэг байх, малынхаа саравч байшин саравчийг сайжруулах, тэгээд малын тэжээл бэлдэх, тэжээлээ өгдөг байх.

Ер нь өвлийн энэ хүйтэн эрсдэлтэй нөхцөл байдлыг давах бэлтгэл ажлыг хийх зайлшгүй шаардлага гараад байна гэж ярьж байгаа.

Тэгэхээр өргөн барьсан энэ хуулийг одоо татаж авч хэлэлцүүлээч гэсэн нэг ийм саналыг оруулж ирж байгаа юм.

Ер нь цаг агаарын өөрчлөлт гэдэг одоо бүр хэлж ирэхгүй орж ирдэг ийм үнэхээр хатуу хүнд байдал бий болоод байна шүү дээ.

Одоо жилээс жилд улам хүндрээд байх шиг байна.

Зундаа айхтар халдаг болчихоод байна, өвөлдөө айхтар хүйтэн болчихоод байна, салхи шуурга нэмэгдээд байна.

Тэгэхээр ер нь малчдынхаа амьжиргааг дэмжих, малчдынхаа амьдрах боломж бололцоо, бизнес хийх боломж бололцоо, малаа хагас эрчимжсэн байдлаар авч явах ийм нөхцөл байдлыг бий болгохын тулд малчид ногоон тэжээл болон бордоогоор хангах, өөрөө өөрсдөө ногоон тэжээлээ тарьдаг байх боломж

бололцоог нь олгох зайлшгүй шаардлага гараад байгаа юм.

Тийм болохоор Газрын тухай хуульд оруулж байгаа.

Өвөлжөө, хаваржааныхаа газар нэг га хүртэл газарт ногоон тэжээл тарих боломж бололцоо олгож байгаа энэ Газрын тухай хуулийг татаж хэлэлцүүлээч ээ гэсэн саналыг Улсын Их Хурлын даргад санал болгож хэлж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай шууд холбоогүй ч гэсэн.

Тэгээд хэлэлцэх асуудалд оруулах талаар холбогдох Байнгын хороодоос энэ асуудлаар санал ирээгүй бөгөөд Газрын хуультай холбоотой асуудлуудыг цогцоор нь, багцаар нь хэлэлцэнэ гэж Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо үзээд Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа.

Газрын хуультай холбоотой асуудлууд багцаараа явж байгаа юм билээ.

Тийм учраас Байнгын хороон дээрээ энэ асуудлаа хэлэлцэж, ажлын хэсэг дээрээ хэлэлцээд тэгээд нэгдсэн журмаар оруулж ирэхээр тохирсон юм байна. Танай Байнгын хороо.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

**Нэг.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**

*/Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/*

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогогийн Энхтүвшин танилцуулна.

Индэрт урьж байна.

Т.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр дотоод кастодиан банкны үйл ажиллагааг нээж, эдийн засгийн зохистой харьцаанд уялдуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг хөрөнгийн зах зээлд оролцож байгаа гаднын томоохон сүлжээ дэлгүүрүүдийн хувьцааны асуудлаар, хөрөнгийн зах зээлийг зөв хөгжүүлснээр хөрөнгө оруулагчдыг дэмжих, эдийн засаг томрох, хөрөнгө оруулалтыг татах боломжтой болгох талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй зарчмын зөрүүтэй хоёр саналын томьёоллыг гаргасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусган, эцсийн хувилбарын төсөл, Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн үнэт сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг баталж өгөхийг Та бүхнээсээ хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Баттулгын Дөлгөөн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Лувсандоржийн Сонор, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газрын дарга Бархасын Долгорсүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн дарга Жаргалсайханы Мөнх-Оргил, Сангийн

яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх Нүрсэдийн Ундраа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Г.Дамдинням гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Та бүхнийхээ амар амгаланг айлтгая.

Үнэт цаасны хуулийг сайжруулах энэ бүх юмыг дэмжиж байгаа.

Үнэт цаасны зах зээл нэг үеэ бодвол бас сүүлийн үед гайгүй болж байгаа. Уг нь санхүүгийн зах зээлийн 5-хан хувийг эзэлдэг байсан бол одоо арай дээрдсэн байх. Тийм. Банкнуудын үнэт цаас Хөрөнгийн бирж дээр зарагддаг болсноор энэ бас арай дээрдсэн байх. Манай хөрөнгө оруулагчид бас энэ бирж дээрээ авах ийм бараатай болсон байгаа байх.

Гэхдээ хэд хэдэн зүйлүүд байна. Үүнийг тодруулъя.

Энэ “**Топ-100**” компани гэж байгаа. Бусад дэлхийн улс орнуудад аль болохоор хөрөнгийн бирж дээр гарах, тэгээд нээлттэй компани болох, үнэт цаас гаргах ийм сонирхолтой байдаг л даа. Энэ байдал ямар байна вэ?

Нөгөө талаар манайх уул уурхайн компаниуд байгаа.

Тэгээд 10 хувиа хувьцаат компани болоод олон түмэнд үнэт цаасны зах зээлд нийлүүлж байх ёстой. Ингээд нээлттэй арилжаалж, олон түмэн түүнээс нь худалдаж авч, хөрөнгө оруулж явах ёстой. Ийм юм нь юу болсон бэ?

Ийм хөрөнгө оруулалтын орчин байхгүй болохоор манай залуучууд чинь одоо “coin”, “token” ийм зүйлүүдэд ороод нөгөө мөнгө төгрөгөө алдаад дуусаж байна. Үүнээс нь одоо тэд нарыг ухуулах, ойлгуулах, тэр луйварчидтай хийх тэмцэл, энэ виртуал хөрөнгө оруулалт дээр гаргасан хуулиуд чинь амьдрал дээр яаж хэрэгжиж бууж байгаа юм бэ?

Энэ бол одоо Та бүхний бас нэг үүрэг байх ёстой. Бид чинь зах зээлд ороод нэг их удаагүй байна. Хүн болгон тийм хөрөнгө оруулалт, үнэт цаасны талаарх мэдлэг тийм сайнгүй байгаа.

Үүнийг нь луйварчид аягүй ашиглаж байна.

Нөгөө талаар энэ ашигтай ажилладаг, ялангуяа бараг төрийн 50 их наядын өмчтэй ийм компаниуд байна. Энэ талаар хувьчлах, үнэт цаасыг нь гаргуулах талаар аягүй бага ажиллаж байна.

Тэгээд **“Эрдэнэс Тавантолгой”** компани маань сүүлийн хэдэн жил уул уурхай, нүүрсний үнэ нэлээн өндөр байсан.

Гэтэл одоо үүний ашгийг ард түмэнд хүртээж чадсангүй ээ. Ер нь наалдсан ч үгүй. Тэр компани нь өөрөө ойлгомжгүй нэршилтэй, ойлгомжгүй байдалтай. Нэг болохоор төрийн компани ч юм шиг, нэг болохоор хувьцаат компани ч юм шиг.

Тэгээд компанийнхаа хуулиар явдаггүй. Нэгэнт тэр хуулийг нь гаргасан юм бол, тэр хуулиараа явахгүй юм бол. Хууль бол хаана ч хэрэгжиж байх ёстой. Түүн дээр Та бүхэн хяналт тавьж байх ёстой.

Гэтэл одоо төрийн юм уу, одоо Монгол Ардын нам л эрх барьчихаараа хууль хэрэгжүүлдэггүй, бараг хэдэн дарга

нарын өмч юм шиг явж байдаг ийм байдалдаа хэзээ цэг тавих юм бэ?

Нөгөө талаар энэ ашигтай ажиллаж байгаа компаниуд олон түмний хяналтад ороод. Хувьцаат компаниуд. Би ялангуяа тэр “Эрдэнэс Тавантолгой”-г цохож байна. Тэр **“Оюу Толгой”** байна.

Үүний ашиг, ногдол ашиг нь хэзээ наалдах юм бэ, өгөх юм бэ? Тэр ард түмэндээ.

Тэр байтугай улирал болгон ногдол ашгийг нь өгч байж болно шүү дээ. Тэр талаас нь хэлдэг, ярьдаг хүн байхгүй их удаж байна.

Тэр хөрөнгө оруулалтын банк, кастодиан гээд нэр төдий Үнэт цаасны хуульдаа оруулсан. Гаднын хөрөнгө оруулалт сүүлийн арваад жил, ялангуяа сүүлийн 8 жил нэг их орж ирээд гийгүүлээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хороо. Төмөртоогоогийн Энхтүвшин. Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны ажлын хэсгийн дарга хариулна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Ер нь сүүлийн жилүүдэд энэ хөрөнгийн зах зээл нэлээн тэлж байна. Яг одоогийн байдлаар хөрөнгийн зах зээл дээр 11 их наяд төгрөг эргэлдэж байгаа гэсэн ийм мэдээтэй байж байна.

Цаашдаа ч гадаад дотоодын хөрөнгө оруулагч нар бас нэмэгдэх, хөрөнгө оруулалтын сангууд бас нэмэгдэх ийм бололцоо боломжууд нээгдэж байгаа юм.

Үнэт цаасны тухай хууль дээр хамгийн гол орсон өөрчлөлт бол үнэт цаас гаргах аж ахуйн нэгж, байгууллагуудын

гаргах энэ тогтолцоог нэлээн хөнгөн шуурхай болгож өгсөн байгаа.

Ер нь та түрүүн ярилаа. Энэ нүүрсний компани, уурхайн компаниуд үнэт цаас гаргахад нэлээн олон шат дамжлагатай байсан.

Тэгэхээр энэ шат дамжлагыг нэгдүгээрт бууруулж өгсөн байгаа. Маш богино хугацаанд үнэт цаас гаргах бололцоо боломжийг нээж өгсөн ийм хууль болсон гэж харж байгаа.

Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын тоо бас нэмэгдэх хандлагатай байгаа.

Тэгээд энэ хуулиар ч гэсэн гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хөрөнгө оруулалт оруулах бололцоо боломжийг бас нээж өгч байгаа шүү.

Цаашдаа уул уурхайн компаниуд хөрөнгөө Хөрөнгийн биржээр арилжаалах, хувьцаа гаргах асуудлууд нэлээн нэмэгдэх ийм хандлагатай байгаа гэдгийг хэлмээр байна.

Нэмэлт хариулт байвал Д.Баярсайхан дарга хариулаад явъя.

Г.Занданшатар: 4 номер. Дэмбэрэлдашийн Баярсайхан. Санхүүгийн зохицуулах хорооны дарга хариулна.

Д.Баярсайхан: Д.Ганбат гишүүний асуултад тодруулъя.

Мэдээж хөрөнгийн зах зээлийн хөгжил **“Топ-100”** аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, арилжааны идэвхийг сэргээх маш үр нөлөөтэй.

Энэ хүрээнд нэлээдгүй ажлыг хийж байна. Ялангуяа Санхүүгийн зохицуулах хороо **“Монголын Үндэсний Худалдаа,**

Аж Үйлдвэрийн Танхим”-тай хамтраад энэ **“Топ-100”** аж ахуйн нэгжийг **“Монголын хөрөнгийн бирж”**ээр дамжуулж хувьцаагаа олон нийтэд санал болгох, хөрөнгийн зах зээл дээр оролцох оролцооны идэвхийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын хөтөлбөр гаргаад хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд олон нийтэд санал болгон хувьцаа гаргахад хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, бүртгэлийг хөнгөвчилсөн хэлбэрээр ажлын 10 хоногт багтааж гаргах. Хэрвээ өрийн хэрэгсэл бонд гаргах юм бол барьцаа баталгаа шаардахгүй байх гэх мэтийн олон дэмжлэгүүдийг үзүүлж ажиллаж байна.

Ирэх долоо хоногт бас **“Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим”**-тай хамтраад энэ **“Топ-100”** аж ахуйн нэгжүүдтэй **“Монголын хөрөнгийн бирж”** дээр гарах үйл ажиллагааг хэрхэн хөнгөвчлөх вэ гээд хамтарсан ажлын хэсэг байгаа. Үүнийхээ тайланг хэлэлцэнэ.

Түүний дараа долоо хоног бүр нэг цонхны үйлчилгээ гаргаж **“Топ-100”** аж ахуйн нэгжүүдэд **“Монголын хөрөнгийн бирж”**-ээр хувьцаагаа гаргахад зөвлөгөөг өгнө гэсэн ийм чиглэлээр ажиллаж байгаа.

Ер нь мэдээж Ашигт малтмалын хуулийн 5.6-д ашигт малтмалын ордууд, стратегийн ордуудын 10 хүртэлх хувийг **“Монголын хөрөнгийн бирж”**-ээр дамжуулж арилжаал гээд хуулийн заалт байгаа.

Дээрээс нь Төрийн болон орон нутгийн өмчийн 25 аж ахуйн нэгжийн 34 хүртэлх хувийг **“Монголын хөрөнгийн бирж”**-ээр дамжуулж олон нийтийн компани болго гэсэн Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлын тогтоол батлагдсан байгаа.

Энэ хүрээнд бас “Монголын хөрөнгийн бирж”-ээс авхуулаад дөнгөж саяхан “Монголын цахилгаан, харилцаа холбооны компани” Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтийн компани болгох....

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн битгий хурал үймүүлээд бай. Хуралдаа суухгүй.

Д.Баярсайхан: ... бэлтгэл ажлыг бүрэн хангуулж явж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Ер нь “Топ-100” аж ахуйн нэгж яг өнөөдрийн байдлаар 10 компани олон нийтийн компани байгаа.

Бидний хийсэн судалгаагаар “Топ-100” аж ахуйн нэгжийн өөрийн болон охин компаниудад оролцуулбал ойрын 3 жилийн хугацаанд 30 орчим компаниа бас олон нийтийн компани болгоё гэсэн ийм хүсэл эрмэлзэлтэй байгаа юм билээ.

Энэ хүрээндээ ч гэсэн одоо энэ бэлтгэл ажлыг хангуулах, олон нийтийн компани болохтой холбоотой манай дэд бүтцийн байгууллагуудын, дээрээс нь “Топ-100” аж ахуйн нэгжид тэр мэдлэг мэдээллийг олгох талаар Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” хамтарч ажиллаж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Г.Занданшатар: Одоо Г.Дамдинням гишүүн асуулт асууна.

Г.Дамдинням: Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль орж ирж байна.

Цаг үеэ олсон, нэн хэрэгцээтэй хуульд өөрчлөлт орж ирж байгаа гэж харж байгаа.

Ямарваа нэг бизнес аж ахуй эрхлэхэд хөрөнгө оруулалт зайлшгүй хэрэгтэй. Үүний нэг эх үүсвэр бол яалт ч үгүй энэ үнэт цаасны зах зээлээр орж ирдэг.

Уг нь манайд сайн хөгжөөд банкнаас хямд үнэтэй мөнгө бизнес рүү орж байх ёстой ийм л газар л даа.

Тэгээд одоо харамсалтай нь манай энэ сүүлийн 34 жилийн хугацаанд бид энэ үнэт цаасны зах зээлээ одоо сүүлийн үед л нэг жоохон эрчимтэй сэргэж байна. Өмнө нь одоо ерөөсөө олигтой байсангүй.

Ямар ч банкны хүүгээс хямдхан, дээрээс нь эрсдэлээ олон хуваачихсан ийм боломжтой л нөхцөл орж ирэх ёстой байдаг. Уг нь. Одоо яг хөгжчихсөн газартаа.

Тэгээд сүүлийн үед бас энэ **“Ашигт малтмалын бирж”** бий болоод, арилжаа нэмэгдээд, энэ салбар луу орж ирдэг хүмүүс нэмэгдээд харьцангуй гайгүй болж байх шиг байна.

Т.Энхтүвшин гишүүний ахалсан ажлын хэсэг хэд хэдэн сайн зүйлийг оруулж ирсэн харагдаж байна лээ.

■ *Хадгаламжийн сертификатыг арилжихтай холбоотой зохицуулалтыг оруулж ирсэн байна.*

■ *Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын бондыг арилжихтай холбоотой зохицуулалт, үүд хаалгыг нээсэн өөрчлөлтүүдийг оруулж иржээ.*

Бас давгүй. Тэгэхдээ хоёр, гурван асуулт ялангуяа энэ Санхүүгийн зохицуулах хорооноос асуучихмаар байна.

Нэгдүгээрт, энэ 1072 хувьцааг одоо бид ард иргэдэд бүгдийг нь тараагаад өгчихсөн.

Тэгээд “олон нийтийн компани” гэж ойлгогдоод байгаа.

Сая бид нар энэ 1072 хувьцаатай холбоотой ердийн хувьцаа болгочихсон Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлаад гаргачихсан.

Өөрөөр хэлбэл 1072 хувьцааг арилжиж болдог, бэлэглэж болдог, худалдаж болдог, авч болдог. Яг жинхэнэ хувьцааных нь үйл ажиллагаа болгож явуулахад шаардлагатай бүх эрх зүйн зохицуулалт болчихсон гэж ойлгож байгаа. Болчихсон гэж ойлгож байгаа.

Энэ ажил яагаад хийгдэхгүй байгаа вэ?

Хувьцааны ногдол ашгийг нь тарааж байх шиг байна. Энэ долоо хоногт өнгөрсөн оны ногдол ашгийг тарааж байх шиг байна.

Яг энэ бодит жинхэнэ хувьцаа гэдгийг нь бий болгох хууль эрх зүйн зохицуулалт бүрэн хийгдчихсэн байхад хэрэгжих ажил нь яагаад удаашраад байгаа вэ гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт. Энэ койнчдыг ер нь та нар яаж хянаж байгаа вэ? Тийм. Койнчдыг ер нь яаж хянаж байгаа вэ?

Америкийн Нэгдсэн Улс, Европын Холбоо бол энэ койны луйвраар асар их хэмжээний мөнгө хийж, хүмүүсийг маш ихээр хохироосон хүмүүсийг хамгийн өндөр дээд зэргийн ял шийтгэлээр шийтгээд л явж байна. Сүүлийн үед.

Манай улсад бас бараг 900 гаруй мянган хүнийг хамарсан энэ койны сүлжээ хууль бусаар арилжиж, дотоодын “insider trading”¹ гэдэг юм даа. Дотоод мэдээллээ

худалдах, ах дүү, найз нөхөддөө өгч “спикуляц” хийж мөнгө хийх, луйвардах ажлууд нэлээн хийгдсэн гэж мэдээллээс ойлгож байгаа.

Тэгэхээр энэ дээр танайх ер нь ямар хяналт тавьж байгаа вэ? Ямар санхүүгийн болон хууль эрх зүйн хариуцлага, зохицуулалтууд хийгдэх шаардлагатай байгаа вэ?

Ийм хоёр асуулт байна.

Г.Занданшатар: 4 номер. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан хариулна.

Д.Баярсайхан: Г.Дамдинням гишүүний асуултад хариулъя.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьд хаалттай хэлбэртэй ийм хувьцаат компани байгаа юм.

Ер нь төгс утгаараа “олон нийтийн компани” болох бүрэн боломжтой.

Ингэхдээ мэдээж хувьцаагаа чөлөөтэй зах зээл дээр арилжих хэрэгтэй байгаа юм.

Тэгэхээрээ дотоодын зах зээлийн стратегийн хөрөнгө оруулагчид, магадгүй олон улсад “давхар бүртгэл” хэлбэрээр гарвал илүү ч үр дүнтэй байж магадгүй гэж бодож байгаа.

Зөвхөн “Эрдэнэс Тавантолгой” ч биш, уул уурхайн болон бусад компаниудыг Cross-Listing, Dual-Listing гээд хийх, хийлгүүлэх энэ хүрээнд ялангуяа хөрөнгийн зах зээл өндөр идэвхжилттэй, эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй 2011, 2012 оны эхэнд манай дотоодын зах зээлийн бараг нийт арилжааны 80-аас дээш

¹ Insider trading гэдэг нь компанийн талаарх нууц, олон нийтэд мэдээлээгүй мэдээллийг олж авах боломжтой хүмүүс компанийн үнэт

цаасыг арилжаалах, энэхүү давуу эрхийг ашиглах нь тухайн хүний итгэмжлэх үүргээ зөрчсөн гэж үздэг.

хувь нь гаднын аж ахуйн нэгж, иргэд байсан.

Одоо бол дан тоонд орчихсон байгаад байгаа.

Тэгээд үүнийг буцааж сэргээх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо бусад улсуудын зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулаад, дээрээс нь үүний дараа өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага бирж хооронд тохиролцдог.

Тэгээд энэ хүрээндээ “давхар бүртгэл”-ийн ажлуудыг хийлгэхэд нэлээн анхаарал тавьж ажиллаж байгаа.

Дэд бүтэц болон бусад хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд бүхий л талаараа бас боломжтой гэж үзэж байгаа.

Ер нь энэ чиглэлд явах нь зөв гэж үзэж байгаа. Хорооны хувьд. Тийм.

Дээрээс нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдтэйгээ яаж ажиллаж байгаа вэ гэж асууж байна.

2021 онд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэж зохицуулахаар болсон. Энэ хүрээнд нийт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч буюу эксченжүүд, биржүүдийг хороо бүртгэсэн. 12 биржийг бүртгэсэн.

Бирж бол өөр дээрээ арилжаалах тэр койн, токеныг тодорхой шаардлагууд тавиад бирж дээрээ бүртгэгдсэн.

Үүнээс хойш харьцангуй юу гэдэг юм байгаа юм бүртгэлд орсонтой холбоотойгоор тодорхой бид мэдээлэлтэй, статистиктай, хорооноос тавих шалгууртай болсон.

Өмнө нь ямар нэгэн зохицуулалтгүй байсан учраас бас олон нийтийг хохироосон асуудлууд гарсан.

Үүнтэй холбоотойгоор хороо хууль хяналтын байгууллагуудтай бүхий л түвшинд хамтарч ажиллаж байгаа. Хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд.

Ер нь аливаа ийм цахим луйвар, **понзи схем**² /ponzi scheme/ байдаг. Олон улсад байдаг.

Энэ хүрээнд хорооны зүгээс одоо бүхий л төрийн ялангуяа тэр дотоод мэдээллийг урвуулан ашигладаг. Тийм ээ.

“Спекуляц” хийдэг, тодорхой хугацаанд ашиг олдог гээд энэ ажиллагаанууд хийгдсэн нөхцөлд тодорхой хууль хяналтын байгууллагуудаар шалгагдаад одоо шүүхийн шатад очсон байгаа гэсэн мэдээлэлтэй байгаа.

Хороо бол яг мэргэжлийн зүгээс хууль хүчний байгууллагуудад бас шинжээчийн дүгнэлт өгөх бүхий л хэлбэрээр хамтарч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд энэ бол нэг удаагийн үйл ажиллагаа биш.

Маш олон ийм санхүүгийн бусад луйвар, ийм залилангийн үйл ажиллагаа байнга л хийгддэг.

Үүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд маш олон давтамжтайгаар байнгын иргэдийн урьдчилан сэргийлэх, санхүүгийн боловсролыг сайжруулах талаар бүхий л бодлогын байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа.

² **Понзи схем** гэдэг нь хөрөнгө оруулагчдад бага эсвэл огт эрсдэлгүйгээр их хэмжээний өгөөж амласан хөрөнгө оруулалтын луйврын нэг хэлбэр.

Энэ хүрээнд ялангуяа цахим хэлбэрээр залуучуудад хүрэх энэ контентуудыг бэлдээд бүхий л хэлбэрээр байнгын давтамжтай ажиллах шаардлагатай юм билээ.

Энэ хүрээндээ ч гэсэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй хоёр санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналуудыг дэмжсэн болон дэмжээгүй гурав хүртэл гишүүн үг хэлж болно. Дэмжсэн, дэмжээгүйгээр.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.34-4.1.39 дэх заалтын дугаарыг “4.1.35-4.1.40” гэж өөрчлөх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Үг хэлэх хүн бий юу? Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх хүн байна уу?

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх хүн алга байна.

Тэгвэл санал хураалт явуулна.

Байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

25 гишүүн дэмжиж, 56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 19 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.8 дахь хэсгийн “задруулахыг” гэснийг хасах.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

23 гишүүн дэмжиж, 52.3 хувийн саналаар санал дэмжигдсэн.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хороо бас хуралдаад байгаа.

Дараагийн асуудалд орно.

Дараагийн асуудалд орохын өмнө энэ Эдийн засгийн байнгын хороо дуусаагүй байгаа учраас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Эдийн засгийн байнгын хорооны хурал дуусаагүй байгаатай холбогдоод хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулаад Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өчигдөр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороогоор хэлэлцээд, хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, чуулганы нэгдсэн хуралдаан руу оруулахаар шийдсэн.

Тийм учраас бэлэн байгаа энэ асуудлаа хэлэлцэж өгөхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Н.Ганибал гишүүн горимын санал гаргаад одоо хэлэлцье гэж байна.

Таны бас мал аж ахуйтай л холбоотой асуудал байна.

Ингээд Байнгын хорооноос гаргасан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргалын гаргасан горимын саналыг

дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэлэлцүүлэг Эдийн засгийн байнгын хороон дээр дуусаагүй байгаа учраас одоо хэлэлцэх боломжгүй байна.

Засгийн газраас нэн яаралтайгаар өргөн мэдүүлсэн юм билээ.

Ингээд Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг өнөөдөр хэлэлцэх асуудлын дараалалд оруулж хэлэлцье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Ингээд 30 минут завсарлалаа. Эдийн засгийн байнгын хороо Үндэсний баялгийн сангийн хуулийг хэлэлцэж дуустал завсарлалаа. /алх цохив/

ЗАВСАРЛАГА

Улсын Их Хурлын Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын хаврын чуулганы 04 дүгээр сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаан үргэлжилж байна.

Одоо чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд чуулганы танхимд, ажлын хэсэг, сайд, холбогдох хүмүүсийг дуудъя.

Эдийн засгийн байнгын хороогоор өглөө хэлэлцэж, хэлэлцэх эсэх асуудлыг дэмжсэн.

Д.Амарбаясгалан дарга. Ажлын хэсгээ оруулаарай.

Хэлэлцэх асуудалдаа орно.

**Хоёр. Үндэсний баялгийн сангийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль,
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**
*/Засгийн газар 2024.04.03-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/*

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Гишүүд суудалдаа сууцгаая.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна.

Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монголчууд аа,

Монгол Улсын Их Хурлын дарга,

Эрхэм гишүүд ээ,

Өнгөрсөн 30 жилийн оноо, алдааг дүгнэж засаж, **“Шинэ 30 жил”**-ийг нийгмийн уур амьсгал, тогтолцооны хувьд эхлүүлэхийг Засгийн газар бүх талаар хичээж авлигатай нам харгалзахгүй тэмцэж, улс төрийн намууд, хууль хяналтын байгууллага, шүүх хүртэл тархан байршиж улс дамнан хүчирхэгжсэн бүлэглэлтэй эрх ашгийн хувьд тулсаар өнөөдрийг хүрч байна.

Энэхүү тэгш бус хязгааргүй их баялаг тэдэнд үйлчилдэг бүлэглэлийн өмнө Монгол төр ард түмэнтэйгээ олон жил сааралтан хүчгүйдсээр ирсэн нь гашуун боловч бодит үнэн юм.

Монголчууд бидний итгэмтгий, уйдамхай, өрөвч занг ашиглан

- *баялгийг нь,*
- *газрыг нь,*
- *нийтийн өмчийг нь,*
- *шүүхийг нь,*
- *намыг нь,*
- *төрийг нь* хэдхэн хүн өмчлөн

авч, аалзны шүлс мэт хэрсэн авлигын систем хэрхэн үүсгэснийг одоо л нийгэм дүгнэж эхэлж байна.

Гэхдээ энэ бол мөсөн уулын дөнгөж оройн хэсэг нь юм.

Баялаг тойрсон луйврын олон нийтийн мэдэх хэсэг нь л Эрдэнэтийн 49 хувь “Монголросцветмет”, “Дархан төмөрлөг” болон түүний харьяа стратегийн ордууд, Оюу Толгойн Дубайн гэрээ ба 34 хувьд ногдох 2.3 тэрбум ам.долларын асуудал, “Тавантолгой” компанийг 100 жилээр худалдахыг завдсан хэлцэл зэрэг байсан билээ.

Эрдэнэтийн 49 хувийн луйвар таслан зогсоогдсоноор улсад төвлөрүүлж байсан жилд дунджаар 962.0 тэрбум төгрөг өнөөдөр 2 их наяд төгрөг болно гэдэг, мөн цар тахлын үед дулаан цахилгаан төлөх хэмжээнд орлого давна гэдэг бүлэглэлд ямар их хэмжээний бүртгэлгүй мөнгө эргэж байсны энгийн нэг нотолгоо юм.

“Эрдэнэс Тавантолгой” компани ил тод болж, засаглал сайжирснаар 2023 онд 9.6 их наяд төгрөгийн орлого олж, 3.5 их

наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллан, 2022 оны цэвэр ашгаас 1072 хувьцаатай иргэнд 104 мянган төгрөгийн ногдол ашиг олгосон бол энэ долоо хоногт 2023 оны цэвэр ашиг 1072 хувьцаатай иргэнд 256 мянган төгрөг олгогдохоор болсныг “Тавантолгой” компани мэдээлсэн.

Улсын төсвийн орлого ч анх удаа 4.6 их наяд төгрөгөөр даван биелж, энэ нь төрийн албан хаагчдын цалин, ахмадын тэтгэвэр, мөн нийслэлийн цэцэрлэгийн хүртээмж болж иргэдийн гар дээр очсон.

Мөн валютын нөөц 5 тэрбум ам.доллар болж даваа гэдэг бол ямар их хэмжээний далд эдийн засаг нуугдаж байсны бас нэг жишээ юм.

Оюу Толгойн 34 хувьд ногдох өр тэглэгдээгүй бол бид өнөөдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэлэлцэх тухай биш харин ирээдүйд үүсэх 22 тэрбум ам.долларын өрийн тухай л ярилцах байлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд “байгалийн баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” хэмээн хуульчилсан боловч нийт “**стратегийн 16 орд**”-ын зөвхөн 7 нь “**Эрдэнэс Монгол**”-ын харьяанд байна.

Мөн стратегийн нөөцөд бүртгүүлэхгүйн тулд нөөцийн суурь мэдээллийг нь өөрчилсөн, АМНАТ татвараас зайлсхийхийн тулд хуваан эзэмшсэн зэрэг их хэмжээний баялаг бүртгэлгүйгээр далд эдийн засгийг бүрдүүлэн өнөөдрийг хүртэл оршиж байна.

Энэ талаар Улсын Их Хурал удахгүй болох нийтийн сонсголоор олон нийтэд ил тод болгоно гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэ үйл явц мөн л нийгмийг нэлээнгүй бухимдуулах нь ойлгомжтой.

Гэхдээ 30 жилийг зөвөөр дүгнэж, “Шинэ 30 жил”-ийг зөвөөр эхлүүлэхийн тулд иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагууд зайлшгүй энэ мэдээллийг мэдэх ёстой гэж үзэж байна.

Энэ талаар шаардлагатай бүх мэдээллийг Засгийн газар гаргаж өгсөн байгаа.

Өнгөрсөн хугацаанд энэ бүлэглэлтэй мөргөлдсөн улс төрчид, нийгмийн зүтгэлтнүүд учир битүүлгээр амь насаа алдаж, эсвэл улс төрийн тавцангаас шахагдан зайлуулсаар ирснийг түүх нотолно.

“Ордон дотор хүч мөхөсдвөл олон нийтийн дэмжлэг авч тэмцлээ үргэлжлүүлнэ” гэж миний бие Ерөнхий сайдаар томилогдсоныхоо дараа хэлж байсныг Та бүхэн санаж байгаа байх.

“**МАНАН**” хэмээн томъёологдсон энэхүү **системийг задлахын төлөө хатуу зогссон** сүүлийн Засгийн газар ч байж магадгүй гэдгийг би нэрэлэхгүйгээр, бас үнэнээр нь хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Шүүхийн шатад бүлэглэлийг нь томилсон шүүгчдийн өмнө шударга ёсны тэмцэл хүч мөхөстөж байгааг ч бас нуугаад яах вэ.

Монгол Улсын язгуур эрх ашгийн төлөө зарчмын шийдэл гаргах Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн батлагдах явц ч хялбар биш байхгүй нь ойлгомжтой.

Ард түмэн Та бүхнийг анхаарлаа энэ хуулийн төсөлд нарийвчлан хандуулж, хэн нь хаана байгааг нарийвчлан дүгнэхийг энэ

хэлэлцүүлгийн үеэр бас харахыг хүсэж байна.

Энэ хууль батлагдахад Ерөнхий сайдад олон нийтийн дэмжлэг одоо л хэрэгтэй байгааг Улсын Их Хурлын гишүүд Та бүхнийг нам харгалзалгүйгээр суурь зарчим дээр нэгдэхийг, мөн ард түмнээ энэ асуудлыг сайтар анхаарахыг Ерөнхий сайдын хувьд хичээнгүйлэн хүсэж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас өргөн барьж буй Үндэсний баялгийн сангийн тухай хууль бол Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн дэвшүүлсэн **“Монгол хүн баялагтаа эзэн”** байх **тогтолцооны реформын “эхлэл цэг”** бөгөөд улс төрийн намуудын түвшинд олон жил яригдсан салангид хуулийн төслүүдийн уулзах ойлголцлын цэг болж чадна гэдэгт итгэж байна.

Үзэл бодлын зөрүүтэй ч гэсэн энэхүү суурь зарчимд нэгдэхээ илэрхийлсэн Ардчилсан нам болон Ардчилсан намын дарга Л.Гантөмөр, ХҮН нам болон ХҮН намын дарга Т.Доржханд нарт талархаж байгаагаа илэрхийлье.

Үндэсний баялгийн сан нь:

- **“Ирээдүйн өв сан”**,
- **“Хөгжлийн сан”**,
- **“Хуримтлалын сан”**-гаас

бүрдэх бөгөөд сангийн хөрөнгийг арвижуулах, хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх, ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллах **“Норвегийн баялгийн сан”**-гийн загвар болон баялгийн үр өгөөжийг нийгмийн чухал зүйлд зарцуулах **“Сингапурын**

хуримтлалын сан”-гийн жишиг загварт тулгуурлан боловсруулагдсан.

“Ирээдүйн өв сан”-д ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс “Төсвийн тогтворжуулалтын сан” болон “Бүс ба орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-д хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувиас бүрдэх бөгөөд олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар өнөөгийн үнэ цэнийг өсгөх, арвижуулах менежмент хийх нэгдсэн удирдлагаар хангах боломжийг энэхүү хуулийн хүрээнд нээж байгаа болно.

Хуримтлалын сан нь “Эрдэнэс Монгол”-ын эзэмшлийн стратегийн 34 хувь. Тодотгож хэлбэл “Эрдэнэт үйлдвэр”, “Оюу Толгой” зэрэг цаашид мөн ашиглагдах стратегийн ордуудын ашиг Монголбанканд иргэдийн нэрийн дансанд шууд төвлөрч, иргэдийн орон сууцжуулалт, боловсрол, эрүүл мэндэд зарцуулагдахаар энэхүү хуулийн төсөлд тусгагдсан.

Энэ нь уул уурхайн баялгийг зөв өгөөжтэй ашиглах тусам иргэдийн хуримтлал арвижих, хүний хөгжил, нийгмийн тогтвортой байдлын цөм болсон дундаж давхаргыг бүрдүүлэх суурь асуудал болсон үндэсний орон сууцжуулалт, боловсрол, эрүүл мэндийн бодлогын цогц томоохон реформ болох асуудалд стратегийн ордуудаа иргэд өөрсдөө хянан, захиран зарцуулах эрх нээгдэж байна гэсэн үг юм.

Мөн стратегийн ордуудын хяналт, ил тод байдалд бүлэглэлийн эрх ашгаас хамгаалагдах байдалд олон нийтийн хяналт өндөрсөнө гэдэгт итгэлтэй байна.

Олон нийтийн хяналт өндөрлөснөөр уул уурхайн салбар ч байгаль орчинд ээлтэй, илүү өндөр технологид тулгуурласан, илүү цахимжсан, нээлттэй байх уул уурхайн салбарын шинэ бодлогыг

тодорхойлоход туйлын чухал гэж үзэж байна.

Мөн “Хөгжлийн сан”-д нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байснаас нэмэгдэж орох орлогын 50 хувиас бүрдэхээр энэ хуульд хуульчиллаа.

“Хөгжлийн сан” нь Монгол улсын нийгмийн хөгжилд тулгамдаж буй томоохон төслүүдийг санхүүжүүлэх үндсэн зорилготой бөгөөд нийслэлийн метро, гүүрэн байгууламж, шинэ хотууд, орон нутгийн хурдны зам зэрэг улсын төсвөөс шууд санхүүжүүлэхэд хүндрэлтэй томоохон төслүүдийн үржүүлэхийн хүрдийн үүргийг гүйцэтгэнэ гэсэн үг юм.

Үндэсний Баялгийн Сангийн хууль хэрэгжих, арвижих суурь зарчим нь уул уурхайн баялгийн ил тод, шударга ёсны зарчимд суурилах нь ойлгомжтой билээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Баялаг бүтээх, баялаг ашиглах гэдэг бол олон улсын жишигт тэнгэр газар мэт зөрүүтэй ойлголт байдаг.

Байгалийн баялаг бол хүний гараар бүтээгдээгүй, дахин хэзээ ч сэргээгдэхгүй, олон сая жилийн хугацаанд бий болсон газрын хэвлийд орших ард түмэн, бүх нийтээрээ үр өгөөжийг нь хүртэх учиртай баялаг юм.

Аль ч улсын дахин сэргээгдэхгүй баялгийг ашиглагч нар тухайн ард түмэндээ туйлын хүндэтгэлтэй хандах нийгмийн хариуцлагатай байдаг нь олон улсын нийтлэг ёс зүйн хэм хэмжээ юм.

Үндэсний баялгийн сангийн хууль хэрэгжихэд стратегийн ордын тусгай

зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь заавал нээлттэй хувьцаат компани байх, нийт хувьцааны 20-иос дээш хувийг аливаа этгээд дангаар болон харилцан хамаарал бүхий этгээдээр дамжин эзэмшихгүй байх, өв залгамжлал болон бэлэглэлээр шилжүүлсний орлогод 30 хувийн татвар ногдуулах эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

Зарим газар энэ хувь нь 80 хувь байдгийг Та бүхэн мэдэж байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Улс төрч сонгууль боддог бол төрийн зүтгэлтэн ирээдүйн шинэ үеийг боддог” гэдэг үг бий.

Сонгууль дөхсөн байгааг ойлгож байгаа ч тангараг өргөсөн нийтийн эрх ашгийг төлөөлж буй төрийн түшээдийн хувьд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа Монгол Улсын язгуур эрх ашиг, нийтлэг ирээдүйг харж чадна гэдэгт итгэлтэй байна.

Г.Занданшатар: Одоо төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 04 сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн улсын төсөвт төвлөрсөн орлогыг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрт тэгш шударга хүртээх зорилгоор үндэсний баялгийн санг байгуулах, түүний төрөл, зориулалт, зарцуулалт, эх үүсвэрийг тодорхойлох, сангийн хөрөнгийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хууль, тогтоолын төслүүдийг дэмжиж Улсын Их Хурлын хаврын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн Ирээдүй өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүй өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Дашзэгвийн Амарбаясгалан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Батмөнхийн Агиймаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн, Ганхуягийн Давааням Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлье.

Д.Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн тэргүүлсэн Засгийн газар бидний хамгийн анх авч хэрэгжүүлсэн том арга хэмжээ бол энэ нүүрс тойрсон далд эдийн засгийг ил болгох, нүүрс тойрсон авлига, хулгай, дийлдэхгүй байгаа энэ бул хар чулууг хөдөлгөх, зайлуулах, задлах ийм том ажил байсан.

Энэ Тавантолгойтой холбоотой асуудал. Тэрийг Та бүхэн маань мэдэж байгаа.

Бидний нэг хэсэг юмнууд энэ 2008 оноос хойш Оюу Толгойн энэ том орд, дэлхийн хэмжээний аварга орд шүү дээ. Эрдэнэтээс 6 дахин том гээд л Та бүхэн минь бод.

Энэ том ордын Хөрөнгө оруулалтын гэрээ бол Монголын талд ашиггүй ээ. Энэ эцэст нь өрөнд ороод үлдэх нь ээ гэж С.Авирмэд, Ч.Хурц гуай, Т.Балжинням гуай, олон мэргэжлийн хүмүүстэй хамт одоо энэ Их Хурал дээр асуудлыг тавьсан.

Тэгээд үнэхээр одоо бидэнд дийлдээгүй.

Ингээд гэрээг хийсэн.

Бид тэмцэл хийж байж, цөөхөн боловч нам харгалзахгүй тэмцэж байж 57 дугаар тогтоол гэж зарчмын ач холбогдолтой ийм тогтоолыг батлуулсан.

Энэ арван хэдэн жилийн хугацаанд үе үеийн парламент бидний цуцалтгүй тэмцлийн үр дүнд олон түр хороо, ажлын хэсэг Ерөнхий сайдуудад асуулга тавьж бүхий л хүрээнд бид ажиллаж байсан.

Ингээд 2020 онд байгуулагдсан Улсын Их Хурал дээр санаачилга гаргаж шаардаж байж Ц.Даваасүрэнгээр ахлуулсан түр хороо. Оюу Толгойн. Зөвхөн Оюу Толгойн асуудлаар түр хороо байгуулагдаж, тэгээд У.Хүрэлсүх, Л.Оюун-Эрдэнэ хоёрын тэргүүлсэн Засгийн газрын үед энэ хамгийн анхны алхам хийх ийм бололцоо нөхцөл бүрдсэн.

2021 оны 12 сарын 30-нд Их Хурал 103 дугаар тогтоолыг баталсан.

Би боддог юм. Энэ Тавантолгойг тухайлах юм бол 2012-2016 онд, 2015 онд тухайлах юм бол Хятадын компанид 100 хувь өгөх Их Хурлын тогтоолын төсөл оруулж ирсэн шүү дээ.

Тэгээд тэр үед Их Хурлын гишүүд санал нэгдэж байж арай гэж авч үлдсэн.

Тэгээд өнөөдөр одоо жишээлбэл Оюу Толгойгоо тэр чигээр нь тавиад туучихсан. Ямар нэгэн байдлаар үүнийг сайжруулах чиглэлийн алхмыг хийгээгүй.

Тавантолгойг тэр чигээр нь тавиад туучихсан бол одоо ер нь бид ямар байх бол оо гэж боддог юм.

Тэгээд баялгийн реформын энэ том ажил явж байгаа. Тэгэхдээ бид стратегийн ач холбогдол бүхий ордод авахаар том ордуудыг, 2012-2016 онд энд зүгээр хавтсанд хийгээд Их Хурлын тогтоол гаргаад аваад гарч байсан ийм ордууд бий шүү.

Стратегийн 16 ордод эргэж авахаар том том ордууд байгаа шүү. Хөшөөтөөс өгсүүлээд хаана ямар байдалтай байна аа?

Оюу Толгойн Дубай-2-ыг хийх, дахиж зээлийн хавханд аваачиж хийхээр

байсан асуудлыг тэр 103 дугаар тогтоолоор бид хааж өгсөн.

Өнөөдөр Монгол Улсын 33.6 тэрбум доллар дотор аж ахуйн нэгжийн тавьсан 21.8 тэрбум долларын өр бий.

Энэ дотор яг хэдэн тэрбум долларын өрийг Монголчуудыг өрөнд тавьчихаад энэ Оюу Толгой, Рио Тинто байж байна? Энэ цаашаа ахихгүй биз дээ.

Одоо явагдаж байгаа мэдээллээр энэ цаашаа ахиад байна гэдэг ийм асуудлууд яригдаад байгаа шүү. Энэ зээлийн асуудал. Энэ дээр одоо тодорхой хариулт өгөөч ээ.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна. Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад.

Л.Оюун-Эрдэнэ: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Манайх стратегийн ордод оруулсан. Надад өгч байгаа мэдээллээр 16, зарим ордтойгоо нийлээд 20 орчим орд байдаг.

Энэ дотор Асгатын мөнгөний ордоос эхлээд, Шивээ-Овоогоос эхлээд, бидний мэддэг Тавантолгой, Эрдэнэт, Төмөртэй гээд.

Энэ бол ингээд “Эрдэнэс Монгол”-ын харьяанд байж байгаа.

Стратегийн ордоос гаргаад авчихсан ордууд бас бий.

Улсын Их Хурал батлаад, цэц шийдвэр гаргаад авчихсан Нарийнсухайт, Цагаансуварга, мөн бусад Төмөртэй, Мардай, Бороогоулд, Бүрэнхаан гээд олон ордууд байдаг.

Энэ дээр би бас парламентын гишүүдээ уриалж байгаа нэг зүйл байгаа.

Ер нь бид дүгнэлт хийхгүй бол болохгүй гэж би их олон удаа ярьж байгаа.

Тэгэхээр Их Хурлын гишүүдийн хувьд ч гэсэн энэ мэдээлэл маш зөрүүтэй байдаг.

Засгийн газрын гишүүдийн хувьд ч гэсэн маш их тийм зөрүүтэй байдаг. Энэ ингээд хэдхэн мэдээлэлтэй хүн буюу зарим шүүгч нар, зарим цэцийн гишүүд гэдэг ийм агуулгаар ингээд явчихдаг. Хууль хяналтын байгууллагууд оролцоод.

Нэгдүгээрт, “стратегийн ордыг стратегийн орд биш” гэж дүгнэсэн ордууд байгаа.

Энэ асуудал зайлшгүй хөндөгдөх ёстой. Монгол Улсад төр гэж байдаг юм бол.

Дээрээс нь стратегийн ордуудыг хуваагаад авчихсан газрууд байгаа. Жишээлбэл, 5 юм уу, 7 хуваагаад нөөцүүдийг нь өөр байдлаар гаргаад өгчихсөн ийм ордууд байна.

Би сая илтгэлд дурдлаа. Зөвхөн Эрдэнэтийн асуудал, зөвхөн Тавантолгой дээр улсын төсөв 6 их наядаар давж биелээд, төлбөрийн тэнцэл ашигтай гараад, жил бүхэн дотоодын нийт бүтээгдэхүүн нэг хүнд ногдох нь мянган доллароор ахиж байгаа шүү дээ.

Энэ юу вэ гэхээр ерөөсөө “бүртгэлгүй маш их хэмжээний баялаг” байна аа л гэсэн үг.

Тэгэхээр үүнийг л одоо бид авлигалтай хийх тэмцэл, шинэ сэргэлтийн бодлогын цахим реформ ч гэсэн үүний л төлөө байсан.

Энэ нь ингээд эхнээсээ мэдрэгдэж эхэлж байгаа байх гэж бодож байна. Энэ ямар систем, хаана угсрагдсан, юу болсон бэ гэдгийг Монголын ард түмэн илүү мэдэж байгаа болов уу гэж бодож байна.

Тэгээд би Их Хурал дээр эрдэс баялгийн талаар сонсгол хийгдэх ёстой.

“Өнгөрсөн хугацаанд лицензүүд хэн хэнд хэрхэн очсон бэ” гэдэг энэ зүйл зайлшгүй нийгэмд.../минут дуусав/

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр бодитой юмыг бодитойгоор л хэлэх ёстой л доо.

2016 оноос 2020 он, 2020 оноос 2024 оны парламент Засгийн газар үнэхээр баялагтаа эзэн байх баялгийн реформыг хийж чадсан.

Би юу хэлэх гэж байгаа юм гэхээр зэрэг бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 2019 оны 11 сарын 14-нд батлагдсан өөрчлөлтөөр тэр үндсэн хуулийн 6.2-г маш чухал заалтууд оруулсан шүү.

Энэ хэвлийн баялаг төрийн өмч байна гээд заачихсан. Төрийн толгойд гарсан нөхдүүд, үе үеийн парламентын нөхдүүд нэрээр нь дурдаж чадна шүү.

Бид хар толгойгоороо хариуцна гэж. Тэрний саарал юм уу, хар толгойгоороо хариуцна гэж ямар байх вэ дээ.

Тэгээд үүнийг нь төрийн нийтийн өмч, нийтийн мэдэх эрхийг нь бид хангасан ийм чухал заалт.

Тэгээд баялгийн сан байгуулж, иргэддээ тэгш хүртээх. Тэгээд дээр нь

стратегийн ордуудын дийлэнхийг үр өгөөжийг ард түмэн хүртээх зарчмын заалтыг оруулж өгсөн.../минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсэг хариулах уу?

Үндсэн хуулийн 6.2-ын талаар. 4 номер. Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Энэ хуулийг боловсруулсан үндэслэл, зарчим бол яг 2019 онд Үндсэн хуульд орсон уул уурхай, эрдэс баялгийн дийлэнх үр ашиг нь ард иргэдэд үр өгөөж нь ногдох үндсэн зарчмыг тулгуурлаж хуулийн төслийг боловсруулсан гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Б.Бат-Эрдэнэ гишүүн товч тодорхой асуулт.

Б.Бат-Эрдэнэ: Энэ байна шүү дээ, 1997 онд М.Энхсайханы Засгийн газрын анх баталсан Ашигт малтмалын хуулиар алга дарам цаасаар Монгол орны газар, хэвлийн баялгийг лиценз хэлбэрээр тараагаад өгчихсөн.

Үүний алдаа завхрал засагдахгүй байна.

Би үүнийг юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр зэрэг улс оронд үр өгөөж багатай, байгаль орчинд хохиролтой, нийгмийн хариуцлагын хүрээнд ямар ч юм хийдэггүй, энд тэндгүй нэг газар сэглэсэн ийм уурхайнуудыг таслан зогсоох чиглэлээр Уул уурхайн яам ямар бодлого барьж байна аа?

Орон нутагт явж байхад тэр Эрдэнэцагааны хар, Уулбаян, бусад олон сумдуудад. Манай Хэнтий аймагт харьцангуй гайгүй. Олон сумдад ийм юмнууд байгаад байна. Үүнийг зогсоохгүйгээр явахгүй.

Томоохон үр өгөөж нь тодорхой стратегийн, үнэхээр ач холбогдолтой юман дээрээ л анхаарал тавихгүй бол тэр чинь байгаль орчныг, уул ус, түүх соёл, тэгээд бэлчээр юу байдаг юм бүх юм нь сөрөг.../минут дуусав/

Г.Занданшатар: Уул уурхайн яам ажлын хэсэг дотор алга байна.

Ажлын хэсгээс асууж байна. Санжаагийн Наранцогт. 3 номер Дашзэвгийн Амарбаясгалан. Засгийн газрын ахлах газрын дарга.

Д.Амарбаясгалан: Уул уурхайн ордуудын талаар сая Ерөнхий сайд мэдээлэл хийж байгаа.

Ялангуяа “стратегийн орд” гэж, “бүлэг орд” гэж яг юу юм бэ гэдэг энэ ойлголтыг л сая Б.Бат-Эрдэнэ гишүүний асуусан асуултад хариулмаар байгаа юм.

Яг бүлэг ордоороо ярих юм бол стратегийн орд байгаад байдаг. Тэр бүлэг ордуудыг олон хэсэг хувааж олгож олон эзэмшигчтэй болгосноороо стратегийн бус орд юм шиг ойлгогдож, хувийн хэвшил 100 хувь хариуцаад явж байгаа ийм байдал байна.

Яг стратегийн ордоороо нэрлэх юм бол 20-иод ордыг нэрлэж болж байгаа юм.

Гэвч өнөөдөр 6-хан орд газар нь стратегийн ордын статустай төрийн эзэмшлийн “Эрдэнэс Монгол”-ын оролцоо, хувьтай хэлбэрээр явж байна. Жишээ нь, Нарийнсухайтын бүлэг орд 7 хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Цагаансуварга.

Цаашлаад ярих юм бол Төмөртэй, Цайртминерал гээд ордууд өөрөө стратегийн ач холбогдолтой мөртлөө тэр

ангилалдаа бүрэн багтаагүй яваад байгаа ийм дүр зурагтай байгаа юм.

Яг ингээд харахаар “Эрдэнэс Монгол”-д үндсэндээ энэ бүлэг ордуудын эзэмшлийн хувь хэмжээ нь 16 орчим хувьтай нөөц нь байгаа. Эзэмшилд нь.

Гэтэл “Эрдэнэс Монгол” эргээд улсын төсөвт төвлөрүүлсэн орлогоороо ярих юм бол 73.0 хувийг нь төвлөрүүлээд байгаа ийм байдал бодитой ажиглагдаж байна.

Тэгэхээр өнөөдөр энэ Баялгийн сангийн хууль өргөн баригдлаа. Цаашлаад стратегийн орд газруудын ач холбогдол нэмэгдлээ. Эргээд төсөвт, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь 60, 70 хувиар нэмэгдэх боломж байна гэдэг талаас нь харж хуулийн төслийг боловсруулсан.

Г.Занданшатар: 1 минут гэж байхгүй. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Өнөөдөр нийгмийн хамгийн тулгамдсан асуудал гэвэл авлига, хулгайн асуудлыг нийтээрээ санал нэгтэй хэлнэ.

Эдийн засгийн хамгийн тулгамдсан асуудал гэвэл ядуурал, амьдралын түвшний доройтол, дээрдэхгүй байгаа байдал гэж бүгдээрээ санал нэгтэй хэлнэ.

Энэ хоёрын огтлолцлын цэг дээр байгаа гол зүйл энэ уул уурхайн өмч, тэр тусмаа уул уурхайн баялаг, байгалийн баялаг, тэр тусмаа дээр байгаа төрийн өмчит компаниудын засаглал яг энэ шударга ёсны асуудал, эдийн засгийн асуудал хоёрын огтлолцлын цэг дээр байгаа асар чухал зүйл.

Тийм учраас Баялгийн сангийн тухай хууль асар чухал гэдэгт эргэлзээгүй.

Ийм ч учраас Ардчилсан намаас, Ардчилсан намын бүлгээс өнгөрсөн 2023 оны төгсгөлөөр энэ хуулийн төслийг бас нэлээн ажиллаж байж өргөн барьсан. Ардчилсан намын дарга бас нам дотроо сайн, муу хэлүүлээд энэ дээр очиж бас байр сууриа илэрхийлж зогссон.

Гэтэл өнөөдөр энэ хууль уг нь хамтдаа нэгтгэгдээд хэлэлцээд явна гэсэн. Жилийн өмнө өргөн барьсан хууль. Цагийн өмнө өргөн барьсан хууль ингээд хэлэлцэгдээд явж байна.

Тэгээд маргааш нөгөөдрөөс хэлэлцэх юм гэнэ.

Тэр хэлэлцэх, хэлэлцэхгүй байх нь хоёрдугаар асуудал. Хоёрдугаар асуудал.

Гол нь энэ хууль дотор яг үнэхээр саяын хэлдэг тэр авлига, хулгайг бууруулах, иргэдээ баян болгох, эдийн засгийн асуудлыг шийдэх зарчмын зүйлсүүд яг орсон уу гэдэг дээр л эргэлзээтэй олон зүйлүүд. Цагийн өмнө аваад харсан хуулийг харахад олон олон зүйлүүд байгаад байна л даа.

Жишээ нь, засаглалын асуудал. Ер нь байгалийн баялаг, төрийн өмчийн удирдлагыг улс төрчдөөс аль болох хараат бус болгох гэдэг өөрөө энэ баялгийн сангийн гол үзэл баримтлал, концепц байх ёстой.

Улс төрчдөөс хараат бус. Дөрвөн жилийн томилгоотой улс төрчдөөс энэ баялгийн асуудлыг яаж тусгаарлах юм. Харьцангуй хараат бус яаж болгох юм гэдэг.

Гэтэл яг одоо орж ирсэн хуулийн төсөл дээр гурван сан байх юм байна. Гурван санг гурван яамны сайд удирдах юм байна.

■ **“Хөгжлийн сан”**-г Хөгжлийн сайд удирдах юм байна.

■ **“Ирээдүйн өв сан”**-г Сангийн сайд удирдах юм байна.

■ **“Хуримтлалын сан”** нэртэй санг халамжийн сан болгох юм байна. Үүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд удирдах юм байна.

Гурван сан байгуулчихсан, 3 сайд удирдчихсан, улс төрийн албан тушаалтан удирдчихсан. Дээд талыг нь зүгээр **“Баялгийн сан”** гээд нэрлэчихсэн.

Ямар нэгэн тийм концепт, үзэл баримтлалын тийм дэвшилтэй олон улсын аль сангуудад тэр Финлянд, Норвеги, Сингапурын сангуудад яамны сайд нэг баялгийн сан гэснийгээ гурав, дөрөв хувааж удирдчихдаг. Дээрээ нэгдсэн удирдлага, зохион байгуулалт байхгүй ийм сан яг хаана байгааг Та бүхэн хэлж өгөөч.

Монгол Улсад тэр элдэв сан. Тусгай сангийн хуулиар 25 сан ч билүү байдаг. 27, 28, 29 дэх сангийн тухай яриа шиг энд ингээд ийм зүйл явж байна.

Тэгэхээр “Хуримтлалын сан” гэдэг гоё нэртэй сан нь явсаар явсаар байгаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хүрээнд тэр барилга барих, боловсрол, эрүүл мэнд гэдэг зүйлд зарцуулагдана гэж байна.

Уг нь тэр чинь тусдаа бизнесийн эрх зүйн харилцаагаараа явдаг зүйл рүү одоо энэ сангаасаа халамжийн байдлаар эдийн засгийнхаа системийг эвдэж ийм зүйлүүд энэ дээр хийгдэхээр болж байна уу?

Ингээд олон олон зүйлүүд үүний цаана байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн шинэчлэлийн асуудал, нээлттэй болох асуудал.

Эндээс цаг бага байгаа учраас би бас товчлоод хэлье.

Ардчилсан намаас өргөн барьсан хуулиуд дээр энэ бүгд дээр үзэл баримтлалын асар олон зүйлүүдийг:

- давуу эрхийн хувьцаа;
- нээлттэй байх;
- ногдол ашиг;
- портфелийг хэрхэн удирдах, олон улсын мэргэжлийн компаниар яаж удирдуулах гэдэг.

Хөрөнгийн удирдлагын менежментийн компаниар удирдуулах зэрэг олон олон зүйл байсан нь энд ямар ч тийм зарчмын өөрчлөлттэй зүйл энд үнэхээр алга.

Хэдэн яамны сайдад хэдэн сангийн тэргүүн нь зарцуулах эрхийг нь өгчих юм байна. Нэг ийм л зүйл болж хувирч байна.

Үндсэндээ ийм чухал асуудлыг, асар чухал асуудлыг “нүглийн нүдийг гурилаар хуурсан” ийм л бодлогын баримт бичиг орж ирж байна. Үнэхээр.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна. Асуултад.

Л.Оюун-Эрдэнэ: Бид хамтдаа олон удаа ярилцсан.

Тэр ярилцлагын зарим хэсэг дээр О.Цогтгэрэл даргын хувьд тойрогтоо ажилтай гээд оролцоогүй. Танай намын дарга болон бусад удирдлагууд бүгд оролцсон. ХҮН нам оролцсон.

Тухайн үед ярилцсан зарчмаас бид нэг сөөм ч хаашаа ч хазайгаагүй.

Ажлын хэсэг байгуулагдсан. Бараг 10 гаруй удаа хуралдсан. Тэгээд нэгтгэх боломжийн талаар зөндөө л ярилцсан.

Тэгэхээр Ардчилсан намын саналын дагуу энэ төсөл дээр жишээлбэл “Тогтворжуулалтын сан”-тай холбоотой асуудал огт хөндөгдөхгүйгээр орж ирж байгаа.

Мөн зарим хуримтлалын сантай холбоотой асуудал. Бэлэн мөнгөөр биш. Энэ бол зөвхөн орон сууц, боловсрол, эрүүл мэндэд илүү зарцуулагдах нь зүйтэй юм гэдэг энэ агуулгаар орж ирж байгаа.

Дээрээс нь баялгийн сангууд хоорондоо “нэгдсэн удирдлагатай байх нь зүйтэй юм” гэдэг агуулга руу орж ирж байгаа.

Тэгэхээр яах вэ, би зүгээр уриалж байгаа зүйл нь өмнө нь бид ингээд ярилцаад тохирчихсон зүйлүүд дээрээ чуулганы танхимд орж ирээд өөр яриад баймгүй л байгаа юм.

Одоо Үндсэн хуулиас авхуулаад олон л зүйл дээр ярилцаад л явж байгаа. Ярьчихсан бол яг ярьсандаа л байхгүй бол Ц.Элбэгдорж уурлаагүй байхад нэг өөр, Ц.Элбэгдорж уурласны дараа нэг өөр баймааргүй байна.

Энэ чинь Монгол Улс. Ярьсан бол ярьсандаа, гарын үсэг зурсан бол гарын үсэг зурсандаа л байхгүй бол ингээд нэг ийм солигддог тоглоом шиг байж болохгүй ээ.

Тэгэхээр мэдээж би зарчмын хувьд Ардчилсан нам ч бай, ХҮН нам ч бай, парламентад суудалтай намууд танилцуулгаа хийгээд, ажлын хэсэг дээр хийгдээд явах дээр зөвшилцсөн юм байна гэж ойлгосон.

Тэгээд энэ зарчмын дагуу явж байгаа.

Тэгээд Их Хурлын хэлэлцүүлгийн үед парламентын гишүүд ажлын хэсгээр хангалттай ярилцаж, өөрчлөх зүйлүүд байгаа.

Ганцхан зүйлийг хүсье. Суурь зарчим дээр лоббинд автахгүй хэдүүлээ ард нь гарахгүй бол харин яг таны хэлдгээр энэ бол юу ч биш болно.

Өмнөх хуулиуд яг л тийм байсан. Хэлэлцүүлгийн шатанд орж ирээд яг батлах явцад дандаа лоббинд орж байсан. Түүний нэг жишээ бол энэ “стратегийн ордуудыг стратегийн ордоос биш” болгож гаргаад өгчихсөн. Өөрөө цаана нь гэр бүлээрээ хувь эзэмшээд суучихсан ийм олон ордууд байна.

Үүнийг Улсын Их Хурлын бүрэн эрх учраас Та бүхэн маань эрдэс баялгийнхаа сонсголыг хийгээд энэ бүх зүйлийг иргэд мэдээд хэвлэл мэдээллийнхэн мэдэхээр нийгмийн дүгнэлт аяндаа тогтоно биз дээ гэж бодож байна.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн. Ардчилсан намын бүлгийн дарга тодруул.

О.Цогтгэрэл: Өмнө нь намын даргын оролцсон ажлын хэсэг болоод уулзалтуудад бас орж байсан.

Энэ дээр яригдсан зарчмын зүйлсэд нэгдвэл бид бүгд хамтраад ажиллана гэдэг л байр суурийг тал талдаа илэрхийлж л явж байсан.

Сая та тэр “Тогтворжуулалтын сан” гэж байна. Яг “Тогтворжуулалтын сан” гэхэд энэ баялгийн сан дотроо байхгүй. Гаднаа байгаа юм байна. “Тогтворжуулалтын сан”-гаасаа тэр

“Хуримтлалын сан” гэдэг сан руугаа мөнгө татах юм байна буюу уг нь бол энэ байгалийн баялгийн тэр нэг эрсдэл, савлагааг давах ёстой “Тогтворжуулалтын сан”-гаа бүр аль нь ч биш болгоод, энэ бол халамжийн сангийн нэг хэсэг болохоор л яг хуулийн концептод тусчихсан л явж байна.

Дахиад хамгийн гол зүйл нь энэ **“Баялгийн сан”** гэж байгаа чинь өмнө нь үндсэндээ төрийн дансан дахь нэг ийм данс байсан бол уг нь үүнийг амилуулж, менежменттэй, үндэсний баялаг маань өсдөг, үрждэг, арвиждаг, портфелтой, эрсдэлээ хардаг зүйл байтал одоо энэ дээр чинь ямарваа нэгэн тийм зүйл алга байна шүү дээ.

Г.Занданшатар: Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Үгүй ээ. Харин тийм. Тийм учраас л яг үүнийг яриад.

Тийм учраас Ардчилсан намын саналын дагуу л яг “Тогтворжуулалтын сан”, мөн “Хөгжлийн сан” хоёрыг 50, 50 хувьтай байх нь зүйтэй юм гэдэг дээр л тогтсон юм шүү дээ.

Та намынхаа удирдлагуудаас лавла л даа.

Тэгээд би таныг хуралд оролцоогүй асуудал дээр би чуулганы танхимд хариулах үүрэг хүлээмээргүй байна шүү дээ.

Г.Занданшатар: Ер нь О.Цогтгэрэл гишүүний санаачилсан хуулийн төслийг хэлэлцүүлэхгүй байсан зүйл байхгүй.

Гурван нам тохиролцоод, гарын үсэг зураад, нэгдсэн хуулийн төслөө өргөөд явж байгаа учраас энэ хуулийн төслөө хэлэлцээд явна гэж тохирсон.

Тийм санал өмнө нь дэвшүүлж ярилцаагүй. Ярьж хэлэлцэнэ л гэж ойлгосон.

Тэрийг бид мэдэхгүй. Албан ёсоор энэ чинь олон түмэнд зарлачихсан асуудал.

Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

Өнөөдөр 04 дүгээр сарын 04-ний өдөр. Ханш нээх энэ билигт сайн өдөр бас Баялгийн сангийн тухай хууль орж ирж байгаад талархал илэрхийлье.

Олон нийтийн хүсэн хүлээсэн хууль гэвэл мөн. Олон нийт юу хүсэж байна вэ гэвэл нэгэнт Монгол Улс газрын доорх энэ их эрдэс баялгаа ард түмэндээ тэгш хуваарилах, бид бас Монгол Улсын эзэн нь учраас энэ сангаас, энэ их ашигт малтмалын ашиг орлогоос бид хүртэх ёстой гэдэг зүйлийг биднээс байнга нэхэж байдаг.

Тэгэхээр энэ одоо хууль хэлэлцэгдэх гэж байна.

Сая Ерөнхий сайд хэлсэн үгэндээ хэллээ л дээ. Энэ Засгийн газар авлига, хээл хахуультай тэмцсэн бараг л сүүлчийн Засгийн газар байх болов уу гэж.

Би анхдагч нь байгаасай гэж хүсэж байна.

Үндсэн хуульдаа бид өөрчлөлт оруулаад олон намын тогтолцоотой парламентыг бий болгох Үндсэн хуулиа баталсан байгаа. Энэ олон намын тогтолцоо бүгдээрээ энэ нийгмийн хор уршиг болсон авлига, хээл хахуультай

тэмцсэн хамтарсан парламент, хамтарсан засаг байгаасай гэж хүсэж байна.

Мөн энэ Үндсэн хуульд оруулсан байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс бүрдүүлсэн Үндэсний баялгийн сан бий болгосноор Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт бодитоор бүрдэнэ гээд.

Үнэхээр бид Монгол Улсын иргэн л юм бол энэ газрын доорх баялгаа бүгд тэгш хүртэх эрхтэй.

Би зүгээр үр дүнг асууж байна. Асуумаар байгаа юм.

Бид аливаа ажлыг Улсын Их Хурал, Засгийн газар хаа хаанаа хийж байгаа боловч бид хариуцлага тооцох тэр чадамж нь үнэхээр хангалтгүй байгааг олон нийт нэхсээр байгаа.

Оюу Толгойн түр хороонд орж ажилласан л даа.

Оюу Толгойн түр хороо Монголын баялгийг хэрхэн яаж гаднынханд бэлэглэсэн бэ гэдгийг бид Их Хурал ажиллаад бүхий л мэдээллийг нээлттэй болгож хууль хүчний байгууллагад өгсөн боловч өнөөдөр үнэхээр Монгол Улсын газрын доорх баялгийг хууль бусаар зарцуулаад ингэчихсэн байна гээд хариуцлага тооцсон юм ер нь хэр байгаа вэ гэдэг дээр би хариулт авмаар байна.

Нөгөөтээгүүр Монгол Улс газрын нөөцөө бид нэг судлаад нэгдсэн сан үүсгээд байсан. Тийм ээ. Яг түүнтэй нэгэн адилаар бид газрын доорх баялгаа судалсан судалгаа ер нь хэр байдаг юм бэ?

Яг энэ нөөцийн талаарх мэдээлэл байна уу? Эрдэнэтийг бид хэдэн 100 жил ашиглах нөөцтэй гэдэг энэ зүйлийг ярьдаг

боловч хэдэн жилийн өмнө нөөц нь дуусчихсан л гэж ярьдаг байсан.

Гэтэл яг үнэхээр бодит нөөцийн судалгааг бид хийж чадсан байдаг уу, үгүй юу гэдэг дээр тайлбар өгөөч ээ.

Өнөөдөр энэ лицензийн хэчнээн хувь нь ер нь хугацаатай байдаг юм бэ? Би Ч.Хурц гуайтай ч гэдэг юм уу, С.Авирмэд гуайтай ч юм уу ярилцаж байхад тухайн үед юу яригдаж байсан бэ гэвэл гэрээ байгуулаад хаалтын гэрээ нэг ч байгуулдаггүй хамгийн тод жишээ бол Налайхын уурхай гэж ярьж байсан.

Хаалтын гэрээ хийгдээгүй лиценз эзэмших энэ эрхийн талаар ер нь ямар мэдээлэл бидэнд байна вэ гэдэг зүйлийг хэлж өгөөч ээ гэдэг зүйлийг хүсэх гэсэн юм.

Ер нь баялгийн сангийн эх үүсвэр болохоор орон нутгийн “Хөгжлийн сан”-д хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувийг нь, төрийн эзэмших хувьцаа 34 ба түүнээс дээш бол төрийн эзэмшлийн 34 хувьд ногдох ашгийг нь тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байснаас нэмэгдэж орох төсвийн орлогын 50 хувиас бүрдэнэ гээд тооцсон байна л даа.

Энэ тооцооллын яг маш энгийнээр олон нийтдээ тайлбарлаад өгөөч ээ.

Ер нь тооцоолол нь барагцаагаар хэчнээн хувь гэж гардаг юм бол. Энэ зүйлийг мэдээлэл өгөөч.

Нөгөөтээгүүр иргэд, олон нийт өөрсдөө бид баялгаа эзэмших гэж байгаа юм чинь хяналт тавих тэр тогтолцоог нь энэ хуулиар бид оруулж өгч чадсан уу, үгүй юу?

Одоо **D-Parliament.mn**-д байрласан Баялгийн сангийн тухай хуулиар иргэд маань өөрсдөө мэдээлэл өгөх хэрэгтэй. Тийм ээ. Саналаа өгөх эрхтэй боловч энэ дээр би нэг зүйлийг тодруулах гэсэн юм.

Яг иргэд олон нийтийн хяналт тавих тэр тогтолцоог энэ хуулиараа зүйл, заалтаараа бид оруулж өгч чадсан уу, үгүй юу гэдэг дээр нэг тайлбар аваад тодруулъя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Авлигалтай холбоотой, ялангуяа мэдээлэлтэй холбоотой. Тэгээд

“Цахимжилт”
“e-mongolia”
“шилэн ажиллагаа”

гээд энэ хүрээнд мэдээллийг ил тод болгох нь Засгийн газрын үндсэн үүрэг байгаа юм.

Гэм бурууг эцэслэж тооцох асуудал. Энэ бол шүүхийн асуудал. Шүүх дээр Засгийн газар болон Ерөнхий сайд оролцох ямар ч боломжгүй. Энэ хуулиар хориотой байдаг асуудал.

Гэхдээ би удаа дараалан байр суурь илэрхийлж байгаа. Энэ нь шүүхийн хувьд томилогдсон хүндээ үйлчилж байна.

Тийм учраас шүүгчид өөрсдөө улс төрөөс хараат бус байж чадахгүй байна.

Шүүх засаглалыг шүүмжилж байгаа биш ээ. Томилогдсон нэр бүхий шүүгч дээр асуудал байна. Жишээ нь, Эрдэнэтийн 49 хувийн асуудал 7 жил яагаад гагцхав аа. Бусад хэргүүд нь яахлаараа 7-хон сарын дотор шийдэгдэж болоод байдаг юм бэ.

Энэ асуудлын хариултыг олон нийт, парламентын гишүүд ч гэсэн бас нэхэх ёстой. Яагаад гэхээр энэ бол нийгэм. Бид нийгмийн төлөөлөл.

Тийм учраас авлигалтай холбоотой асуудал. Парламентаа зөндөө бужигнууллаа. Парламентын гишүүдийг ч ёстой хосын шувтарч байгаа юм шиг л юм боллоо. Энэ 4 жил.

Парламентын гишүүд маань өөрсдөө ч үүнийг дэмжлээ.

Төрийн албан хаагчид баахан бужигналаа. Одоо төрийн албан хаагчид энэ дээр нэлээдгүй цэгцтэй болж байгаа байх гэдэгт би эргэлзэхгүй байна.

Би шүүх засаглал гэж яриагүй шүү. Хувь шүүгчийн авлигалын асуудлыг хөндөх цаг болсон.

Ялангуяа ордуудын ард шүүгчид, нийслэлийн газрын ард шүүгчид шийдвэр гаргах замаар өөртөө давуу байдал олгосон олон асуудлууд байгаа.

Энэ асуудлуудыг Засгийн газар үе шаттай гаргаж ирнэ.

Үндсэн хуулийн дагуу хүн бүхэн тэгш байх ёстой. Энгийн иргэн ч, парламентын гишүүн ч, эрхэм шүүгч ч хэрвээ авлигал авсан бол хуулийн өмнө хариуцлага хүлээх л учиртай.

Энэ асуудал ер нь авлигад идэгдсэн зарим нэг шүүгчээс хамаарсан асуудал дээр өнөөдөр энэ тэмцэл гацаж байна гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт, хэн хэн хэзээ томилсон, тэр томилогдсон шүүгчид ямар ямар асуудлын ард байсан бэ гэдэг логик дарааллын удахгүй гаргаж тавина.

Энэ бол “нийгэмд цэгцтэй дүгнэлт өгөх” бас нэг алхам байх болно.

Ингээд үе шаттай иргэдийн мэдэх эрх нэмэгдэх тусам дүгнэлт илүү.../минут дуусав/

Г.Занданшатар: Б.Жаргалмаа гишүүн асууя. Д.Амарбаясгалан дарга. 3 номер. Ж.Ганбаатар сайд ажлын хэсэгт байхгүй. Сая нэр өгөөгүй.

Лиценз, уул уурхайн юмыг шалгана. Одоо энэ асуудлуудаар.

Ажлын хэсэгт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гэж алга байна. Ашигт малтмалын лицензтэй холбоотой асуудлууд.

Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья.

Нөөцтэй холбоотой, лицензтэй холбоотой. Би өөрийнхөө нэгдлийн хүрээнд байгаа тодорхой хэдэн мэдээллийг бас танд хуваалцъя гэж бодож байна.

Сая Ерөнхий сайдын үгэнд гарсан. Стратегийн. 2007 онд Их Улсын Их Хурлын тогтоолоор 2 хавсралттай тогтоол гарсан.

Нэг нь, 16 ширхэг стратегийн ордыг яг стратегийн орд гэж тодорхойлсон.

Одоогоор яг 7 лиценз нь “Эрдэнэс Монгол” дээр. Бусад лицензүүд нь хувийн хэвшил дээр.

Хуулиараа хувийн хэвшил өөрөө тодорхойлсон бол 34 хувийг, төрийн төсвийн хөрөнгөөр нөөц тогтоосон бол 51

хувийг авах энэ хуулийн хэрэгжилт бусад лиценз дээр хийгдээгүй байгаа гэсэн үг.

2 дугаар хавсралтаар стратегийн орд болох боломжтой. Үүнийг тодорхойлох үүргийг бас Засгийн газарт өгсөн 39 орд байгаа.

Энэ 39 орд ордын 2-ыг нь манайх эзэмшиж байгаа. Манай Мон-Орос, Дархан Төмөрлөг хоёр. Бусад ордууд бүгд хувийн хэвшил дээр төрийн эзэмшил тогтоогдоогүй явж байна. 3 ордын хувьд эзэмшилгүй байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ дээр бас зайлшгүй Их Хурал, Засгийн газар дээр асуудлууд цаашдаа яригдах боломжтой юм гэдэг ийм зүйлийг ярья.

Манай нэгдлийн хувьд үндсэндээ хоёр бизнес явж байгаа. Нүүрс, зэс.

Сая Д.Амарбаясгалан сайд хариулчихсан. Тийм ээ. Нүүрсний нийт тогтоогдсон нөөцийн 16 хувийг л манай нэгдлийн компаниуд эзэмшиж байгаа.

Гэхдээ манайх энэ нүүрсний бизнесээс яг улсад төвлөрүүлж байгаа, улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлогын 73 хувийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар тодруулна.

Ж.Ганбаатар: Баярлалаа.

Монгол Улс 74 ашигт малтмалаар 3135 ордын нөөц бүртгэгдсэн байгаа.

Үүнийг нэгдүгээрт хариулья.

Хоёрдугаарт, Эрдэнэт үйлдвэрийн нөөц яг цэвэр зэсээрээ 10.7 сая тонн.

Баяжмалаараа 500, 600-аад мянган тонн. Зэсээрээ 4-т хуваагдаж гардаг. Тэгэхээр бараг 40, 50 жил ашиглах нөөцтэй. Эрдэнэт үйлдвэр.

Оюу Толгойн хувьд цэвэр зэсээрээ 43 сая тонн гэж ойлгож болно.

Тэр лицензийн хувьд энэ хугацаагүй олгогддог юм байхгүй. Хайгуулын лиценз 3 жилээр олгогддог. Тэгээд 4 удаа сунгагддаг байгаа.

Цаашдаа Уул уурхайн яамнаас ямар бодлого барьж байгаа вэ гэвэл лицензийн төлбөрийн хувьд олон улсын жишигт нийцүүлнэ. Одоо нэг га-д оногдож байгаа төлбөр маш бага байгаа. Ашигт малтмалын хуулиар бараг 1997 оны ханшаар явж байгаа.

Лицензийн төлбөрийг олон улсын жишигт нийцүүлснээр олон жилээр лиценз эзэмшээд дараад ямар ч ажил хийдэггүй. Тэгээд яг яах гэж байгаа нь мэдэгдэхгүй бараг сумаар нь авчихсан байгаа тийм талбайнуудыг цэгцэлнэ гэсэн бодлогыг Засгийн газар, Уул уурхайн яам барьж байгаа.

Ер нь цуцлагдаж байгаа лицензүүд шүүх дээр очоод сэргэчихдэг ийм практик бараг 90 хувьтай байна.

Тийм учраас бид эдийн засгийн аргаар нь олон улсын жишигт лицензийн төлбөрийг нийцүүлнэ. Энэ бол нэгдүгээрт барьж байгаа бодлого гэдгийг хэлье. Дууслаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Яг асуулт асууж байх хугацаанд бас Эрдэнэс Монголын 256 мянга 636 төгрөг 80 мөнгөний хувьцааны

мөнгө орж ирж байна л даа. Энэ бол Компанийн хуулиараа явж байгаа байх.

Баялгийн сангаас Монголын ард түмэн ер нь яаж ашиг хүртэх вэ? Яг мэтчилэн хувь хүртээх юм уу, үгүй юу гэдэг дээр бас тайлбар өгөөч ээ гэдэг зүйлийг. Хуульдаа яаж оруулж ирж байгаа юм бэ?

Нөгөө талаар. Би түрүүн ярьсан. Оюу Толгойн түр хороо, Нүүрсний түр хороонд ажиллалаа л даа. Бид мэдээллийг ил тод, нээлттэй болгоод тэр дарагдчихсан байсан тэр хулгай луйврыг нь илрүүлээд өгөхөөр хариуцлага тооцож байгаа, ард түмнийг, Монгол Улсыг хохиролгүй болгож байгаа ийм “кэйс” ерөөсөө дурдагдахгүй байгаа юм. Энэ дээр ард түмэн хариулт нэхэж байгаа шүү гэдгийг би уламжилъя гэж бодож байна.

Бид яаж энэ улсуудаас хариуцлага тооцож алдсан баялгаа эргүүлж авах вэ гэдэг дээр олон нийт хүлээлт үүсгэж байгаа.

Ерөнхий сайд хэлж байна. Үнэхээр юу гэдэг юм, авлигачидтай бид тэмцэж чадахгүй байгаа юм бол ард түмнийхээ дэмжлэгийг авна шүү гээд Ерөнхий сайд хэлээд байгаа.

Яагаад бид хугацаа алдаад байгаа юм.

Г.Занданшатар: Д.Амарбаясгалан дарга хариулъя. Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Би сая ер нь хариулчихлаа л даа.

Гэм бурууг тооцох. Хуулиараа бол шүүх.

Одоо шүүхийн шатад шилжүүлэх хүртэл Засгийн газар хариуцдаг ийм хуультай. Эдийн засгийн хувьд үр өгөөж гарч байна. Эцсийн хариуцлага тооцох шатан дээр олон нийтийн дэмжлэг хэрэгтэй байна гэдэг нь анхаарлаа битгий сулруулаач ээ.

Хэн хэн ямар ямар асуудал дээр яаж байгааг олон нийт, хэвлэл мэдээлэл хамтдаа хянахгүй бол Ерөнхий сайд зөвхөн дангаараа яриад байхаар чинь одоо ингээд нөгөө Шүүхийн ерөнхий зөвлөл эд нар чинь намайг огцруулах шийдвэрүүдийг гаргачхаад, ийм байдал үүсээд байгаа учраас л би олон нийтийн хяналт хэрэгтэй шүү гэж хэлж байгаа нь тэр.

Энэ нийтийн сонсгол ч гэсэн хийгдэхгүй бол бас олон асуудлууд явж чадахгүй байсан даа. Энэ бол бодитой үнэн.

Тийм учраас энэ парламентын 2019 оны Үндсэн хууль үнэхээр үр өгөөжөө өгсөн гэдэгт итгэлтэй байгаа.

Энэ хуулийн төслүүд дээр байгаа ард нь дагах хуулиудыг та харвал яг үүний ард одоо яг таны хөндөөд байгаа үр өгөөжтэй холбоотой асуудлууд нэлээн гарч ирж байгаа.

Яах вэ, цаг амжихгүй байгаа учраас би дараагийн асуулт дээрээ яг энэ нөгөө нэг хуримтлалын сан болон бусад сангууд хэрхэн яг үр өгөөж өгөх вэ гэдэг хуулийн төслийн талаар дэлгэрэнгүй ярья.

Яагаад гэхээр хугацаа дуусч байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Монгол Ардын намын 2020 оны сонгуулийн

мөрийн хөтөлбөрт ард түмэндээ амласны гол амлалт бол Баялгийн сангийн хууль гаргаж байгалийн баялгийг ард түмэндээ өгөөжтэй, өрх бүрт өгөөжтэй хуваарилна гэсэн ийм том амлалт байсан.

Энэ амлалтаа хэрэгжүүлэх хуулийн төсөл орж ирж байгаад дэмжиж байна.

Монгол Улсын хувьд уг нь байгалийн баялаг ихтэй. Нэг хүн ногдох баялаг, тэгээд мөн малын тоо гэдэг юм уу, мөн газар нутгийн хэмжээ том боловч бид яг тэгш бус байдал газар авсан. 3 хүн тутмын нэг нь ядуу байна.

Үүнд хүрсэн гол асуудал өнгөрсөн 30 жилийн нөгөө баялгийн тэгш бус хуваарилалт, өмч хувьчлал, тэгээд байгалийн баялгийг цөөхөн хэдэн бүлэглэлүүд эзэмшсэн энэ том алдаа өнөөдрийн дүнд хүргэсэн.

Тийм учраас бид улс төр, эдийн засгийн том реформ хийх ёстой. Тэр реформын чинь нэг нь хамгийн гол нь Баялгийн сангийн асуудал учраас би дэмжиж байна.

Ер нь тэгээд эдийн засгийн онолын хувьд ч гэсэн зах зээлийн эдийн засгийн нөхцөлд хүмүүс тодорхой хугацаанд түр хугацааны орлогуудыг хуримтлал болгон хэрэглэж, дараа үедээ гэдэг юм уу, эсвэл нас ахисан хойноо ашиглах энэ макро эдийн засгийн онолын ёсоор ер нь баялгийн сан байх ёстой.

Тэгээд ялангуяа Монгол Улс шиг уул уурхайн баялаг өндөртэй улс орнууд Баялгийн сангийн хуулиа батлуулж, ирээдүйд хэрэглэх энэ өв санг тэгш хүртээмжид хуваарилж ирсэн байдаг.

Тийм учраас хууль үнэхээр Монгол Улсын хувьд өнгөрсөн 30 жилийн алдаагаа засах, тэгш хүртээмжтэй, Үндсэн хуулийнх

нь нэмэлт, өөрчлөлтийн дагуу баялгийг тэгш хүртээмжтэй хуваарилах гол бодлого гэдгийг хэлмээр байна.

Тэгээд ажлын хэсгийн гишүүдээс хэд хэдэн асуулт байгаа.

Ер нь баялгийн сангийн хуваарилалт, түүнд тавих хяналт, дээр нь төсвийн маш зөв бодлого байхгүй бол зарим улс оронд баялгийн сан үр дүнгээ өгч чадаагүй байдаг юм. Жишээлбэл, Орос нефтийн гол экспортлогч орон гэдгээрээ нефтийн сантай байсан.

Тэр нь 2016 онд жишээлбэл дотоодын бүтээгдэхүүнийхээ 7 хувьд хүрэх орлоготой байсан ч гэсэн яг төсвийн бодлого нь яваагүйн улмаас энэ санд хуримтлах орлого дөнгөж 2 хувьд хүрсэн. Одоо бараг зогсчихсон байгаа жишээтэй.

Гэтэл Ботсвана ч гэдэг юм уу, Норвеги гээд тодорхой улс орнууд баялгийн сангийнхаа үр өгөөжийг маш үр дүнтэй ашиглаж, эдийн засгийн хөгжилдөө оруулж ирсэн байгаа.

Тийм учраас хуулийн төсөл дээр ер нь энэ баялгийн сангийн хуримтлал, санхүүжилт, хяналт тавих тогтолцоо нь ямар орж ирсэн бэ?

Бид бас тодорхой улс орнуудын алдааг давтахгүй, үр өгөөжтэй сан байгуулах ёстой.

Хоёр дахь асуулт нь, “Ирээдүйн өв сан” гэж Монгол Улсад байгаа. Гэтэл л нөгөө “Ирээдүй өв сан”-д хуримтлал үүсгэх гээд тэр сангийнхаа хуримтлалаас бид тодорхой хувиудыг нь ашиглаад ирчихсэн байгаа.

Өөрөөр хэлбэл сан байгуулсан ч гэсэн яг цаг зуурын шинжтэй ашиглаад яваад ирсэн. Тэгвэл баялгийн сангийн

хуульд яг энэ санд хуримтлагдаж байгаа орлогуудыг хэрхэн хэрэглэх, энэ тал дээр ямар зохицуулалт байгаа вэ?

Өөрөөр хэлбэл энэ Баялгийн сангийнхаа хуулийн төсөл дээр яг энэ орж ирсэн хуримтлалыг ер нь хязгаарлах гэдэг юм уу, тодорхой зохицуулалт нь ямар байгаа асуумаар байна.

Гуравдугаар асуулт нь, одоо яг Баялгийн сангийн хуулийн төсөлд маань “**өв залгамжлал**” болон “**хувь эзэмшил**”-тэй холбоотой ямар зохицуулалтууд орж ирж байгаа вэ гэдгийг ажлын хэсгээс болон хууль санаачлагчаас асууя.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Би маш энгийнээр Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулах гэж хичээе.

Байгалийн баялгийн АМНАТ буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ирээдүйд хадгалагдана.

Ирээдүйн хадгалагдаж байгаа дансыг “Ирээдүйн өв сан” буюу одоо байгаа тэр данс.

Гэхдээ менежмент хийж буюу “Норвегийн сан”-тай адилхан байдлаар арвижуулах менежментийг хийх энэ эрх зүйн орчноор нээгдэнэ гэж ойлгож болно.

Мөн бүс ба орон нутаг уул уурхайн баялгийг дэмжиж байгаа орон нутаг ба бүс илүү давуу эрх эдэлж, тухайн газар нутгаа хөгжүүлэх боломжтойгоор АМНАТ-ийн зохих хувийг авна.

Тийм учраас АМНАТ бол ирээдүйд хадгалагдана. Бүс ба орон нутгийн хөгжилд

зарцуулагдана. Иргэдэд ногдол ашиг хуримтлагдана.

Үүнийг “**Хуримтлалын сан**” гээд, Маш энгийн. Бэлнээр авахгүй.

Тодорхой хугацаа буюу 2030 он хүртэл “**Үндэсний орон сууцжуулалт**”-ын эх үүсвэрт зарцуулагдана.

Иргэн бүхэн Монголбанканд нэрийн данстай байна. Түүнийг яг Төв банк удирдлагаар хангана. Бас арвижуулалт хийж болно.

Энэ агуулгаар ингээд тусгагдаж байгаа.

Иргэн хуримтлалаа

- *орон сууц худалдаж авахад зарцуулж болно,*
- *боловсролдоо зарцуулж болно,*
- *эрүүл мэнддээ зарцуулж болно*

гэдэг байдлаар одоо энэ бол ингээд хуульчлагдаж байгаа.

Энэ бол Сингапурын хуримтлалын сантай маш төстэй загвар.

“**Тэтгэврийн сан**”-тай нийлүүлэхэд тэтгэврийн сан маань одоо сантай нийлэх хэмжээнд ил тод биш байна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас хольж болохгүй. Гэхдээ цаашдаа магадгүй энэ амжилттай болбол 15-аас 20 жилийн дараа ч юм уу “Тэтгэврийн сан”-тай “Хуримтлалын сан” нэгдэх боломжтой. Гэхдээ одоо бол хооронд нь хольж болохгүй гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр одоо энэ хууль ингээд хэлэлцээд батлагдсанаараа Эрдэнэтийн 34 хувь, Оюу Толгойн 34 хувь, бусад стратегийн ордуудын 34 хувь

иргэдийн хуримтлалын санд төвлөрнө гэсэн үг.

Тэгэхээр ногдол ашиг ашигтай ажиллахын төлөө иргэн өөрөө хяналтаа тавина гэсэн үг.

Энэ агуулгаараа засаглалын хувьд илүү тийм томоохон хэмжээний реформ болж байгаа гэж ойлгож болно.

“Хөгжлийн сан” бол томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулагдсан.

Улсын төсөв хэрвээ давж биелбэл **50 хувь нь “Хөгжлийн сан”, 50 хувь нь “Тогтворжуулалтын сан”-д орно гэдэг** л ийм л ерөнхий зарчмыг л энэ дээр хувааж өгч байгаа юм.

Бусад нь хуулиудаар нарийвчилж зохицуулагдана. Нэгдсэн удирдлагаар бас хангагдах ийм эрх зүйн орчин нь хийгдсэн.

Г.Занданшатар: Хариулт дутуу байна гэнэ. С.Наранцогт дарга хариулах уу? Санжаагийн Наранцогт дарга.

С.Наранцогт: Тийм. Ер нь яах вэ, сай Ерөнхий сайд тайлбарлаж байгаа.

Энэ хууль маань 2030 он хүртэл ер нь тодорхой менежмент хийх, хөрөнгө цуглах ёстой. Энэ цугларах хүртэл бид энэ хуулиар механизм их тодорхой болж байгаа.

Тэр хүртэл ер нь эцсийн шийдвэрүүд нь Их Хурал эцэслэн нэгдсэн төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэгтэй цуг батлаад явна.

Ингэснээрээ таны хэлж байгаа нөгөө төсвийн болоод макро тэнцвэрээ хадгалаад нэгдсэн төсвийн нэг хэсэг болоод Их Хурал дээр хэлэлцэгдээд ингээд батлагдаад явна.

Түрүүн О.Цогтгэрэл гишүүн хуулийн нэр томьёо сайн уншаагүй учраас яамд, сайд нар хариуцах юм шиг ярьж байна лээ. Тийм биш.

Их Хурлын гарсан шийдвэрийг өдөр тутмынх нь тэр данс тооцоо, гүйлгээ хийх ажлыг нь л яамд хийнэ.

Энэ хооронд дагах тогтоолоор яг хөрөнгийн удирдлагын компанийг чадавхжуулах, бэхжүүлэх ажлыг Засгийн газарт үүрэг болгож байгаа.

“Ирээдүйн өв сан”-гийн энэ хөрөнгийн удирдлагын компанийн хэсэг л ерөөсөө хэрэгжээгүй. Энэ бол их сайн хэсэг. Яг Норвегийн сангийн хэсэг байсан.

Энэ хөрөнгийн удирдлагын компани хэрэгжихэд боловсон хүчнээ бэлдэх, тухайн сан нь өөрөө үйл ажиллагаагаа санхүүжүүлэх бололцооны хөрөнгө хуримтлагдах ийм урьдач нөхцөл бас бүрдүүлж, шилжилтийн хугацаа олгохгүй болохоор энэ хэсэг хэрэгжиж чадаагүй.

Тийм учраас “Ирээдүйн өв сан”-гийн дагаж мөрдөх тухай хуулиар энэ үүргийг Сангийн яаманд шилжүүлчихсэн байгаа.

Тэгэхээр бид яаж байгаа вэ гэхээр яг үг, үсгээрээ тэр “Ирээдүй өв сан”-гийн хөрөнгийн удирдлагын компанийг бэхжүүлж, энэ хуулийн зохицуулалтыг нь 2030 оноос мөрдүүлэх байдлаар орж байгаа. Тэгж л бэлдэх ёстой ийм байдал үүсэж байгаа.

Тэгэхээр хяналт Их Хурлын түвшинд ороод ирж байгаа.

Дээр нь иргэдэд очих хөрөнгө үндсэндээ ногдол ашгаас бүрдэж байгаа учраас энэ ногдол ашиг хаанаас бүрдээд байна вэ гэхээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн
Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа.
Баялгийн сангийн хуулийг үзэл
баримтлалынх нь хүрээнд дэмжиж байгаа.

Тийм учраас энэ хуулийг хэлэлцэх
эсэхийг нь дэмжээд хэлэлцүүлгийн
түвшинд бас зарим анхаарах зүйлүүд байна
уу гэж харж байгаа юм.

Заяагдмал баялгийнхаа үр өгөөжийг
хүн бүр тэгш хүртэх боломжийн тухай
асуудал яригдаж байгаа зүйл.

Тийм учраас зөвхөн төрийн өмчийн
оролцоотой төрийн өмчтэй хуулийн
этгээдийн 34 хувь хуримтлалын сандаа орж
ирэх ёстой юу, эсвэл ерөөсөө хувийн
хэвшлийн ч бай, энэ заяалагдмал баялаг
дээр тулгуурлагдсан үйл ажиллагаа
явагдаж байгаа хуулийн этгээдүүдийн төлж
байгаа татварын тодорхой хэсэг энэ рүү
орох ёстой юу гэдэг асуудал байгаад байгаа
юм.

Тийм учраас би тэр “Ирээдүйн өв
сан”-д тогтворжуулалт руу аваад
үлдсэнийх нь 65 хувийг “Ирээдүйн өв сан”
руугаа авч байгаа энэ хэсгээсээ тодорхой
процентыг “Хуримтлалын сан” руугаа авах
юм бол заяагдмал баялгийнхаа эзэдтэй
хүрэх бололцоо нь бүрдэж байгаа юм биш
үү гэдэг нэг ийм санаа байна. Энэ дээр нэг
хариулт өгөөч ээ гэж.

Хоёр дахь зүйл. Манай төрийн
өмчийн оролцоотой компаниуд ашигтай
ажиллалаа. Мэдээж 34-өөс дээш хувь
эзэмшиж байгаа тохиолдолд 34 хувийг нь
хуримтлал руугаа авчихлаа. Түүнээс давсан
хэсгийг нь орлого төвлөрүүлэгч этгээд
ирээдүйн хөгжил рүүгээ зарцуулахаар орж
байна л даа. Энэ хуулиар.

Тэгэхээр “Хөгжлийнхөө сан” руу
үүнийх нь тодорхой хэсэг орох ёстой юм
биш үү. “Хөгжлийн сан” чинь харин
төсвийн тэнцэл ашигтай гараад, гол орж
байгаа орлогуудын дундаж үнэлгээнээс
дэлхийн зах зээлийн үнэлгээ нь давсан
тохиолдолд тэр давсан хэсгийн 50 хувийг
оруулахаар ингэж зохицуулагдаж орж ирж
байна шүү дээ.

Тэгэхээр энэ бол бас бодууштай
зүйл.

Тийм учраас би үнэхээрийн ашигтай
ажиллаад, тэр “Хуримтлалын сан” руугаа
өгдөг хувиа өгчхөөд, давж байгаа
хэсгийнхээ тодорхой хэсгийг “Хөгжлийн
сан” руугаа авах ийм бололцоо боломж бий
юу? Ингэвэл их баталгаатай эх үүсвэртэй
болох юм биш үү гэсэн нэг ийм зүйл байна
гэж.

Гурав дахь асуумаар байгаа зүйл.
Баталгаат өгөөжийн асуудлыг яаж ярих юм
бэ? Би энэ хуримтлалын санг чинь иргэн
бүрийнхээ нэр дээр, тэгээд нэгдсэн сан
байх юм байна гэж ингэж ойлгосон.

Тэгэхээр зэрэг мэдээж “үлдэгдлийн
тухай асуудал” яригдана. Тэр “эргэлтэд
орох тухай асуудал” яригдана.

Тэгэхээр тэрний “баталгаат өгөөж”-
ийн асуудал ямар юм байх юм гэдэг зүйл.
Нэг.

Хоёрдугаарт, эх үүсвэрийг юунд
зарцуулах вэ гэхээр зэрэг боловсрол, эрүүл
мэнд, орон сууцын асуудал руу зарцуулах
гээд байгаа юм.

Тэгээд мэдээж энэ харилцаа өөрөө
тодорхой журам нөхцөлөөр зохицуулагдаж
таараа. Ойлгомжтой. Ямар цаг хугацаанд
ямар хэсгийг нь зарцуулах юм гэдэг
асуудал яригдаж байгаа.

Мэдээж би тэр цаад иргэн хүний нэр дээр байгаа учраас тухайлсан хүн дээр үүсэж байгаа хуримтлалтайгаа уялдсан байдлаар энэ нь явах юм байна гэж.

Тэр лүүгээ аваагүй улсуудын үлдэгдлийг яаж хэдүүлээ баталгаат өгөөжийнх нь асуудлыг ярьж, тэрнийг нь яаж тэр улсууд хүртэх боломжийг нь нээх юм бэ? Энэ гурав руу авахгүй байж болно шүү дээ.

Тэгвэл тэрийг нь яах вэ гэдэг асуудал байгаа.

Үүнтэй ер нь төстэй юм. Бид хэд нийгмийн даатгалынхаа шимтгэлийн тодорхой хэсгийг мөнгөжуулах тухай буюу хуримтлалын эрх зүйн орчинг нийгмийн даатгалын багц хуулиараа бий болгосон.

Тэгвэл одоо тэр мөнгөжүүлсэн хоёр пунктийнхээ эх үүсвэрийг энэ хуримтлалын сангийнхаа нэг бүрэлдэхүүн хэсэг мэт үзэж.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Олон жилийн хувьд ер нь яагаад бид үндсэн шийдэл рүүгээ сайн очиж чадаагүй вэ гэхээр яг үнэн л дээ.

Нэгдүгээрт, энэ сан хэрхэн арвижих вэ гэдэг нэгдсэн менежмент буюу нөгөө үржүүлгийн хүрд байх зарчим. Одоо жишээлбэл Норвегийн сан бол ингээд л бусад улсын хувьцаа худалдаж аваад л, тэгээд нөгөө арвижуулах тал дээр анхаардаг.

Энэ менежментийг бид хийж өгөөгүй. Данснуудаа салгачихсан учраас нэгдүгээрт энэ ингээд хийгдээгүй.

Тэгэхээр энэ эрх зүйн орчноор нэгдсэн менежмент рүү ингээд орж ирж байна гэдэг ийм ойлголтыг авах нь зүйтэй.

Хоёрдугаарт, АМНАТ, ногдол ашиг орлого давбал яах вэ, уул уурхайн бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээр уначихвал яах вэ гэдэг энэ бүх зүйлүүдийг давхар бодохгүй бол болохгүй болчхож байгаа юм.

Тэгэхээр одоо энэ маань ингээд ярьж ярьж, улс төрийн намуудтай зөвшилцөөд хамгийн л тийм “**БОЛОМЖИТ ТЭНЦВЭРИЙН ЦЭГ**” өнөөдөр л орж ирж байна гэсэн үг. Маш энгийнээр.

Одоо болон цаашид ашиглагдах “стратегийн ордууд”-ЫН 34 хувь нь хуримтлал.

Ер нь бид хийж чадвал том агуулга гэсэн үг. Том агуулга.

Эхлээд бид одоо байгаагаа ашигтай ажиллах тал дээр иргэдийн шахалтад орчхож байгаа юм.

Ингээд цаашлаад яах вэ гэхээр стратегийн орд биш юм шиг байгаа ордуудын хувьд ч гэсэн энэ хяналт сайжирна.

“Тавантолгой” дээр ингээд асуудал болохоос өмнө бас би нэг хэлж байсан. Тийм ээ. Ж.Ганбаатар сайд ч бас байсан байх.

“Тавантолгой” дээр онцгой дэглэм тогтоосноор дотоодын нийт бүтээгдэхүүн хоёр дахин тэлнэ ээ гэж.

Одоо эргээд бод доо. Тэлчихсэн байгаа биз.

Тэгэхээр стратегийн ордтой дүйцэхүйц хэмжээний ордын ил тод байдлууд сайжирснаар “Хуримтлалын сан” Монгол Улсад **“ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН РЕФОРМ”**-ыг хийх хямд эх үүсвэртэй болно.

Үүнийг бид их олон юманд ингээд тэгшитгэж хуваах гэж хичээх тусам энэ өөрөө ямар ч үр дүнгүй болно.

Хоёрдугаарт, нэгэнт бид “Тавантолгой” компани 1072 хувьцааг ингээд бэлнээр өгөөд байдаг. Компанийн хууль учраас өгөхгүй байж болохгүй.

Уг нь өөр зүйлд зарцуулагдвал энэ хамаагүй илүү үр өгөөжтэй. Гэхдээ нэгэнтээ л иргэддээ хувьцаа өгчихсөн учраас бид хариуцлагатай байх ёстой.

Тийм учраас бид бэлэн мөнгөөр цаашдаа одоо ингээд тараах бол инфляци ч дийлэхгүй, бэлэн мөнгөнийхөө эргэлтийг ч дийлэхгүй зүйл болно.

Тийм учраас **“ДУНДАЖ ДАВХАРГА”**-ыг дэмжих ёстой.

Орон сууцжуулалт, эрүүл мэнд, боловсрол хамгийн чухал асуудал гэж гарч ирж байгаа.

Тэр иргэд ирээдүйн үнэ цэн болж байгаа юм. Тэр иргэд өөрсдөө ирээдүйн баялаг бүтээгч үнэ цэн болно.

Г.Занданшатар: Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууна. Ж.Батжаргал гишүүн тодруулж асууя. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэгэхээр ашигт малтмал буюу эрдэс баялгийн салбарын үр

өгөөжийн асуудал дээр бид нэлээн их онцгой анхаарал хандуулах ёстой.

Баялгийн сангийн хуулиар ер нь овоо зохицуулалт, юмнууд нь тодорхой болоод ирж байгаа юм.

Гэтэл цаад аж ахуйн үйл ажиллагаан дээр үр өгөөжөө яаж тооцох вэ гэдэг юм байгаад байна л даа.

Төрийн өмчтэйгүүд нь одоо үүгээрээ ингээд захирагдаад болдог юм байж. Хувийн хэвшилд байгаа юмнуудаа бид яаж зохицуулалтаа хийх вэ гэдэг юмыг тэр ашигт малтмалын нөөцийн байдаг юм уу, тэр компанийн хуулиараа их тодорхой болгохгүй бол биржийн тогтчихсон үнээс бага үнээр борлуулалт хийгээд баланстаа тусгаад ашиг юмаа бага гаргаад яваад байвал яах юм бэ?

Тэгэхээр бид ер нь уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлохдоо **“ҮНИЙН ДООД ХЯЗГААР”** гэдэг юмыг бараг нэр төрөл болгон дээр нь жил болгон шинэчилж харж явах ёстой юм биш байгаа даа гэдэг бодол байгаад байгаа юм.

Үүнийг ер нь дагасан хуулиудаар яаж зохицуулбал зохилтой юм болоо гэсэн нэг ийм бодол.../минут дуусав/

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүн их чухал асуудал хөндлөө.

Нэгдүгээрт, энэ хууль батлагдсанаар стратегийн орд эзэмшигч хувийн аж ахуйн нэгжүүд олон нийтэд нээлттэй бирж дээр **“ЛИСТЭД ХУВЬЦААТ КОМПАНИ”** болно.

Хоёрдугаарт, энэ хууль яг өргөн баригдсан хувилбараар батлагдвал

стратегийн орд эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн 20 хувь нь л нэг компани байна.

Бусад нь **“public company”** болно гэдэг нь хөрөнгийн бирж дээр **“listed company”** /бүртгэлтэй компани/ болно гэсэн үг.

Энэ нь л өөрөө засаглалыг ил тод болгочхож байгаа юм.

Дээрээс нь нэгдсэн цахим менежмент хийгдэнэ. Ж.Ганбаатар сайд одоо энэ дээр ажиллаж байгаа.

Ингээд явахаар яах вэ гэхээр сая таны хөндсөн АМНАТ-аас нуугдаж байгаа, татвараас нуугдаж байгаа стратегийн ордыг 5 хуваагаад стратегийн орд биш гэж тайлбарлаж байгаа.

Эсвэл стратегийн ордыг стратегийн орд биш ээ гэж парламентын гишүүдэд ойлгуулаад, цэцийнхэнд хахууль өгөөд авчихсан стратегийн ордуудын асуудал эргэж хөндөгдөнө.

Энэ бүгд 34 хувь нь хуримтлалын сан руу шилжинэ.

Ирээдүйд орж ирэх нөөцтэй холбоотой асуудал дээр ямар нэгэн байдлаар одоо жишээлбэл өөрөөр тайлбарлах боломж хумигдана.

Яагаад гэхээр энэ бол ил тод байдал бий болно.

Дээрээс нь бас хэлэхэд стратегийн ордуудыг хувьд шилжүүлбэ гэдэг нэг ийм лобби “Тавантолгой” компани дээр ч тэр, “Эрдэнэт” дээр ч тэр. Ингээд явсан.

Энэ бол ер нь худлаа шүү.

Стратегийн ордуудыг эзэмшээд, тэгээд энэ мөнгөө улс төр лүү оруулаад ирвэл юу болдог вэ гэдгийг бид Ц.Элбэгдоржийн үед харсан шүү.

Одоо энэ цаг эргэж ирж болохгүй. Хэн ч дийлэхгүй шүү. Ийм их мөнгийг.

Одоо та нар бодоод үз.

Дараагийнх нь асуулт дээр хариульа даа.

Г.Занданшатар:

Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Өнөөдөр Үндэсний баялгийн сангийн тухай хууль орж ирж байгаа явцтай танилцахад бас концепцын хувьд нэлээн хэдэн жил бас яг ямар болох нь тодорхойгүй байгаад байсан. Ингээд ороод ирж байна.

Мэдээж хэлэлцэх эсэх гэж байна. Хэлэлцэх нь мэдээж зүйтэй.

Гэхдээ дүгнэлтээ хийх юм нь. Одоо бид ямар ч байсан ингээд **“Баялагтаа эзэн Монгол”**, 2019 оны **“одоо ба хойч ирээдүй үедээ газрын баялгийнхаа үр өгөөжийг зөв өгье”** гэдэг энэ философийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон хууль орж ирж байна.

Тэгээд гол юм нь “Хөгжлийн сан”, “Хуримтлалын сан”, тэгээд тэр “Ирээдүйн өв сан” гээд.

Тэгээд энэ дээр гол яригдаж байгаа юм нь хууль маань ингээд гарахад, энэ Эдийн засгийн байнгын санал, дүгнэлт нь ч гэсэн. Сангийн хөрөнгийн тогтвортой байдал гээд байгаа юм.

Бид 13 жилийн өмнө намайг гишүүн байхад бид “Тогтворжуулалтын сан”-гийн тухай хуулийг батлаад мөрдсөн. Тэгээд

дараа нь төрийг нь бас хуульд нь янз бүрийн байдлаар өөрчлөлт хийгээд элдэв янзаар нэр өгөөд хөрөнгийг нь ашиглаад байсан гэсэн шүүмжлэл гарсан.

Тэгэхээр одоо жишээлбэл энэ хууль дээр харахад та хэд маань нэг ийм механизм анхаарсан уу, үгүй юу. Хуулийг ингээд ердийн зарчмаар хурдан өөрчлөөд байдаг.

Тэгэхээр бид дээр нэг сонгуулийн хуулийг 2011 онд билүү хийх үедээ дийлэнх олонхын саналаар билүү, гуравны хоёрын саналаар үүнийг өөрчилж байна гэж.

Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн хууль маш чухал хууль байгаад байгаа байхгүй юу. Яг одоо Үндсэн хуулийн органик хуулийн шинжтэй.

Тэгэхээр хуулийн тогтвортой байдлыг яаж хангах вэ гэдэг асуудал дээр механизм маань дээр юу гэж харагдаж байна вэ? Бас яг сайн харагдаж өгөхгүй байна.

Хоёрдугаарт, гол юм бол ер нь ийм л асуудал байна л даа. Эх үүсвэр байна л даа.

“Хуримтлалын сан” бол одоогийн хүмүүст маш чухал анхаарал татсан асуудал байгаа. Эрүүл мэнд, боловсрол, орон сууцын асуудал хангана гэж.

Үүний эх үүсвэр дандаа төрийн эзэмшилд ногдох ногдол ашиг гэгчихсэн байгаа байхгүй юу. Бид хоосон яриагүй. Энэ засаг, энэ Их Хурлын үед яг өнөөдөр гэхэд жишээлбэл 256 мянган төгрөг 1072 хувьцаатай хүмүүст ингээд ногдол ашиг нь орж байна.

Тэгэхдээ манай төрийн өмчит компаниудын чинь ихэнх нь ашиггүй

ажилладаг. Цөөн хэдхэн толгой том компаниуд маань л ногдол ашиг олдог.

Тэгэхээр одоо энэ хуулийг чинь дагалдаад ер нь төрийн өмчит компаниуд ашигтай ажиллах шаардлагатай байгаа юм. Ашигтай ажиллаж байж хуримтлалын сан, сая хэд гуравхан компанийн эх үүсвэртэй биш, илүү арвижиж байж, тэгж байж иргэд эрүүл мэнд, боловсрол, тэр орон сууцынхаа асуудлыг шийдэх боломж гарц нээгдэх нь.

Тэгэхээр энэ дээр Засгийн газар нэг хэсэг яриад байсан. Одоо энэ төрийн болон орон нутгийн өмчит хуулийнхаа философийг өөрчлөх ёстой байгаа юм. Энэ бол энэ Баялгийн сангийн хуулийн их чухал хэсэг байж байна.

Нэг гол би асуух гээд байгаа юм маань нөгөө “Хөгжлийн банк” байгаа юм.

Энэ дээр “Хөгжлийн сан” гэж заачхаад яг “Хөгжлийн сан” маань ямар байх юм гэдэг талаар дурдаагүй байна.

Ерөнхийдөө гурван яам л удирдах нь байна шүү дээ.

- Эдийн засаг, хөгжлийн яам,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,
- Сангийн яам гурав удирдана.

Өнгөрсөн он жилүүдийн бид нарын их ярьсан юм бол засаглал муу байгаа тухай ярьсан.

Хойно Их Хурлын тогтоол дээр Ерөнхий сайдад цаашдаа олон улсын засаглал, сайн засаглалыг нэвтрүүлэх юмыг үе шаттай нэвтрүүлэх гээд заачхаж.

Тэгэхээр **засаглалын асуудал** чинь хамгийн гол нь failed_[амжилтгүй болох]-ээд байгаа.

Тэгэхээр одоо ямар ч байсан нэг хэсэгтээ гурван яам удирдаад явах нь байна шүү дээ.

Тэгэхээр нөгөө улс төр, Их Хурал, Засгийн газар, тухайн үеийн уур амьсгал ордог, өөрчилдөг.

Тэгэхээр энэ асуудал дээр хяналт тавих тухай энэ хууль дээр заачихсан гэж байна.

Тэгэхээр яг энэ дээр хэлэлцсэний дараа Их Хурал ажиллах ажлын хэсэг энэ хяналтын механизм дээрээ анхаарах ёстой байх.

Засаглалаа бас ойлгомжтой тайлбарлахгүй бол хүмүүс чинь үүнийг эргээд л дахиад л санг завхруулдаг гэж.

Тэгэхээр “Хөгжлийн сан”. Би асуух гэж байгаа юмаа дахиад тодруулаад хэлэхэд “Хөгжлийн сан”, “Хөгжлийн банк” яаж уялдаж байна вэ? “Хөгжлийн банк” татан буугдах юм уу?

“Хөгжлийн сан”-гийн удирдлагыг одоо тэгээд хэрэгжүүлж байгаа Эдийн засаг, хөгжлийн яам хөрөнгө оруулалтын асуудал, том төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээд явах гэж байна уу?

Эсвэл **“Хөгжлийн сан”**, **“Хөгжлийн банк”** хоёрыг өөрөөр тооцсон юм юу байгаа вэ? Их Хурал тогтоол гаргачихсан. Өмнөх нэг тогтоол байгаа шүү дээ.

Тэгэхээр дээр бас яаж байна гэдэг ийм.../минут дуусав/

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: “Хөгжлийн банк” татан буугдахгүй.

“Хөгжлийн банк” бол **ЭКСИМ**[экспорт, импорт] банкны хэлбэр лүү орж зохион байгуулагдана гэсэн үг.

Тэр нь юу вэ гэхээр арилжааны банкнуудтай “Хөгжлийн банк” өрсөлдөхгүй буюу жижиг зээлүүд олгохгүй.

Хоёрдугаарт, доллар Монгол Улсад оруулж ирж байгаа экспортыг дэмжсэн зээлийг л гаргана гэсэн үг.

Нэг үгээр хэлбэл Монгол Улсын газар нутаг дээр магадгүй манай зарим компаниуд Узбекистанд ч юм уу, ингээд Киргизэд ч юм уу бас ингээд ажиллаж байна. Жишээлбэл, ингээд томоохон аж ахуйн нэгжүүд.

Тэр нь яах вэ гэхээр тэндээс өөрөө манай валютыг дэмжиж байгаа.

Түүнд түрүүлж “Хөгжлийн банк” зээл олгох энэ загвар луу явна гэсэн үг.

“Хөгжлийн сан”-д хуримтлал үүсэж байгаа асуудал бол төсөвтэй яг адилхан Их Хурлаар батлагдана. Гэхдээ төсөв шиг олон хуваахгүй л гэсэн үг. Орлого давбал.

Тэгэхээр яах вэ гэхээр парламентын гишүүд бид бүгдээрээ төсвөө ашигтай байлгах, төсөв алдагдалгүй байхын төлөө хичээн эрмэлзэх ийм сэдэл бас энэ хуулиар ингээд бий болж байгаа.

Би нөгөө “**үржүүлгийн хүрд**” гэж яриад байгаа маань тэр.

Төсөв ашигтай ажиллах тусам бид томоохон асуудлуудаа том дүнгээр шийдвэрлэх боломж гарна гэсэн үг.

Тэр нь өөрөө бүгдийг санхүүжүүлэх биш, санхүүжүүлэх зүйлийн эхлэл “fund”^[сан] бас байх боломжтой гэсэн үг.

“Хөгжлийн банк”-аар дамжиж гарч болно.

Тэрийг шууд байдлаар, магадгүй баталгааны хэлбэрээр ч юм уу бас ингээд ашиглаад явчих боломжтой. Хөгжилтэй холбоотой асуудал.

Би түрүүн хариулж байсан зүйл дээр бас асуулт давхцаж байна.

Өмч хувьчлал. Өмч хувьчлал зөв. Төрийн өмчийн хувьд шилжүүлэх нь. Гэхдээ зөв хийвэл зөв, буруу хийвэл буруу.

Шатахууныхаа бүх компаниудыг хувьчилчихсан нь зөв байсан уу, үгүй юу. “Роснефть” гээд нэг л компаниас авдаг мөртлөө энд хүрч ирээд хэдэн компанитай асуудал болдог.

Тэгээд нэг улс төрийн үйл явдал болохоор л бензин тасардаг. Энэ зөв үү, буруу юу.

“Тавантолгой” компанийг ер нь тун хувьчлангаа алдсан.

Хэрвээ хувьчлагдчихсан байсан бол одоо энэ дүнг бодоход **9.6 их наяд төгрөгийн орлого олж байгаа юм.**

3.5 их наяд нь цэвэр ашиг.

Энэ мөнгө бүртгэлгүйгээр улс төр лүү орвол яах вэ. Тийм учраас энэ хууль дээр стратегийн орд эзэмшигч компаниуд улс төр санхүүжүүлэхийг хориглож байгаа юм.

Энэ яваандаа ер нь ингээд дийлдэхгүй болоод нөгөө “**баялгийн хараал**” гэдэг зүйл бол яг энэ.

Нөгөө хар тамхины мафиудаа дийлэхээ больчихдог зүйл чинь ер нь бол энэ шүү дээ.

Тэгээд би баялаг ашиглаж байгаа компаниуд “даруухан байх ёстой”, “хүндэтгэлтэй хандах ёстой”, “ил тод байх ёстой” гэдэг нь тэр.

Өмч хувьчлал дээр 30 хувийн татвар оруулж ирж байгаа. Энэ ч гэсэн үүнтэй холбоотой асуудал.

Тэгээд ингээд явахаар яах вэ гэхээр эдийн засаг аяндаа эрүүлжинэ. Энэ нь өөрөө эдийн засаг руу.../минут дуусав/

Г.Занданшатар: 13.00 цаг болсон байна.

Чуулганыг 14.00 цаг хүртэл завсарлуулъя. 14.00 цагаас үргэлжлүүлж хуралдана. /алх цохив/

ЗАВСАРЛАГА

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 04-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Үдээс хойших хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг оруулъя. Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт, хариултаа үргэлжлүүлж байя.

Ж.Сүхбаатар: Би түрүүн яах вэ асуултдаа гүйцэд хариулт аваагүй л дээ. Ажлын хэсэг хариулах байх.

Хуулийн тогтвортой байдлыг яаж хангах вэ гэдэг асуудал, механизм энд суугаагүй байна. Үүнийгээ яаж харж байна гэсэн.

Хоёрдугаарт, нэг ийм асуудал байгаа.

Энэ “баялгийн сангийн төсөв нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна” гээд 12.1 дээр байгаа юм л даа. Би төсвийн чиглэлийн санхүүгийн хүн биш.

Энэ “Ирээдүйн өв сан”-г ер нь энэ нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэгт оруулах хэр зөв юм бол доо. Одоо манай С.Наранцогт маань дэд сайд байсан хүн. Төсвийн тэр аргачлал, үзүүлэлт талаасаа чухал байдаг юм уу?

Уг нь “Ирээдүйн өв сан” чинь зорилго нь өөр байгаад байгаа шүү дээ. Тэр чинь төсөвт үзүүлэх баланс, янз бүрийн юм талаасаа заавал тийм хэрэгтэй юм. Тэрийг чинь авч ашиглахгүй байх ёстой гээд байдаг.

Цаашдаа энэ чинь илүү бие даасан удирдлагатай, илүү зөв арвижаад ингээд явж байх.../минут дуусав/

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт захирал хариулъя.

С.Наранцогт: Ж.Сүхбаатар гишүүний асуултад хариулъя.

Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэгтэй явж байгаа нь хоёр зорилготой байгаа.

Нэгдүгээрт, макро тэнцвэрийг хадгалахын тулд хэдийгээр үйл ажиллагааны хувьд хоорондоо төсвийн сангууд болон улсын төсвийн зарлага, орлоготой холилдохгүй.

Яг сан сандаа төвлөрөөд ажиллаад явчихна. Нэгдсэн төсвөөр батлуульж байгаа нь аль аль сангаасаа яваад нэгдсэн төсөвтэй байгаад энэ төсөв мөнгөний бодлогынхоо макро тэнцвэрийг хадгалах гэдэг нэг агуулга байна.

Хоёрдугаар агуулга нь, ер нь эцсийн шийдвэрийг ашигт малтмалаас орж байгаа орлого яг Үндсэн хуульд нийцсэн зарчмынхаа хүрээнд “**төрийн нийтийн өмч**” учраас нийт ард иргэдээсээ сонгогдсон төлөөлөл буюу Улсын Их Хурал дээрээ төсөв нь яг эцсийн шийдвэр болж батлагдаж байх нь зүйтэй байна гэдэг ийм агуулгаар орж ирж байгаа юм.

Ер нь манай гишүүд, Ардчилсан намын бүлэг дээр ч гэсэн ярьж байгаа зүйл бол, бид ч бас Засгийн газар танилцуулахдаа нэлээд ярьсан нь сонгодог утгаараа мэдээж олон улсын сайн туршлага, хөрөнгийн удирдлагын компани болох ёстой гэдэг концепц нь байж байгаа. Хэрэгжүүлэх тогтоол дээрээ заалт болж орсон.

Гэхдээ энэ бол тодорхой хугацаанд манай бусад улсын тэр газ хийнээс ордог орлоготой харьцуулах юм бол, нефтиэс ордог орлогоос харьцангуй харьцангуй бага мөнгөтэй.

“Ирээдүй өв сан” дээр жишээлбэл энэ зохицуулалт их дэлгэрэнгүй сайн зохицуулалт Норвегийн сангийн жишгээр хийгдчихсэн. Харамсалтай нь үүнийг хийх

гэхээр нэгдүгээрт манай санд байгаа мөнгөний хэмжээ, боловсон хүчин, энэ үйл ажиллагааны зардал зэрэг нэлээн олон шалтгаанаас болоод энэ хэсэг нь ерөөсөө хэрэгжиж чадаагүй. Ингээд 2025 он хүртэл Сангийн яам хэрэгжүүлнэ гэдгээр огт хэрэгжээгүй явсан. Энэ нь бас иймэрхүү шалтгаантай.

Нөгөө талдаа Хөгжлийн банкн дээр жишээлбэл бид нар.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Үндэсний баялгийн сангийн тухай хууль ер нь жоохон оройтоод л орж ирж байна л даа.

Ардчилсан намын бүлгийн гишүүд дөрвөн сарын өмнө **“Тусгаар тогтнол”** нэртэй Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн бас нэг төслийг өргөн барьсан.

Тэгээд өнөөдөр хүртэл хэлэлцэх асуудал нь шийдэгдээгүй явж байгаа.

Яах вэ, Засгийн газрын өргөн барьсан хууль өчигдөр өргөн баригдаад өнөөдөр одоо ингээд хэлэлцэх асуудал нь шийдэгдээд явж байгаа нь бас сайн хэрэг.

Цаашлаад энэ хоёр хууль ер нь зорилго нэг. Бас тодорхой асуудал дээр зарчмын зөрүүнүүд байна.

Тэгээд үүнийгээ бас нэгтгээд “Тусгаар тогтнол” үндэсний баялгийн сангийн тухай хуулийн үндсэн гол ялгаатай асуудал маань засаглалыг сайжруулах асуудал дээр тодорхой бодит заалтуудыг оруулсан байгаа.

Тэгэхээр бидний хувьд манай Монгол Улсын өнөөгийн 33 жилийн ойн, ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас

хойш явж байгаа нэг алдаатай асуудал. Бид маш хариуцлагагүй байгаа.

Бидэнд баялаг байна уу, байна. Орлого олж байна уу, онцолж байна.

Хамгийн гол нь түүнийг зарцуулж байгаа асуудал дээр ер нь иргэдийн хяналт байхгүй. Энэ дээр хулгай, авлигал нүүрлэсэн гээд бодит жишээнүүд байна л даа.

Тэгэхээр үүнийг л засан залруулж нийтийн хяналтад оруулах, цаашлаад нээлттэй IPO, хувьцаа гаргаж иргэдээ мөнгөжүүлж ийм л асуудал бид бүхний өмнө энэ хуулиараа дамжуулаад хийгдэх байх гэж ойлгож байгаа.

Гэхдээ бид энэ хууль батлагдсанаараа олон асуудлын гогцоог тайлж, тэрийгээ зөв талд нь гаргах байх.

Би ер нь бас нэг асуудлыг. **“Эрдэнэс Баянбогд”** гээд нийслэлийн 66 хувийн өмчтэй. Одоо “Эрдэнэс Монгол”-ын 34 хувийн өмчлөлтэй ийм нэг нууцлагдмал ордтой болсон.

Өнөөдрийг хүртэл Их Хурлын гишүүн хүртэл одоо тэр мэдээллийг олж авахад хүндрэлтэй ийм байдалтай байгаа.

Тэгэхээр энэ бол одоо Монгол Улсын өмч өө. Төрийн өмч.

“Эрдэнэс Баянбогд” стратегийн орд бүхий энэ баялгийг өнөөдөр яагаад нийслэл рүү шилжүүлчхэв. Нэгд нь.

Хоёрт нь, Засгийн газрын шийдвэр гаргахдаа Та бүхэн яг тэр геологийн нөөцийг нь баталгаажуулсан тэр **“JORC стандарт”**-ын тайланг ер нь Та бүхэн үзсэн үү? Үзэж байж шийдвэр гаргасан уу?

Эсвэл үзээгүй, нөөц нь тодорхойгүй гээд асуудлыг бүрэн ойлголтгүйгээр нийслэл рүү шилжүүлчээгүй байгаа даа гэсэн ийм бодол төрөөд байдаг юм.

Яагаад гэхээр энэ орд нь өөрөө Монголын ард түмний өмч. Зөвхөн нийслэлийн тодорхой хэмжээний гурав, дөрөвхөн төслийг хэрэгжүүлэх хэмжээний тийм жижиг орд биш.

Хэрвээ метро ярьж байгаа бол одоо бараг 10, 15 метро барих хэмжээний, өнөөдрийн ярьж байгаа метрог барьчих хэмжээний ашиг олчих ийм ордыг өнөөдөр нийслэлд өгөөд, зөвхөн төсөл хэрэгжүүлэх хэмжээнд тэр ордыг ашиглах асуудлыг хотын захирагч нар яриад явдаг. Энэ бол Монголын ард түмэн бүгдээрээ мэдэж байгаа. Гадаад улс орнуудад очоод тэр олон улсын стандартын геологийнхоо нөөцийг үзүүлээд буцаагаад томоохон төслүүдийг Улаанбаатар хотдоо хэрэгжүүлбэ гэдэг асуудлыг яриад явдаг.

Тэгэхээр аливаа асуудал ийм хоёр талтай л байгаад байна л даа.

Өнөөдрийн энэ хууль гарахаас өмнө тэр асуудал яригдсан. Тэр асуудал шийдэгдчихсэн. Хэрвээ одоо энэ хууль маань гарах юм бол одоогийн энэ “Эрдэнэс Баянбогд” дээрх жишээний ийм асуудлуудыг бид.../минут дуусав/

Г.Занданшатар: Дашзэгвийн Амарбаясгалан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариулна.

Д.Амарбаясгалан: Н.Ганибал гишүүний асуултад хариулъя.

“Эрдэнэс Баянбогд”-ын асуудлыг асууж байна гэж ойлголоо. Тийм ээ.

Тэгээд 34 хувь нь “Эрдэнэс Монгол”-ын мэдэлд, 66 хувь нь

нийслэлийн мэдэлд шилжсэн ийм процесс 2021 онд хийгдсэн байгаа юм.

Тэгээд энэ асуудлыг Засгийн газар эргэж харахаар асуудлаа боловсруулаад явж байна. Нэг ёсондоо “Эрдэнэс Монгол” компанийн саналаар.

Энэ цаашдаа нөөц нь тогтоогдоод стратегийн орд байх уу, үгүй юу. Цаашлаад байгалийн баялаг орон нутгийн өмчид шилжээд явах нь зөв үү, буруу юу. Үндсэн хуулийн 6.2-ыг зөрчиж байгаа юу, үгүй юу гэдэг дээр Засгийн газар маш олон талаас нь ярилцаж байгаа.

Одоо бид бас мэднэ шүү дээ. “Жижиг Тавантолгой” хувьцаат компани. Тийм ээ. Бас Өмнөговь аймгийн орон нутгийн мэдэлд 51 хувь нь байгаа. 49 хувь нь бусад хувьцаа эзэмшигчдийн мэдэлд явдаг.

Энэ дээр олон талын маргаан гардаг. Байгалийн хэвлийн баялаг өөрөө нийт ард иргэдэд өгөөжөө өгдөг байх ёстой гэсэн үндсэн зарчимтай нийцэх үү, үгүй юу гэдэг асуудлыг судлаад явж байгаа гэдгийг хэлбэ.

Г.Занданшатар: Ажлын хэсэг. Нэмж нэрээ өгнө дөө. Жамбалын Ганбаатар. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд.

Ж.Ганбаатар: Баярлалаа. “Эрдэнэс Баянбогд” дээр Н.Ганибал гишүүн бараг хоёр дахь, гурав дахиа асууж байгаа байх. Үүнийг бас чуулган дээр ярьж байх.

Ер нь “Х” зөвшөөрөлтэй. “А” зөвшөөрлөө аваагүй. “А” зөвшөөрлөө аваагүй гэдэг чинь нөөц нь Эрдэс баялгийн зөвлөлөөр ороогүй л гэсэн үг.

Ерөнхий сайд Дорноговь аймагт уулзаад явж байхад үед ч гэсэн тодорхой хариулсан.

Ер нь “А” зөвшөөрөл олгогдох нөхцөл бололцоо хангаагүй. “А” зөвшөөрөл олгогдоогүй байгаа л гэсэн үг. Дууслаа.

Г.Занданшатар: Н.Ганибал гишүүн тодруулья.

Н.Ганибал: Тийм. Зүгээр **JORC**-оороо баталгаажсан стандартын геологийн тайлан байгаа байхгүй юу. Тийм ээ. Тэрийг бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ.

“AREVA” хүлээлгэж өгөхдөө геологийн нөөц нь ийм байна гээд.

Одоо нарийвчилсан хайгуулыг нийслэлийн төсвөөр хийж байгаа. Үүнийг бүгдээрээ мэдэж байгаа. Нийслэлийн төсөв дээр тэр мөнгө нь байгаа.

Хамгийн гол нь тэр хайгуулын баталгаажуулалтын юун дээр гадаадын компаниуд тэнд хяналт тавьж байгаа юм билээ. Жоохон нууцын гэрээтэй явж байгаа гэсэн.

Ер нь ийм шүү дээ. Ямар нэгэн байдлаар олон улсын хэлцэл хийхэд **JORC**³[Joint Ore Reserve Committee]-ийн тайлан барьж байгаад хоорондоо ярилцдаг шүү дээ.

Энэ дээр ийм байгаа. Тэгэхээр ийм юм дээр одоо манайх ийм нөөцтэй орд байна. Энд зориулаад танайх манайд ийм төслүүд хэрэгжүүлээч ээ гээд.

Үүнийг Монголын үндэсний телевизээр өнгөрсөн зуны бараг бүтэн нэг сар үзсэн байхгүй юу. Бүгдээрээ.

Г.Занданшатар: Тийм. Ерөнхийдөө ойлгомжтой хариулсан юм байна.

Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууна.

Г.Ганболд: Хуулийг дэмжинэ.

Эндээс бид эх үүсвэр нь юу байх юм, юунд зарах юм, хэн захиран зарцуулах юм гэдэг л ерөөсөө гурван асуудал ярина.

Тэгэхээр би зарцуулалт дээр ярих гээд байна.

Энэ дээр “Хөгжлийн сан”, “Хуримтлалын сан” эд нар бол жоохон орлого тодорхойгүй. Хамгийн гол төвлөрөх юм бол “Ирээдүйн өв сан”.

Тэгэхээр үүнийг одоо яг зарцуулах нь олон улсын зах зээл, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт оруулах замаар гэж байгаа юм.

Нөгөө талдаа “Хуримтлалын сан”-г ингээд эрүүл мэнд, боловсролын систем рүү зарах юм бол төсвийн бүрэлдэхүүн болгож зарцуулсантай ямар ч ялгаагүй. Энэ салбаруудаас чинь эргэж энэ сан арвижихгүй.

“Сан” гэж юуг хэлдэг юм гэхээр арвижуулаад, түүнийгээ өсгөж, үржүүлэх л зорилготой.

Тэгэхээр эхний ээлжид ерөөсөө энэ сангуудаа зарцуулахгүй нэг хэсэг хугацаанд арвижуулж, тэр сан том болоод ирсэн хойно нь өсөх тухай асуудал байгаа юм.

³ **JORC code** нь ашигт малтмалын хайгуулын үр дүн, ашигт малтмалын нөөц ба хүдрийн нөөцийг нийтэд тайлагнах стандарт тогтоосон мэргэжлийн үйл ажиллагааны дүрэм.

Тэгэхээр би энэ “Ирээдүйн өв сан” дээр нэг юм нэммээр байгаа юм.

Бид байна шүү дээ, олон улсын зах зээл дээр санхүүгийн хөрөнгө оруулна гэж байгаа юм.

Хөрөнгө оруулалт болгон ашигтай биш шүү дээ. Эрсдэлд орж болно. Ганцхан эрсдэлгүй юм нь юу вэ гэхээр Засгийн газрын өр, зээлүүд байна шүү дээ. Манайх чинь өөрөө гадаадад Засгийн газрын өр гэхэд 8, 9 тэрбум доллар байна шүү дээ.

Тэгэхээр “Ирээдүйн өв сан”-гаасаа. Бид гадаадаас авч байгаа зээлээ Монгол Улсын Засгийн газар, төр бол яг доллароор аваад хүүтэй нь төлж байгаа.

Тэгэхээр энэ хуримтлагдсан баялгийн сангаасаа тэр өр төлбөрийг барагдуулаад, засаг тэр сандаа одоо ингээд хүүтэй нь өрөө төлөөд явдаг ийм эрх зүйн зарцуулалтыг энэ дээр заавал зааж өгөх ёстой.

Тэгэх юм бол “сан” эрсдэлгүй. Төр өөрөө гадаадад өртэй байснаас сандаа өртэй.

Тэрийгээ яг доллароор нь хүүтэй нь хийгээд явдаг ийм эх үүсвэрийг зайлшгүй нээх шаардлагатай гэж бодоод байгаа юм.

Тэгээд энэ дээр ажлын хэсэг яг ямар бодолтой байгаа вэ?

Хоёрт нь, юунаас бүрдэх вэ гэж.

Тэгэхээр энэ дээр мэдээж заавал төрийн өмчит компаниудын ногдол ашиглахаас гадна. Түүрүүн гишүүдийн хэлсэн. Заавал төр гэх юм байхгүй. Хувийн хэвшлийнхний ерөөсөө энэ байгалийн баялаг ашиглаж байгаа энэ бүхий л компаниуд орлогын тодорхой хувийг энэ санд төвлөрүүлдэг ийм зохицуулалтыг ер

нь зайлшгүй хийж байж Оюу Толгойгоос ч тэр, эсвэл энэ хувийн 100 хувь эзэмшиж байгаа томоохон ордуудын тодорхой хувь нь энэ санд орж арвиждаг.

Тэгэхгүй бол нэг хэдхэн төрийн өмчит компаниа гээд яваад байх юм бол түвэгтэй болно.

Тэгээд би “Эрдэнэс Монгол” компанийг анх байгуулагдахдаа төрийн өмчийн энэ олон компаниудыг менеж хийгээд олон улсын зах зээл дээр би IPO гаргах юм байна гэж би ойлгож энэ компанийг байгуулж байна гэж ойлгосон.

Гэтэл энэ хуулийн чинь 12.5 дээр хуримтлалыг төвлөрүүлдэг аж ахуйн нэгж нь 100 хувь төрийн өмчтэй байна гээд заачихсан байх юм.

Тэгэхээр одоо танайх бол тэр нөгөө өмнөх байгууллагадаа явж байсан тэр хэлбэр лүү орохгүй гэсэн үг гэж ойлгох уу?

Ер нь одоо ингээд танайх өөрөө IPO хийгээд олон улсын зах зээл дээр гарахгүй. Ерөөсөө 100 хувь төрийн өмчтэй компаниараа байх юм байна. Тэрийг нь одоо үүгээрээ ингээд хуульчилчхаж байна гэж ингэж ойлгож болох уу?

Тэгэхээр эндээс чинь уг нь Монголын томоохон стратегийн ордууд дээр одоо байгаа энэ төрийн өмчит компаниудынхаа нэмүү өртөг шингэсэн Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн арматурын үйлдвэрийг гадаад зах зээл дээр хөрөнгө оруулалт босгож ирээд хийгээд явах ийм менежментийн чинь юмнууд ингээд хаагдчих юм биш биз гэсэн асуулт байх юм.

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт захирал хариулъя.

С.Наранцогт: Г.Ганболд
гишүүний асуултад хариулъя.

Энэ сангуудад ямар орлого төвлөрүүлэх вэ, яаж яаж хуваах энэ механизмыг нэлээн олон ярилцсан. Өмнөх хуулиуд дээр ч байсан. Засгийн газрын хуралдаанд 3 удаа танилцуулагдсан, 4 удаа ярьсан. Тэгээд яамдын саналыг тусгасан.

Сая өглөө Ерөнхий сайдын хэлснээр ярьж, саналууд тусгагдаж явж явж ямар ч байсан энэ бол нэг тийм яг тэнцвэрийн цэг ч гэх юм уу, яг энэ дээгүүрээ л ямар ч байсан яваад эхэлье гэдгээр энэ хуваарилалт юм нь орж ирж байгаа.

Хоёрдугаар асуудал яасан гэхээр анхандаа бид бас хуулийн зохицуулалтыг нэлээн дэлгэрэнгүй болгоод, тэр хөрөнгө оруулалтын шийдвэрийг яаж гаргах вэ, хаана хийх вэ энэ тэр гээд юмнууд явж байсан.

Мөн л намын бүлгүүдийн ажлын хэсэг, Засгийн газар дээр олон удаа ярихаар энэ хууль дэлгэрэнгүй хийгдэх тусмаа нэгдсэн ойлголтод хүрэхэд их төвөгтэй байдал үүсэх юм байна.

Тийм учраас энэ хуулийг хамгийн хураангуй, товчхон, зөвхөн үндсэн зарчмыг тодорхойлсон хууль хэлбэртэй болгох нь зүйтэй байна гэж үзээд ингэж орж ирж байгаа.

Хөрөнгө оруулалтын бодлого хаана тодорхойлогдох вэ гэхээр Засгийн газар дээр Засгийн газар хөрөнгө оруулалтын бодлогоо тодорхойлно.

Та сангууд ярьсан. Төсвийн нэгдсэн төсвийн хэсэг байна гээд. Яах вэ, сан бол ерөнхий зарчим нь өсгөх, үржүүлэх механизмууд тодорхой сангаараа явж байгаа ч гэсэн улс болгон өөр өөрийн ямар асуудлаа шийдэх гэж байна вэ гэдгээсээ

хамаараад бүгдээрээ ч бас тийм биш байгаа юм.

Бид нарын тандан судалгааны үед Америкт Нью-Жерси мужид ч хүртэл энэ газрын тосны орлогоо шууд иргэд рүүгээ бүр кэйшээр хуваарилчихдаг ч тогтолцоо байгаа.

Тэгэхээр бидний хувьд эхний энэ концепц дээрээ бэлэн бус “Хуримтлалын сан” гэж үүсгээд, 2030 оноос “Ирээдүй өв сан”-гийн зохицуулалт өөрчлөгдөөд тэнд байгаа хөрөнгийн удирдлагын зохицуулалт энэ хууль руу болоод бусад зохицуулалтыг нэмж оруулж ирнэ гэдэг ийм байдлаар энэ хуулийн төсөл дагах хуулийг хэрэгжүүлэх тогтоол дээрээ тусгаад явж байгаа.

Тийм учраас Засгийн газар дээр хууль өөрөө товчхон учраас тодорхой. Энэ хөрөнгө оруулалтын бодлого нь тодорхойлогдоно.

Тэгээд тэр бодлогынхоо дагуу Их Хурал дээр төсвийнхөө төсөөлөл, хөрөнгө оруулалтынхаа төлөвлөгөө, бүгдийг нь оруулж ирээд ингээд Их Хурал дээр нэгдсэн төсвийнхөө нэг хэсэг болгож батлуулаад, тэгээд үүнийхээ хэрэгжилтийг хангуулаад л явна гэж. Ийм байдлаар л энэ хууль боловсруулагдсан байгаа юм. Тийм.

Г.Занданшатар: Г.Ганболд
гишүүн тодруулья.

С.Наранцогт: Энэ цаг амжихгүй байна. “Эрдэнэс Монгол”-ын талаар дараагийн асуулт дээр нь.

Г.Занданшатар: Гочоогийн
Ганболд гишүүн тодруулж асууна. 1 минут.

Г.Ганболд: Би ерөөсөө огт асуултаа хариулт авсангүй.

Би нэг л юм ярьж байна шүү дээ. Засгийн газрын өрөө, гадаадын өрөө аваад явах энэ зохицуулалтаа яг энэ хуульдаа тодорхой хийгээд өгчхөж болохгүй юм уу?

Гадаадын хөрөнгө оруулалт, зах зээлийн хөрөнгө оруулалт хийнэ гэхээр чинь хүүтэй мөнгө л зээлнэ гэсэн үг шүү дээ. Гэтэл бид ялгаа байхгүй яг Засгийн газар чинь гаднаас хүүтэй доллароор мөнгө зээлээд байхгүй юу.

Тэгээд репо маягийн юм хийгээд. Бид гадаадад өртэй байснаас. Одоо монголчууд чинь байнга л ярьж байна шүү дээ. Гадаад өр замбараагаа алдлаа гээд.

Тэр өртэй байснаас баялгийн сандаа өртэй л явж байвал “Баялгийн сан” маань ч.

Засгийн газар тэртээ тэргүй баталгаатай төлж байгаа юм чинь. Тэр маань өсөөд үржээд баталгаатай явах. Нөгөө талаасаа гадаад өр зээлээсээ ингээд нэг салаад явах ийм зохицуулалттай энд хийчхөж болохгүй юм уу л гээд байгаа шүү дээ.

Түүнээс би энэ дээр тэр хөрөнгө оруулалтын юм дараа нь журам гарах юм уу, яах юм.../минут дуусав/

Г.Занданшатар: 5 номер.

С.Тулга: Сангийн яамны хэлтсийн дарга С.Тулга. Гишүүний асуултад хариульа.

Үндэсний баялгийн сангийн хуулийн үндсэн агуулга нь ирээдүй хойч үе, өнөө үедээ тэгш байгалийн баялгийг хүртээмжтэй хуваарилах гэсэн агуулгаар орж ирж байгаа.

Энэ агуулгаар ирээдүй хойч үедээ хуримтлуулах хөрөнгийг бид “Ирээдүйн өв

сан”-даа хуримтлуульа гэсэн Норвегийн баялгийн сангийн үндсэн баялгийн сангуудын гол зарчимд нийцсэн хууль бол “Ирээдүйн өв сан” тухайн үедээ батлагдаж байсан.

Тухайн үед олон улсын сайн жишгүүдийг судалж үзэхэд олон улсын зөвлөхүүд маань юу гэж зөвлөж байсан гэхээр “Ирээдүйн өв сан”-гаас хийх гэж байгаа хөрөнгө оруулалт чинь танай улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болохгүй.

Ингэх юм бол аюулгүй байдал, найдвартай байдал энэ зэрэг алдагдах юм. Энэ агуулгаараа “Ирээдүй өв сан”-гийн тухай хуулийн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 12.1.7 дээр Монгол Улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болохгүй гэсэн ийм заалт байгаа.

“Ирээдүй өв сан”-гийн хөрөнгийг Монгол Улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хийж болохгүй гэсэн.

Өөрөөр хэлбэл хоёр дахь зах зээлээр Монгол Улсын Засгийн газрын бондыг худалдаж авч болохгүй.

Бусад улсын бондыг худалдаж авч болно.

Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын бонд “Дабл Эй”⁴[\[Credit Rating AA+\]](#) зээлжих зэрэглэлийн үнэлгээтэй бусад улсын Засгийн газрын бондыг худалдаад авахад чөлөөтэй.

Зөвхөн Монгол Улс бүртгэлтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө

⁴ **AA+** Зээлжих зэрэглэлийг АНУ-ын Standard & Poor's, Fitch, Moody's гэсэн гурван агентлаг тогтоодог. AA+ зэрэглэл нь зээлийн эрсдэл маш бага бөгөөд үнэт цаас гаргагч нь өр төлбөрөө төлөх чадвар өндөр байгааг харуулдаг.

хийж болохгүй гэсэн ийм зохицуулалттай байгаа.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн алга байна.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа.

Одоогоос 3, 4 жилийн өмнө Г.Занданшатар даргын Асгатын мөнгөний ордыг төрд буцааж авч байгаа нэг үйл ажиллагаа явуулсан л даа. Бичлэг. Энэ үйл ажиллагаа үнэхээр эзэн нь юмаа мэддэг юм, Монгол төр байдаг юм гэдгийг иргэд, олон нийтэд мэдрүүлсэн, итгэл төрүүлсэн ийм ажиллагаа болсон гэж би хувьдаа боддог.

Өнөөдөр манай парламентад олон жил сууж байгаа гишүүд энэ Баялгийн сангийн тухай хуулийг боловсруулж, хэлэлцэж эхлүүлэх юмсан гэж олон жил гадаад, дотоодыг судалсан, явсан байдаг юм билээ.

Энэ парламент энэ бүрэн эрхийн хугацаанд олон эрх зүйн шинэчлэлүүдийг хийсэн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн.

Гэхдээ энэ олон эрх зүйн шинэчлэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс илүүтэйгээр энэ Баялгийн сангийн хуулийн орж ирж байгаа асуудал энэ бүрэн эрхийн хугацааны эрх зүйн шинэчлэлийн хамгийн том чухал хэсэг гэж би хувьдаа харж байгаа.

Ард түмэндээ амласан амлалтын томоохон нэг хэсэг гэж харж байгаа.

Тийм учраас энэ хуулийг хувь гишүүнийхээ хувьд яахын аргагүй дэмжих ёстой хууль гэж бодож байгаа.

Яг үүн шиг Асгатын мөнгөний ордыг төрд авсан шиг дараа дараагийн янз бүрийн арга, хулгай луйврын аргаар төрийн мэдлийн стратегийн ордуудыг хувьд авчихсан энэ ордуудыг эргүүлж авах үйл ажиллагаа дахин хийгдэх үү? Шуудхан асуухад гэдгийг нэгд асууя.

Хоёрт, манайх 16 стратегийн ордтой юм байна. Энэ ордын үнэ цэн ер нь өнөөгийн байдлаар ямар үнэлгээтэй байдаг юм бэ? Ямар үнэлгээтэй байдаг юм?

Бид чинь газар доороо ер нь ямаршуухан үнэлгээтэй. Баялагтай баялагтай л гээд байдаг. Ямаршуухан хэмжээний баялагтай улс орон юм бэ? Үүний одоо тооцоо, судалгаа юм байна уу, үгүй юу?

Хууль хэрэгжсэнээр цаашдаа Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд, Монгол Улсын төсөвт яаж нөлөөлөх юм? Хэдий хэмжээгээр нэмэгдүүлнэ гэж тооцож байгаа вэ? Эдийн засгийн тооцоо, судалгаа нь юу байна вэ? Үүнийг тодруулж өгөөч.

Хуульд хүлээлгэх хариуцлага гэж байгаа. Хуулийг зөрчсөн бол Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ гэж. Би энэ Зөрчлийн хуулийг нь авчихмаар байгаа юм.

Ерөөсөө энэ хуулийг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг баймаар байна.

Тэгээд л нэг Зөрчлийн хуулиар торгуулийн хэдэн цөөхөн мөнгөөр торгуулаад л өнгөрдөг.

Энэ корпорац, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орж байгаа улсууд ямар томоохон хариуцлага хүлээж тэнд сууж байгаа вэ гэдгийг.

Тэгээд тэнд гарах гэж байгаа шийдвэрт хараат бусаар бие даасан байдлаар яаж шийдвэр гаргаж байгаа вэ гэдэгт маш чухал асуудал.

Удирдах зөвлөлд орж байгаа улсууд Зөрчлийн хуулиар бус Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг байх ёстой гэж би хувьд хувьдаа үзэж байгаа юм. Үүнийг юу гэж үзэж байна вэ гэж.

Удирдах зөвлөл нь байгуулагдах юм байна. 9 гишүүнтэй байх юм байна. Томилгоог нь Улсын Их Хурал томилно л гээд оруулчихсан байна.

Нийтийн сонсголоор орох уу? Одоо бид чинь томилгооны сонсголыг хийдэг болчихсон.

Яг энэ Баялгийн сангийн корпорацын Удирдах зөвлөлд орох бүрэлдэхүүнийг нийтийн сонсгол, томилгооны сонсголоор оруулдаг байх уу?

Г.Занданшатар: Дашзэгвийн Амарбаясгалан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга.

Д.Амарбаясгалан: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт, өнөөдөр орж ирсэн төсөлд энэ корпорац гэж байгуулах төсөл байхгүй. Удирдах зөвлөлийн 9 гишүүн гэж бас байхгүй.

Тэгэхээр буруу төсөл харсан юм шиг байна.

Ер нь яг л өмнө нь **“Хөгжлийн банк”** дээр ийм тусдаа бүтэц, корпорац байгуулаад Хөгжлийн банк удирдаж ажилласан. Сүүлдээ 2013 онд тухайн үеийн Засгийн газар оруулж ирж, Засгийн газрын

хуралдаанаар хэнд зээл олгох асуудлыг хүртэл шийддэг болчихсон байсан.

Тэгэхээр Засгийн газар давхардсан данс, бүтэц гаргахгүйн тулд Улсын Их Хурлаар Баялгийн сангийн үйл ажиллагаа, ерөнхий бодлогыг гаргаж батална. Хэрэгжүүлэхээр Засгийн газар ажиллана гэж зохицуулалтыг нэгдүгээрт оруулж ирж байгаа.

Хоёр дахь нь, стратегийн ордуудын талаар асуулаа.

Түрүүн С.Наранцогт захирал бас хариулж байсан. Нийт **“16 ордыг стратегийн орд”** гэж Улсын Их Хурал баталсан байдаг. Үүний

- 7 нь “Эрдэнэс Монгол”-д,

- 9 нь “хувийн хэвшилд” байна.

Хувийн хэвшилд байгаа стратегийн орд хуулийн зохицуулалтаараа

■ *өөрсдийн хөрөнгөөр хайгуул хийсэн бол төрд 34 хувь нь,*

■ *төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бол төрд 51 хувь нь* байх

ийм ерөнхий зохицуулалттай.

Тэгээд тухайн ордууд Засгийн газартай, Улсын Их Хуралтай гэрээ байгуулж, тогтоол гаргуулж, хамтарч ажилласан тохиолдлууд байгаа юм.

Жишээ нь, Нарийнсухайтын нүүрсний орд гэхэд 2005 оны 07 дугаар сарын 04-ний өдөр 10 жилийн хугацаатайгаар тогтвортой байдлын гэрээг байгуулан ажилласан. Энэ хугацаа дуусаад үндсэндээ 9 жил гаруй хугацаа өнгөрчихсөн байж байна.

Цагаан суваргын зэс, молибдены орд гэхэд Улсын Их Хурлын 2014 оны 54 дүгээр тогтоолоор төр хувь эзэмших шаардлагагүй гэж үзсэн шийдвэрийг гаргуулсан байгаа юм. Улсын Их Хурал дээр.

Тэгээд энэ шийдвэрээ түрүүн Ерөнхий сайд хариулт дээрээ хэлж байсан. Үндсэн хуулийн цэцээр хүртэл асуудлыг оруулж шийдвэрлүүлэх ийм алхам хийгдсэн гэж ингэж явж байгаа.

Төмөртөө овооны цайр, хар тугалгын орд гэж орд байна. 1998 онд 15 жилийн хугацаатайгаар тогтвортой байдлын гэрээг байгуулсан байгаа юм.

Тэгэхээр Засгийн газар таны асуултад юу гэж хариулах вэ гэхээр хүний хувийн өмчийг хурааж авна гэхээсээ илүүтэйгээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын Их Хурлын тогтоол хууль хэрэгжүүлэх чиглэл дээр анхаарал хандуулж ажиллана гэсэн үг.

Тогтвортой байдлын гэрээний хугацаа дууссан бол тэр хугацаа дууссантай холбогдуулан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, эргээд “Хуримтлалын сан”, “Баялгийн сан”-д үр өгөөж өгөх тэр боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Өнөөдөр “Баялгийн сан” дээр орж ирж байгаа “Ирээдүйн өв сан”-гийн орлого бүрдүүлэлт тал дээр жишээ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр. Мөн дээрээс нь төрийн өмчит уул уурхайн компаниудын 34 хувийн ногдол ашгаас эдгээр сангуудын эх үүсвэр бүрдэхээр байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Асгатын мөнгөний ордыг ч улсад шилжүүлж авсан. Салхитын мөнгөний ордыг шилжүүлж авсан.

Тэгэхдээ сая яриад байгаа шиг хувийн өмчийг ингээд шууд авчихсан асуудал биш шүү.

Ерөнхий сайдын сая хэлээд байгаа энэ АМНАТ-ын хулгай, баялгийн хулгай гурван хэлбэрээр явагдаж байгаа юм.

Нэгдүгээрт, Салхитын мөнгөний орд бол төрийн өмчийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн орд газрыг хууль бусаар лицензийг нь аваад, дамлан наймаалцаж, худалдсанаар гадаад, дотоодын иргэнд очоод, түүнийгээ ахиж хулгай, луйврын аргаар Криминалистикийн төвд хахууль өгч гарын үсгийг нь хуурамчаар үйлдсэн, болгосон гэх мэтчилэн.

Тэгээд хууль хяналтын байгууллагуудын маш олон хүнд авлига өгч үүнийгээ залруулсан, зассан ийм гэмт хэргийн шинжтэй үйлдэл нь тогтоогдсон. Гурван шатны шүүхээр тогтоогдсон.

Хоёрдугаарт нь, энд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 10 дахин, маш их бага хэмжээгээр төлдөг.

Геологийн төв лаборатори, элдэв газрууд авлига, хээл хахууль өгөх замаар доторх мөнгөний орцыг нь маш багаар үнэлээд гадагшаа хүдэр гаргахаар маш бага татвар төлдөг.

Үүнийг АМНАТ-ын тооллого хийж, энэ бүх уул уурхайн компаниуд дээр байж болзошгүй үзэгдэл.

Гуравдугаарт, байгаль орчны нөхөн сэргээлт хийгдээгүй.

Ингээд Ашигт малтмалын хуулийн 5, 6 заалтыг зөрчсөн тохиолдолд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хуулийн хүрээнд авагдсан арга хэмжээ бөгөөд энэ нь хууль, шүүхийн

байгууллагууд, Криминалистикийн төвд удаа дараагийн авлига өгсөн нь Авлигатай тэмцэх газрын нотлох баримтаар нотлогдоод авлига өгөхөөр завдаж байсан сая хэдэн зуун мянган доллар билээ. Тэр нь хураагдсан.

Ийм маш олон гэмт хэргийн шинж чанартай үйлдлийн улмаас Монголын баялгийн хулгайг яаж хэрэгжүүлж байсан гэдэг ганцхан, жижигхэн ордоор харагдсан.

Одоо гагцхүү ордын ашиглалтыг тэр зөв ашиглах асуудал дээрээ энэ жишээг авч Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрэгжүүлэх нь чухал байгаа юм гэдгийг бас онцлон тэмдэглэж хэлье гэж бодлоо.

Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Баялгийн сангийн тухай хуулийн төслийг дэмжиж байна.

Хожигдож байгаа ч гэсэн бас цаг үеэ олж орж ирж байна. Үүнийг бид тал талаасаа ярилцаад маш сайн ажиллаад гаргах ёстой гэж бодож байна. Яг өнөөдөр Монголын нийгэмд тулгамдсан гурван асуудал байгаа.

Нэгдүгээрт, Монгол Улсын хөгжлийн бодлогын асуудал.

Энэ дотор энэ баялгийн менежментийн асуудал. Монгол Улс цаашдаа яаж хөгжих юм? Сая тэр Тавантолгой дээр БЭТ_[бүрэн эрхт төлөөлөгч] томилоод ажилласны үр дүнд Монголын ард түмэн хувьцааны ногдол ашиг авчихна шүү дээ. Өдий төдий тэр оффтейк гэрээ, хулгай. Тэгээд урьдчилж авсан, аман дээрээс худалдах байсан мөнгийг төлөөд тэгээд цаад талд нь 2 жилийн хугацаанд 4.5 их наяд төгрөгийн ашигтай ажиллаж байна шүү дээ.

Тэгээд Монголын хөгжлийн гарц юу гэхээр баялгийн менежментээ зөв хийх, баялаг дээрээ суурилсан хөгжлийн бодлогыг л гаргаж ирэх шаардлага байгаа.

Энэ утгаараа Баялгийн сангийн тухай хууль цаг үеэ олж байна.

Хоёрдугаарт, Боловсон хүчний асуудал, манлайллын асуудал.

Энэ байхгүй. Одоо аливаа хөгжилд хүний үүрэг роль онцгой ач холбогдолтой. Энэ дээр анхаарах ёстой.

Гуравдугаарт, Авлигалын асуудал.

Сая Ерөнхий сайд маш тодорхой ярьж байна. Авлигыг ялж чадвал Монгол Улс хөгжинө. Авлигыг ялахгүй Монгол Улс хөгжихгүй.

Энэ дээр маш сонирхолтой судалгаа гаргаад ойрын үед Та бүгдэд тараахаар бодож байгаа.

Ингээд манай эрдэс баялгийн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 33 орчим хувийг эзэлж байгаа юм.

Яг үнэндээ манай дотоодын нийт бүтээгдэхүүн жижигхэн шүү дээ. 16, 17 тэрбум доллар. Гаднын нэг жижиг компанийн л борлуулалтын орлого шүү дээ.

Тэгэхээр эдийн засгаа тэлэх хэмжээгээр энэ баялгийн эзлэх хувь бас тэлэгдэж явах ёстой. Энэ хэмжээгээрээ өгөөж нь нэмэгдэх ёстой. Ийм л учиртай л даа.

Тэгээд уул уурхайн салбарт өмнө нь хийгдсэн нэг чухал асуудал.

Энэ нь **“Уул уурхайн биржийн тухай хууль”**.

Үүнийг Улсын Их Хурлын даргаас ажлын хэсэг байгуулж биднийг бас нэлээн шахаж шаардаж үүнийг гаргасан.

Өнгөрсөн жил Монгол Улсын экспортод гарч байгаа нүүрсний 20 орчим хувь нь одоо бараг 10 их наяд төгрөгийн борлуулалтыг хийчихсэн байгаа.

Одоо он гараад эхний 3 сарын байдлаар бас сайн ажиллаж байгаа. Тэгэхдээ бодох анхаарах юмнууд байгаа. Үүнийг ингээд ажиллах ёстой гэж ингэж бодож байна.

Ингээд одоо өнөөдөр дэлхийн хэмжээнд. Энэ их шинэ юм биш л дээ. Одоо дэлхийн хэмжээнд 456 “Баялгийн сан” бүртгэгдсэн байгаа. Яг идэвхтэй үйл ажиллагаа явж байгаа 176 сан байна л даа.

Энэ сангуудыг аваад үзэхээр манайхан чинь энд тэнд, тэр Норвегид, **“TEMASEK”**-т зөндөө очоод үзчихсэн байна.

Хамгийн бидэнд их ойрхон байгаа сан бол **“Казахстаны хөгжлийн сан”** байгаа шүү.

Казахстанчууд үнэхээр энэ КОВИД-ын үед баялгаа яаж худалддаг, тэр сангаа яаж өргөжүүлдэг гэдгийг жинхэнэ үлгэр жишээ хийсэн.

Өнөөдөр тэр **“САМРУК”** /SAMRUK KAZYNA/ гэдэгтэйгээ нийлэхээрээ бараг 160 тэрбум долларын сантай болчихсон байгаа.

Тэгээд ер нь аливаа зүйл хөдөлгөөнтэй байж хөгждөг, эрүүл байдаг.

Энд хөрөнгийн удирдлагын компани байгуулах юм байна. Гадна, дотнын их мундаг мэргэжилтнүүд биш ч гэсэн тэнд ажиллаж байсан бас тийм ахмад улсууд Монголтой бас хамтарч ажиллаж гэсэн тийм санал, санаачилга байдаг юм гэсэн.

Тэгэхээр энэ “Ирээдүйн өв сан” дээр одоо алдаа гарсан шүү.../минут дуусав/

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Та нөгөө хөрөнгийн удирдлагын компанийн талаар асууж байна гэж ойлгож байна.

Тэгэхээр хууль хэрэгжүүлэх тогтоол дээр яг тодорхой заагаад өгсөн. “Ирээдүйн өв сан”-гийн корпорацын хөрөнгийн удирдлагын компанийн хэрэгжээгүй энэ заалтыг сайжруулж, энэ хуульд оруулж ирэх энэ үүрэг даалгавар бол Засгийн газарт. Энэ институцийг бэхжүүлэх ажиллагаа хоёр нь хамтдаа өгөгдөж байгаа.

Тэгээд яагаад энэ хууль хэрэгжээгүй вэ гэхээр Норвегийн сангийн яг хөрөнгийн удирдлагын тэр засаглал, тэр схемийг нь хуульчилсан. “Ирээдүйн өв сан” дээр.

Тэгээд яг хэрэгжүүлэх гээд хууль батлагдсан чинь боловсон хүчин. Энд төвлөрч байгаа мөнгө нь “Хүний хөгжлийн сан”-д нэг их наяд төгрөгийн өртэй. Үйл ажиллагаагаа санхүүжүүлэх ч бололцоогүй.

Энэ компанид нэлээд олон улсын түвшинд бэлтгэгдсэн, цалин хөлс өндөртэй чадварлаг боловсон хүчин ажиллах ёстой байдаг.

Тэрийг нь Дэлхийн банкны **RAMP** [Reserves Advisory and Management Program] хөтөлбөртэй хамтарч бэлдэх гэсэн чинь ингээд КОВИД болсон.

Иймэрхүү шалтгаанууд үүссэн. Одоо ч гэсэн бид шууд энэ хуульдаа оруулаад ирэх гэхээр нэгдүгээрт үндсэн зарчмаа тодорхойлсон товчхон хууль хийе гэдэг дээр нэг тал нь их болоод бас асуудал үүсэж байгаа.

Нөгөө талдаа бас л ялгаагүй шууд бэлэн боловсон хүчин, нөөц бололцоо байхгүй байгаа.

Тэгэхээр энэ хуулийн зохицуулалт 2030 он хүртэлх энэ “Ирээдүйн өв сан”-гийн энэ орлогын хэсгээс бусад хэсэг тэр чигээрээ мөрдөгдөөд 2030 онд зарцуулалтынхаа хувьд ч тэр, “Ирээдүйн өв сан”-гийн концептод өөрөө өөрчлөлт орж ирж байгаа учраас тэр үед нь энэ корпорацынхаа удирдлагын яг институцийг бэхжүүлээд, Засгийн газар тэр хуулийнхаа зохицуулалтыг энэ хууль дээр нэмээд, магадгүй бусад төрөлжсөн сангийн удирдлагатай холбоотой бас сайжруулж оруулж ирэх шаардлагууд гарах байх.

Тэгэхээр үндсэн концепц бол хэвээрээ. 2030 он дээр эдгээр зохицуулалтууд энэ хууль дээр нэмж орж ирэхээр Улсын Их Хурлын хууль хэрэгжүүлэх тогтоол дээр оруулж ирж байгаа юм.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Одоо энэ Баялгийн сангийн их олон сан байна л даа.

Дэлхийн хэмжээнд аваад үзэхээр 6 сан голдуу байгуулсан байна. Тийм. Манайх 3-аар ингэж орж ирж байгаа.

Бүгдийг нь нэг амьсгаагаар өнөөдөр цоо шинэ юмыг хийгээд амжилтад хүрчихнэ гэж байхгүй.

Тэгэхээр оруулж ирж байгаа энэ хэлбэр нь зүйтэй. Үүгээр сангаа байгуулаад цаашаагаа явах боломж байна гэж үзэж байгаа.

Хамгийн гол нь юу гэхээр энэ цугларч байгаа мөнгөө 2030 он хүртэл эрсдэлээс яаж хамгаалах вэ гэдгийг л.

“Ирээдүйн өв сан” чинь одоо 2022 оны ханшийн 20 хувийн өсөлтөөр 800-аад тэрбум төгрөг ханшийн үнээр алдчихсан шүү дээ. Тухайн үед валютаараа байсан бол өнөөдөр 800-аад тэрбум төгрөг илүү байх байсан юм.

Тийм учраас энэ Баялгийн сангийн хууль дээрээ нэгэнт бий болсон энэ хуримтлалыг хамгаалах чиглэлд, өсгөж үржүүлэх чиглэлд л.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ.

Тэгээд ер нь түрүүн бас яриад байна лээ. “Ирээдүйн өв сан”-гийн корпорацыг нь байгуулах асуудлыг хойшлуулаад, хууль хэрэгжээгүй учраас тэр корпорацын удирдлага зохион байгуулалт маш сайн хийсэн хууль байсан юм билээ.

Түүнийгээ хэрэгжүүлээгүй учраас энэ хөрөнгийн удирдлага нь, хөрөнгө оруулалт нь төгрөгөөрөө үнэгүйдэх ийм нэг нөхцөл болсон.

Тэгээд одоо ч гэсэн Хөгжлийн банкныг бас тэр хуульд заасан боловч хэрэгжээгүй гээд хэлчхээд байна л даа.

Хуулиа хэрэгжүүлээгүй байхгүй юу. Хөгжлийн банканд чинь. Нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгэх удирдлагын багийг сонгон шалгаруулна гэдгийг 2012

онд өөрчлөөд л тэгээд л тэр чигээрээ явчихсан.

Тэгэхээр энэ сан дараа нь элдэв сангууд шиг болохгүйн тулд бие даасан удирдлагын тэр “Норвегийн сан” шиг, тэр “Ирээдүйн өв сан”-гийн хуулийг тэрнээс хуулбарлаж хийсэн юм билээ. Түүн шиг хараат бус, бие даасан, мэргэжлийн удирдлагын ажиллах нөхцөл, бололцоог хангасан, улс төрийн нөлөөлөлгүй байх бололцоонуудыг хангасан тийм нөхцөлийг бүрдүүлэх нь ер нь хамгийн чухал гэдгийг Б.Баттөмөр гишүүн бас онцолж тэмдэглээд байна л даа.

Тэгэхгүй бол тэгээд л ахиад л нэг авлигын асуудал. Тэгээд л баахан хүн сүүлд нь чирэгддэг нэг ийм юм болох вий гэж байгаа юм.

Одоо Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дэмжиж байгаа.

Тэгээд одоо бид хуримтлалын санд хуримтлагдсан мөнгөөрөө бонд худалдаж авах, хувьцаа худалдаж авах, банканд өндөр хүүгээр хадгалуулах ч гэдэг юм уу, есгөх хуримтлалуудыг бас бий болгох талаар энэ дээр тусгагдсан байгаа юу?

Хоёр дахь асуудал. Бид энэ Үндэсний баялгийн сангаа цаашдаа тогтвортой явуулахын тулд Ашигт малтмалын тухай хуулийг яаралтай оруулж ирэх хэрэгтэй.

Өнөөдөр газрын доор ямар эрдэс баялаг байгаа юм. Дараагийн стратегийн орд нь тодорхой юм уу, тодорхой бус юм уу гэдэг нь тодорхойгүй байгаад байгаа шүү дээ.

Тийм учраас хайгуулын ажлыг эрчимжүүлэх, ялангуяа бид газрын доор байгаа баялгуудаа мэдэж авах талаар ер нь онцгой анхаарах болов уу гэсэн бодолтой байна. Бас Хөгжлийн сантай байна.

Тэгээд энэ уул уурхайтай аймгуудаа ер нь цаашдаа яах юм? Мэдээж “Хөгжлийн сан”-гаар томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх байх.

Тэгэхээр энэ уул уурхайтай Дорноговь аймаг, Өмнөговь аймгийнхаа дэд бүтцийн асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй. Би энэ дээр нэг заалт оруулж өгөөч л гэж бодож байгаа юм.

Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын асуудлыг энд ярих юм бол ингээд Өмнөговь ч юм уу, Дорноговь аймагт ч юм уу томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийгддэггүй, хаягддаг.

Тэгэхээр баялгийн үндэсний санд хуримтлагдаж байгаа мөнгө бол ихэвчлэн Өмнөговь аймаг болон говийн аймгуудаас орж ирж байгаа мөнгө байгаа.

Тэгэхээр энэ хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалтынхаа асуудлыг энэ баялгийг оруулж байгаа стратегийн орд байж байгаа энэ аймгуудын дэд бүтцийг нэн тэргүүнд нь шийднэ ч гэдэг юм уу, ийм үг, үсэг оруулахгүй бол энэ мөн ялгаа байхгүй гээд Өмнөговь аймагт ч хөрөнгө оруулалт хийгддэггүй, Дорноговь аймагт ч хөрөнгө оруулалт хийгддэггүй, тэр бүс нутгийн ард иргэд нь ч гэсэн баялгийнхаа хувийг хүртэж чаддаггүй яг л ийм байдалтай явна, наадах чинь.

Тэгэхээр энэ дээр нэг тодорхой заалтыг оруулж өгөхгүй бол болохгүй байх гэсэн бодолтой байна.

Дөрөв дэх асуудал. Энэ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн бас

тодорхой хувиуд нь орон нутагт “Орон нутгийн хөгжлийн сан”-гаар дамжиж орж байгаа.

Тэгээд үүний хувь хэмжээг бас нэмэгдүүлэх талаар онцгой анхаарахгүй бол цаашдаа дахиж уурхай нээх, хайгуул хийх, олборлох энэ үйл ажиллагаа чинь ер нь цаашдаа нэлээн их хүндрэлтэй учрах юм байна лээ шүү. Учрах юм байна лээ.

Тэгэхээр энэ бүс нутгууд руугаа хийх хөрөнгө оруулалтаа эрүүл мэнд, боловсрол, томоохон хэмжээний зам харгуй, усны асуудлыг нь шийдэж байж цаашдаа говийн бүсийн энэ стратегийн ордуудаас оруулж байгаа хөрөнгө оруулалтыг л татаж авах, мөнгийг нь Үндэсний баялгийн сандаа оруулах талаар нэлээн онцгой анхаарч ажиллахгүй бол болохгүй байх гэсэн бодолтой байна. Миний хувьд. Энэ дээр нэг хариулт авъя.

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт. “Эрдэнэс Монгол” гүйцэтгэх захирал.

С.Наранцогт: Хөрөнгө оруулалтын бодлогын хувьд түрүүн манай гишүүд ярьж байна. Их Хурлын дарга хэлсэн.

Бид хэд өмнө нь ийм жоохон муу туршлагууд байгаа учраас 2030 он хүртэл дунджаар сангуудад 3 санд 4.8-аас 2.8 их наяд төгрөгүүд цуглах болов уу гэсэн ийм төсөөлөлтэй байгаа.

Тэгэхээр энэ хүртлээ явах хооронд хөрөнгийн удирдлагын компани, бусад зүйлүүдээ чадавхжуулах, бэлдэх гэдэг ажил Засгийн газар дээр хийгдэнэ.

Энэ хүртэл сангаа үүсгэж аваад, яг энэ сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг Засгийн газар дээр боловсруулаад Их Хурал дээр орж ирээд явах нь бас өмнөх

энэ муу туршлага, энэ авлига, хулгай зэлгийн асуудал үүссэний дараа 2030 он хүртэл ингээд явчихвал бас зөв юм болов уу. Их Хурал дээрээ ирээд төсвөө ярьдаг шигээ энэ төслүүдээ яриад.

Том төслүүдийн хувьд орон нутгийн олборлолт явуулж байгаа дээр илүү мөнгө хуваарилагдах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх тухай ярилаа.

Тэгээд энэ бол хоёр аргаар хэрэгжинэ гэж бодож байгаа.

Нэгд, яах вэ, энэ төсвийн харилцаанд орж байгаа “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн АМНАТ-аас хуваарилагдаж байгаа дүнд бид ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй.

Одоо явж байгаа, хуваарилагдаж байгаа журмаараа яг олборлолт явагдаж байгаа аймаг, орон нутагт арай илүү “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгө хуваарилагдаж байгаа шүү дээ.

Нэгдүгээрт, тэр зарчмаараа хуваарилагдаад орон нутаг, бүс нутагтаа өөрсдөө төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх бололцоо нь нээгдэнэ.

Хоёрдугаарт, стратегийн орд газар эзэмшигч компаниуд өргөжих.

Таны хэлдэг ус, цахилгаан, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх энэ механизм нь өөрөө бас их учир дутагдалтай байсан. Үүнийг нээж, яг энэ стратеги дээр. Тухайлбал, газрын усны төсөл, тэр боловсруулах үйлдвэрүүд, дэд бүтцийн цахилгаан, эрчим хүчний төслүүд энэ тэр гээд. Тэр нь нэгдлийн стратеги төлөвлөгөөгөө хийгээд бид батлуулчихсан байгаа.

Тэр төслүүдээ бас санхүүжүүлэхэд зарцуулах бололцоог нь хуулиар нээж өгч байгаа.

Энэ хоёр талдаа нэгдүгээрт яг энэ олборлолт явж байгаа уул уурхайн компаниудаа хариуцлагажуулах, дэд бүтцийн төслүүдээ хэрэгжүүлэх бололцоог нь нэмэгдүүлэхээс гадна энэ компаниудыг бас ногдол ашиг төвлөрүүлж “Хуримтлалын сан”-гийн орлогыг тогтвортой нэмэгдүүлэх ийм хөшүүрэг болох юм гэж үзэж байгаа юм.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Эхлээд тэр Ашигт малтмалын хуулийг хариулахаас өмнө уул уурхайтай аймгуудад орон нутагт нь өгөх үр өгөөжийн тал дээр Уул уурхайн яам Т.Энхтүвшин гишүүнтэй санал нэг байгаа.

Ер нь Ашигт малтмалын хууль Сангийн яамтай зөвшилцөхөд нэлээн хол байгаа зүйл бол АМНАТ-ын төлбөрийн 20-иос 30 хувийг бид орон нутагт нь үлдээ гэдэг ийм зүйл, заалтыг хуульдаа оруулсан байгаа юм.

Тэгээд Сангийн яам одоо бараг 4 сар дотооддоо ярьж байна. Яг энэ дээр бид бас тохиролцохгүй байгаа зүйлүүд байна.

Сангийн яам бол улсын төсвийн АМНАТ-ын орлого буурна гэсэн байр суурьтай саналаа өгөхгүй байгаа.

Үүнээс шалтгаалаад ашигт малтмалын хууль Их Хурал руу орж ирэхгүй байна.

Мэдээж Сангийн яамны байр суурийг бид бас хүндэтгэж байгаа. Гэхдээ одоо тантай. Би юу байна гэхээр ер нь С.Наранцогт захиралд ч хэлж байгаа, Хэрэг эрхлэхийн сайдад ч гэсэн хэлж байгаа.

Эхлээд энэ саалийн үнээгээ томруулах хэрэгтэй. Одоо байнгын сүүтэй байлгах. Яг энэ уурхайн салбараа, том том уурхайнуудаа ядаж нүүрсээ угааж гаргадаг байх хэрэгтэй байна. “Эрдэнэс Тавантолгой” компани.

“Эрдэнэс Тавантолгой” компани ядаж цахилгаан станцаа өөрөө шийдмээр байна, усаа шийдмээр байна. Цаашдаа орлогоо бууруулахгүй байх. Бусад улсын уурхайнуудтай хөл нийлүүлэх, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх энэ ажил руугаа анхаарах хэрэгтэй.

Тэгэхгүй бол олж байгаа мөнгийг нь хувааж авна гэдгээ сайхан ярьж байна. Энэ бол сайн. Маш сайхан зүйл ярьж байгаа. Гэхдээ тэр компани маань яаж мөнгө олох вэ, яагаад мөнгөө таслахгүй байх вэ гэдэг тэр зүйлийг бас анхаарах хэрэгтэй.

Г.Занданшатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Энэ баялгийн сангаа байнга л бид нэмэгдүүлж байх л учиртай л даа.

Тийм учраас газрын доорх баялгуудаа хайх ажлыг л бид эрчимжүүлэх хэрэгтэй байна. Хайх.

Дараагийн стратегийн ордыг л бид олох ёстой шүү дээ. Тэгж байж “Ирээдүйн өв сан” ч гэдэг юм уу, “Хуримтлалын сан” ч гэдэг юм уу ингээд л өсөөд явна.

Мэдээж Оюу Толгой байна, Тавантолгой байна. Тодорхой хугацаа нь дуусна.

Тийм учраас бид эрчимтэй энэ хайгуулаа хийх, дараагийн стратегийн ордыг олох. Ер нь бид газар доор юу байгаа гэдгээ л мэдэх хэрэгтэй байна.

Ингэж байж цаашдаа “Баялгийн үндэсний сан” тогтвортой явах. Монгол Улс ч гэсэн тогтвортой хөгжлөө бас тодорхойлох бололцоо боломж л бий болох байгаа юм л даа.

Тэртээ тэргүй Монгол Улсын эдийн засгийн гол цөм нь энэ нь уурхайн эрдэс баялаг гэдэг нь тодорхой шүү дээ.

Тийм учраас энэ хайгуул дээр та тодорхой хариулт хэлж өгөөч.

Г.Занданшатар: Ж.Ганбаатар сайд хариулах уу? Жамбалын Ганбаатар.

Ж.Ганбаатар: Тийм ээ. Манай улсын хувьд энэ асуудал их тулгамдсан асуудал байгаа.

Тэгээд бусад улсын жишгийн дагуу манай агаарын геофизикийн салбарт Засгийн газраас 40.0 тэрбум төгрөг энэ 2024 онд тавьсан.

Тэгээд агаарын геофизик гэдгийг та юу гэж ойлгож байгаа вэ гэхээр бид хуучин одоо ингээд алх бариад 50 мянган зураглал, 200 мянган зураглал хийдэг байсан бол энэ хайгуулын компаниудын шаардлагыг хангахгүй болсон.

Тийм учраас орчин үеийн шаардлага хангасан тэр дата мэдээллийг бид энэ 40.0 тэрбум төгрөгөөр Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгийн тодорхой бүс нутагт гаргаж өгнө. 2024 ондоо.

Цаашдаа газар нутгийнхаа тал хээрийн бүсийг бүгдийг нь бид агаарын геофизикийн дэлхийн шилдэг технологиор энэ илэрцийг бий болгоно.

Тэр тохиолдолд хайгуулын компаниудад ядаж анхан шатын дата мэдээлэлтэй болох зорилтыг төр өөрөө

мэдээлэлтэй болох, төр өөрөө дата мэдээлэлтэй болох, тэр мэдээллийнхээ дагуу хаанаа юугаа ашиглуулахаа, хаанаа юугаа зарлахаа өөрөө мэдэж зарлах. Түүнээс биш хаа хамаагүй газар алт ухуулдаг, хаа хамаагүй газар нүүрс ашиглуулдаг ийм юм байхгүй гэдгийг энэ бодлого чиглэлийг барьж ашиглаж байгаа.

Энэ 40.0 тэрбум тавигдсан. Олон улсын тендер шалгараад дуусаж байгаа. Энэ жил харин их хурдтай явж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Нямаагийн Н.Энхболд гишүүн асуулт асууна.

Н.Энхболд: Баярлалаа. Энэ хуулийн үзэл баримтлалын хувьд хэлэлцэхийг дэмжиж байна.

Үндсэндээ гарч ирсэн суурь шалтгаан нь ер нь 2019 онд Үндсэн хуульд оруулсан баялгийн, ялангуяа уул уурхайгаас олж байгаа баялгийн үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гээд Үндсэн хуульд заасны дагуу энэ Засгийн газраас нийгэмд бий болоод байгаа уур амьсгал, практик шаардлага, энэ бүхнийг харгалзаж үзээд оруулж ирж байгаа.

Манайх намын бүлэг дээрээ ярьчихсан. Дэмжиж байгаа.

Тэгэхээр үүнийг хэлэлцэхийг дэмжиж байгаа.

Баялгаа ашиглахдаа мэдээж улс орон болгон янз бүрийн эрх зүйн зохицуулалтаар, янз бүрийн арга, хэлбэрээр ашигладаг.

Энэ үзэл баримтлал дотор жишээ нь бусад орнуудын

- *үндэсний баялгийн,*
- *тогтворжуулалтын,*
- *хадгаламжийн,*
- *ирээдүй хойч үеийн,*
- *тэтгэврийн,*
- *валютын нөөцийн,*
- *хөрөнгө оруулалтын,*
- *стратегийн хөгжлийн,*
- *хуваарилалтын сан* гээд олон хэлбэртэй байна.

Үүнийг тал талаас нь судалж байж бас өөрийнхөө онцлогт таарсан өнөөдрийн уур амьсгал, нөхцөл байдалд таарсан ийм зүйлийг оруулж ирж байна гэж бодож байгаа.

Түүнээс аль нэгийг нь бариад энэ нь их сайн юм байна гээд шууд хэрэглээд явах ямар ч боломж байхгүй.

Тэгэхээр Засгийн газар үүнийгээ олон талаас нь харж байж оруулж ирж байгаа гэж бодож байгаа.

Энэ бас нэг онцлог нь юу вэ гэхээр Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хууль болж байгаа юм. Хэдийгээр урьд нь олон янз бүрийн юм байсан ч гэсэн.

Цаашаа боловсронгуй болгоод энэ анхдагч хуулиа хөгжүүлээд явах ийм боломжууд байгаа.

Хамгийн гол хүмүүсийн, бид нарын анхаарлыг татах ёстой асуудал юу вэ гэхээр энэ удирдлагын тогтолцоо, хэлбэр, арга зам нь ямар байх юм бэ гэдгийг нэгдүгээрт.

Хоёрдугаарт, уул уурхайгаас олж байгаа ашгаа бусад салбараа хөгжүүлэхэд хэрэглээд, суурь бодлогодоо чиглүүлээд, түүнийхээ үр дүнд дахиад бий болсон эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг хойч үедээ хүртээх ийм үзэл дэлхий даяараа

байгаа. Энэ хүрээнд хийгдсэн гэж бодож байна.

Тэгэхээр надад нэг ийм санаа байгаа юм.

Үндсэн хуульд ард түмэнд дийлэнх хэсэг нь ногдоно гээд заачихсан нь ерөөсөө шууд тарааж өгөөд байхын хэлбэр гэж огт бодохгүй байгаа.

Хэрэв бид ямар нэгэн сан байгуулъя, үүнийгээ арвижуулдаг юмтай, зөв удирдлагатай байлгах ёстой. Арвижуулж байж нөгөөдөх тогоо маань томорно. Хуваах юм маань нэмэгдэнэ.

Тэгэхээр нөгөө дийлэнх нь ард түмэнд очно гэдэг энэ үзэл санаа нь улам нэмэгдээд явах юм байгаа юм. Дийлэнхэд нь очдог хэсэг томроод томроод явна.

Өмчийн хэлбэрийн хувьд жишээ нь энэ дээр дурдсан компаниуд, удирдах байгууллагууд нь төрийн өмчийн байж болно. Төр өөрөө түүнийгээ өөрөө улс төрчдийн томилгоогоор бий болсон бүтэц, удирдлагаар аваад явах уу, эсвэл хамгийн шилдэг чадвартай тийм багийг сонгож аваад түүгээрээ удирдуулаад явах уу гэдэг бол тусдаа асуудал.

Тэгэхээр би зарим гишүүдийн гаргаад байгаа саналтай санал нэг байгаа.

Төрийнх байвал наадах чинь тэгээд бас урьдах л жишгээрээ ингээд идэж уугаад дуусах вий дээ гээд санаа зовж байна.

Миний асуулт юу вэ гэхээр ингээд энэ байгууллагууддаа, бүтцүүдээ бий болгочихлоо. Үүнийг заавал Монголчууд, заавал улс төрчдийн томилсон удирдлагын баг аваад явах уу, эсвэл үүнийг гэрээгээр чадвартай, туршлагатай гадна, дотнын хэн ч бай заавал төрийн гэхгүй ийм гэрээтэй

байгууллагуудаар удирдуулаад л явах боломж бий юу?

Үүнийг харчхаад гишүүд энэ гурван яам л аваад явах юм байна. Энэ урьдын адил юм болно гээд байна л даа.

Тэгэхээр хэлэлцүүлгийн явцад өмч нь төрийнх байж болно. Удирдлагыг нь яахаа төр мэднэ. Тэр яах дотроо хамгийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй бол тодруулж асууна гэж байгаа. Санжаагийн Наранцогт. Гүйцэтгэх захирал. “Эрдэнэс Монгол” хариулья. 4 номер.

С.Наранцогт: Н.Энхболд гишүүний асуултад хариулья.

Энд хоёр институци яригдаад байгаа. Гишүүддээ би бас тайлбарлая.

Нэгдүгээрт, Орлого төвлөрүүлэгч төрийн өмчит компани гээд. Энэ 100 хувь гээд.

Үүний засаглал, үйл ажиллагаа, ТУЗ-ийг сонгон шалгаруулах. Эдгээр зүйлүүд нь олон улсын. Өөрөөр хэлбэл OECD гэдэг үгийг бид бас шууд хэрэглээгүй. Цаанаа OECD-гийн энэ төрийн өмчит компанийн удирдлагаар явахаар Засгийн газар өөрөө журамлана гээд хуульд оруулсан.

Энэ орлого төвлөрүүлэгч гэдэг нь толгой компани дээрээ хувьцаа эзэмшигч учраас төрдөө хамаараад баялгийн сангийн орлогыг бүрдүүлэх учраас төр өөрөө хуваарилалтаа хийх үйл ажиллагааг хариуцна гэдгээр оруулж байгаа.

Доод талын компаниуд мэдээж хувьцаат компани. Манай Тавантолгой гэхэд чинь 28 хувь нь иргэддээ оччихсон.

Ингээд хөрөнгө оруулалтын компаниуд гаднын хөрөнгө оруулалтаар ч гэсэн явагдаад ингээд тэр нээлттэй харилцаа компанийн сонгодог хэрэглэлээр явна.

Харин засаглалын хувьд энэ нэгдлийн бүрэлдэхүүн компаниуд яг OECD-гийн зарчимд тулгуурласан засаглал, үйл ажиллагаатай болно гэдгийг энэ хууль дээр ер нь дурдаад өгчихсөн.

Тэгээд түрүүн би Та бүхэнд хэлээд байгаа. Энэ хуулийг их дэлгэрэнгүй задалж бичих бололцоо бид нарт байгаагүй гэж.

Хоёрдугаарт, хөрөнгийн удирдлагын компани гэж тэр “Ирээдүйн өв сан”-гийн хуульд дурдсан тэр Норвегийн сангийн удирдлагыг үндсэнд нь оруулсан.

Тэр хуулийн зохицуулалт энэ хуульд бүрэн орж ирж хэрэгжих юм.

Гэхдээ цаг хугацааны юу тавиад өгчихсөн. Яагаад гэхээр нөгөө “Ирээдүйн өв сан” дээр өөрөө 2030 он гэсэн зохицуулалт яваад байгаа учраас түрүүн энэ хэсгийг хэрэгжүүлэхэд бас гараад байгаа хүндрэлийн талаар би ярьсан.

Тэгэхээр тэр болтол Засгийн газар дээрээ хөрөнгийн удирдлагын бодлого нь гараад түүнийхээ дагуу төсвөө боловсруулаад Та бүхэнд Их Хурал дээр оруулж ирнэ.

Тэр институц яг Норвегийн сангийн засаглал руу орно. Тэр засаглал бэхжээд,

- *компанийн хувьд,*
- *боловсон хүчний хувьд,*
- *эрх зүйн хувьд* нь яг хугацаа заачихсан. Ингээд бүртгэе.

Наана Засгийн газар дээр мөн л тэр зарчим дээр үндэслэсэн төлөвлөлт юмыг хийгээд шинэ бүтэц яаран сандран

байгуулахгүй. Их Хурал дээр орж ирээд ирэх жил бид ийм хэмжээний хөрөнгө цугларуулна. Үүнийгээ ингэж өргөжүүлж хөгжүүлнэ. Ийм хөрөнгийн зах зээлийн инстертмент рүү оруулна гэдэг зүйлээ Их Хурал дээрээ ямар ч байсан эхний ээлжид яриад явъя.

Тэр хооронд механизм тодорхой болчихсон учраас мөнгө нь хуримтлагдаад ирнэ. Энэ хооронд бас үйл ажиллагаанууд байгаа институцүүд дээрээ сууриалаад явна.

Яамд бол тэр хөрөнгө оруулалтыг хааш нь хийх вэ, шууд удирдах гэсэн ойлголт байхгүй. Тэр бол зүгээр өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага л тэнд явна гэж ингэж.../минут дуусав/

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн тодруулж асууя. 1 минут.

Н.Энхболд: Тэгэхээр энэ сангуудыг ялангуяа зарцуулахтай нь холбоотой, шинээр арвижуулахтай нь холбоотой энэ бүх менежментийн удирдлагыг нь заавал төрийн.

Хэдийгээр төрийн өмчийн компани байлаа ч гэсэн гэрээ байгуулаад чаддаг бусад газруудаар хийлгэж болно гэж ойлгож болох уу? С.Наранцогт оо. Тэгж ойлгож болох уу?

Тэгэхгүй бол энэ хүмүүс санаа зовоод асуугаад байна шүү дээ. Яамд энэ юмаа ингээд хийдэг бол тэгээд ялгаагүй ээ. Адилхан л идэж уугаад л, дундуур нь хүн ороод л. Хүнээс их юм шалтгаалаад л. Манайх шиг ийм нөхцөлд ингээд энэ чинь бас дахиад л нэг муу юмны эх үүсвэр болно гэсэн юм яриад байна шүү дээ.

Тэгээд тэрийг гэрээгээр бусад байгууллагаар заавал төрийн оролцоотойгоор томилдог удирдлагын байгууллага тэрийг удирдах юм уу,

орондоо гэрээгээр сайн газруудаар хийлгэж болох юм уу гэдгийг л товчхон л хэлчих.

Г.Занданшатар: Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Тэгэхээр одоогийн “Ирээдүйн өв сан”-гийн зохицуулалт дээр ч гэсэн байгаа. Тийм боломж. Удирдуулж болно гээд. Гэрээгээр гадаадын хөрөнгө оруулалт.

Тэгэхээр энэ агуулга одоо яг хадгалагдаж байгаа гэдэг утгаараа Засгийн газар дээр хөрөнгө оруулалтын бодлогыг бид гаргахдаа таны хэлж байгаа энэ зохицуулалтаар оруулаад ирэх боломж бүрэн нээлттэй байгаа.

Тийм учраас бид “Ирээдүйн өв сан” дээр нь энэ хууль дээр бас Монголбанкаар гэрээгээр хэрэгжүүлэх зүйлээ хийгээд явчхаж болно гэсэнтэй адилхан. Энэ сангуудын хөрөнгийн удирдлагын бодлогодоо бид тодорхой шаардлагуудыг хангасан ийм Хөрөнгө оруулалтын корпорацаар гэрээгээр удирдуулж болно гэсэн ийм зохицуулалтыг оруулж ирээд ингээд хийгээд явахад нээлттэй.

Зүгээр ганцхан болгоомжлолыг бид удаа дараа яриад байгаа нь ер нь ямар ч тохиолдолд ингээд нэг ийм эрсдэлүүд байгаад байдаг. Энэ эрсдэл өнгөрсөн хугацаанд нэлээн хэд хэд гарсан.

Тэгээд энэ эрсдэл бол бас тодорхой ил тод биш байдлаас болж л үүсээд байна. Яг одоогоор бид нарын хувьд ялангуяа энэ ашигт малтмалын орлого бол “нийтийн өмч” гэдэг энэ Үндсэн хуулийн агуулга дээр явж байгаа учраас нийт ард, иргэд дээр сонгогдсон.

Их Хурал дээр тэгэхдээ бид хөрөнгө оруулалтын бодлогоо боловсруулаад

засгаараа хэлэлцээд төсвийн нэгдсэн төсөв өргөн барихдаа бүх төлөвлөгөөгөө оруулаад ирнэ.

Түүн дээр одоо жишээлбэл энэ хэмжээний хөрөнгийг энэ жил бид ийм олон улсын хөрөнгийн удирдлагын компаниар хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна гэдэг асуудлыг оруулж ирнэ.

Энэ нь хэрвээ болж байна гэж Их Хурал үзэх юм бол тэр юуг хэрэгжүүлээд л явчихна.

Ер нь нэг ийм тодорхой хугацаанд ийм зохицуулалтаар явахгүй бол бас ийм ил тод байдал нь сайн хангагдахгүй, элдэв эрсдэл үүсээд байна гэдэг агуулгыг бид энэ хууль боловсруулахдаа нэлээн сайн ярьсан гэдэг зүйлийг бас танд би онцолж хэлье.

Г.Занданшатар: Ерөнхийд нь саяын асуултуудад хариулчихлаа. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа.

Юуны өмнө Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар, Тавантолгой компанийн хамт олондоо талархал илэрхийлж байна.

Манай С.Наранцогт дарга энэ компани дээр очоод бас их олон дэвшлүүд гаргаж байгааг бид мэдэж байгаа.

Хамгийн гол нь олон жилийн турш амьгүй 1072 хувьцааны тухай бид ярьж байсан. Зөвхөн аман ярианы түвшинд байсан бол өнөөдөр ямар ч байсан хоёр дахь удаагаа ард иргэд маань одоо энэ Тавантолгой компаниасаа, уул уурхайн баялгаасаа үр шимээ хүртээд явж байгаа нь бас олон нийтэд би итгэл өгч байгаа гэж бодож байгаа.

Яагаад гэвэл ард иргэд маань энэ уул уурхайн баялгаас бид хүртэхгүй байна, эдийн засгийн өсөлт бидэнд мэдрэгдэхгүй байна, баялгийн хуваарилалт шударга биш байна гэдэг ийм шүүмжлэл, гомдлыг олон жил ярьж ирсэн.

Өнөөдрийн энэ хууль орж ирснээр цаашдаа уул уурхайн баялгаасаа Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу ард иргэд үр шимийг нь хуулийн дагуу хүртэх ийм боломжийг нээсэн хуулийн төслийг оруулж ирж байгаа учраас ингээд Та бүхэнд талархал илэрхийлж байгаа юм.

Миний хэлэх гэж байгаа хоёр дахь зүйл бол ямар ч байсан бид Үндэсний баялгийн сантай болж байна.

Энэ “Баялгийн сан” маань “Ирээдүйн өв сан”, “Хуримтлалын сан”, “Хөгжлийн сан” гэсэн гурван сантай байх нь.

Энэ гурван сан ард иргэдтэйгээ яаж шууд уялдах юм бэ. Яаж шууд уялдах юм. Энэ сангуудын ялгаа нь юу вэ гэдгийг Та бүхэн маань ажлын хэсгээрээ миний асуултыг хувааж авч байгаад нэг тодорхой хариулт өгөөд орхиоч.

Дараагийн миний хэлэх гэж байгаа зүйл энэ сангуудын орлого “Төрийн сан”-д төвлөрнө гэж. “Төрийн сан”-д төвлөрөхөөр зэрэг тодорхой хувь хэмжээ өгсөх энэ боломж нь би хязгаарлагдмал байдаг гэж боддог юм.

Олон улсын туршлага бол энэ сангуудын хөрөнгийг найдвартай, алдахгүй байхаар өсгөдөг. Тэгж байж ард түмэндээ очих тэр үр шимийг нь улам өсгөдөг. Та нар маань үүнийг яаж хий гэдэг ийм төлөвлөгөөтэй байгаа юм бэ? Ажлын хэсэг байгуулагдах юм бол ер нь энэ хуулийн төсөл дээрээ бидний ярьж байгаа саналуудыг оруулаад тодорхой дэвшил

гаргах боломж байгаа юу гэдэг ийм асуултуудыг тавиад дараа нь тодруулъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Дашзэгвийн Амарбаясгалан. Хэрэг эрхлэх газрын дарга хариулна.

Д.Амарбаясгалан: Д.Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

“1072 хувьцаа”, “Хуримтлалын сан”-гийн зарцуулалт хоёрын ялгааг тодруулж байна.

1072 хувьцаа бол 2010 оны Улсын Их Хурлын тогтоолоор батлагдаад иргэн бүрт хувьцаа эзэмшүүлэх асуудал шийдвэрлэгдсэн байсан.

Уг шийдвэр Засгийн газар дээр 2012 оны 04 сарын 11-ний өдөр тогтоол гарч иргэн бүр хувьцаа эзэмшигч болж байсан байдаг.

Түүнээс хойш яг энэ 1072 хувьцаа ямар төрлийн хувьцаа вэ гэдэг нь тодорхойгүйгээр саяхныг хүртэл явсан. Ингэвэл өнгөрсөн оны 12 дугаар сард Засгийн газраас “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 34 хувийг нийт ард иргэд эзэмших ёстой.

Мөн 2012 оны 04 сарын 11-нээс хойш төрсөн Монгол Улсын иргэд мөн адил хувьцаа эзэмшигч болох ёстой гэсэн асуудлыг Улсын Их Хуралд өргөн барьсан.

Үр дүнгээр нь иргэн бүр хувьцаа эзэмшигч болсон. 2023 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл төрсөн хүмүүс.

Эдгээр хүмүүст энэ хувьцааны ногдол ашгийг өнөөдөр олгож байна.

Мөн Улсын Их Хурлын тогтоолоор нэг зүйл онцгойлон шийдэгдсэн.

Тэр **“энгийн хувьцаа”** гэдэг төрөл нь **баталгаажсан байгаа**.

Хувьцаа Монгол Улсад үнэт цаасныхаа хуулиар **“энгийн хувьцаа”**, **“давуу эрхийн хувьцаа”** гэдэг хоёр төрөл байдаг.

Тэгэхээр энэ онд 01 дүгээр сарын 07-нд үндсэндээ Улсын Их Хурлын тогтоол маш том алхмыг хийсэн. Үр дүнгээр нь 2022, 2023 оны ногдол ашгаа иргэд хүртэж байна. Өнөөдөр 2023 оны ногдол ашиг 256 мянган төгрөгийг дансандаа авч байгаа юм.

“Хуримтлалын сан” уул уурхайн “Эрдэнэс Монгол” компанийн харьяаны охин компаниудын ногдол ашгийн 34 хувийг төвлөрүүлснээр “хуримтлалын сан” үүснэ. Энэ сан дээр үүсэж байгаа мөнгө иргэн бүрт тэгш хуваарилагдана. Иргэд бэлэн бусаар зарцуулах эрхтэйгээр явах юм.

Яг ногдол ашиг биш. Энэ бол **“хувь хишиг”** гэдэг хэлбэр лүүгээ явна. Үндсэндээ байгалийн баялгаасаа иргэн бүр ижил тэгш эрхтэйгээр хүртэх боломжийг олгож байгаа хэлбэр гэсэн үг.

Үүнийг энэ орж ирж байгаа хуулийн зохицуулалтаараа өнөөдрийн байдлаар боловсрол, эрүүл мэнд, орон сууцны хөтөлбөрт бэлэн бусаар зарцуулах боломжтой гэдгээр томъёолж орж ирж байгаа.

Тийм. 1072 төрлийн хувьцаа бол нөгөө “энгийн хувьцаа” буюу иргэн хүний өмч болчихсон гэсэн үг шүү дээ. Та бидний барьж байгаа гар утастай адилхан бидний хөрөнгө болчихсон.

Тэгэхээр түүнд ногдож байгаа ашгаа жил болгон ногдол ашиг хэлбэрээр авах нь

тусдаа. “Хуримтлалын сан” дээр төвлөрч байгаа мөнгийг ногдсон хувь хишгээ бэлэн бусаар боловсрол, эрүүл мэнд, орон сууцны хөтөлбөрт зарцуулах боломжтой гэсэн ийм хоёр төрөл болж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Яаж өсгөх вэ гэдэг нэг асуулт хариулсангүй гэж байна. Яаж өсгөн үржүүлжүүлэх вэ. 4 номер.

С.Наранцогт: Нэлээд хэдэн гишүүний асуултад гараад хариулаад яваад байгаа. Тэгэхдээ сайн хариулаагүй л юм шиг байна.

“Хөрөнгийн удирдлагын бодлого” нь 2030 он хүртэл Засгийн газар дээр тодорхойлогдоод, тэр бодлогынхоо дагуу жил бүр тухайн сангуудын хөрөнгийг үржүүлэх, өсгөх тэр бодлогоо Их Хурал дээр бид оруулж ирнэ.

Тэгээд Их Хурлаар болж байна гэж үзвэл төсвийн хэлэлцүүлэгтэй адил хийгдээд, энэ жил ийм хэмжээний орлого төвлөрүүлнэ, ийм ийм хөрөнгө оруулалтад байршуулах бололцоотой.

Түрүүн Н.Энхболд гишүүний асуусан зарим тохиолдолд хөрөнгийн удирдлагын компаниар удирдуулаад, ийм болох бололцоотой ийм ийм зүйлүүд гээд ингээд Их Хурал дээр шийдээд явна.

Энэ хооронд Засгийн газар дээр **“Хөрөнгийн удирдлагын компани”** яг Норвегийн сангийн хөрөнгийн удирдлагын компанийн бүтэц, зарчмаар чадавхжиж бэхжээд, 2030 онд “Ирээдүйн өв сан”-д хуульд орж байгаа өөрчлөлтийн дагуу тэр хөрөнгийн удирдлагын компанийн зохицуулалт энэ хууль дээр орж ирснээр яг бие даасан хөрөнгийн удирдлагын компани бий болж үйл ажиллагаагаа явуулах юм гэж л бид ойлгож энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа. Тийм.

Тэр хооронд “сан” маань ч бололцооны удирдах хэмжээний хөрөнгөтэй болчихно. Бид боловсон хүчин нь бас бэлдэнэ. Ялангуяа төрийн өмчийн компаниудын үйл ажиллагаа, засаглалтай холбоотой бас зохицуулалтыг оруулж ирж байгаа.

Яагаад гэвэл иргэд шууд бусаар төрийн өмчит компаниудын 34 хувийг. Одоо Оюу Толгойн жишээлбэл Монголын талд ногдох 34-өөс орж ирэх, ирээдүйд орж ирэх одоогийн ТЭЗҮ-гийн тооцооллоор орж ирсэн тэр 3 тэрбум доллар бүгдээрээ энэ хуримтлалын сан руу орно.

Энэ үед сангийн өөрийнх нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Өнөөдөр энэ Баялгийн сангийн тухай хууль тэгээд л үүнийг дагалдан хуулиуд энэ сангийн тухай орж ирж байна л даа.

Уг нь энэ хууль хэрэгжээд ард иргэд газар хэвлийн ашигт малтмалын ашгаас нь хүртэж байвал сайн л даа. Гэхдээ би хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Энэ Асгатын мөнгөний орд стратегийн чухал орд гээд яриад байгаа юм. 40 жил ярьж байна. Ардчилсан нам гарсан ч ярина, Ардын нам гарсан ч ярина, сонгуулийн шоу болдог. Ерөөсөө.

40 жилдээ хайгуул хийгээд яасан дуусдаггүй орд юм. Энэ одоо. Энэ ашиглалтад оруулж болдоггүй юм уу? Энэ талаар Уул уурхайн сайдаас, Засгийн газар асуумаар байна.

Нөгөө талаар Ногооннуурын нутаг дэвсгэр Дулаанхарын хар тугалганы

үйлдвэр гээд баяжуулах үйлдвэрээ бариад дууссан үйлдвэр байгаа.

Одоо 7 жил болж байна. Эзэн нь Хятад. Баригдаад явчихсан. Эзэнгүй том үйлдвэр байгаа.

1976 онд оросууд үүнийг бас хайгуул хийгээд, нөөцийг нь тогтоогоод л 8 тонн алттай гэсэн юм билээ. Одоо тэнд маш том баяжуулах үйлдвэр баригдсан. Тэрийг үзмээр байх юм.

Хэрвээ тэрийг ашиглаад цаанаасаа тэр Асгатын мөнгөний ордыг бас ашиглах бүрэн боломжтой л доо.

Мөн Ногооннуур сумын нутаг дэвсгэрт Бахлаг багийн Улаан-Уулын вольфрамын үйлдвэр гээд соц нийгмийн, Оросын Холбооны Улстай хамтарч ашиглаж байсан вольфрамын орд байсан.

Дандаа эздүүд нь нэгнээсээ хоёр дахид нь зараад ашиглалтын лиценз авчхаад дамлаад зардаг. Ашиг олдог улсууд байдаг байхгүй юу. Энэ одоо нинжа нар л ашиглаж байгаа. Маш том орд.

Үүнийг яагаад Засгийн газар мэдэлдээ авч болдоггүй юм уу? Буцааж төрд авч болдоггүй юм уу?

Одоо Цэнгэл сумын нутаг дэвсгэрт байгаа том алтны баяжуулах үйлдвэр баригдсан байгаа.

Сая би Ерөнхий сайдтай ярьсан. Тодорхой мэдээлэлгүй байна. Энэ маш том баяжуулах үйлдвэр баригдсан. Том орд. Тодорхой энэ талаар мэдээлэл байна уу? Ер нь. Засгийн газар мэддэггүй юм уу? Аль эсвэл мэдчихээд дуугүй сууж байдаг юм уу?

Хэрвээ энэ бага хэмжээний нөөцтэй байвал том баяжуулах үйлдвэр барихгүй шүү дээ.

Мөн тэр Цэнгэл сумын ордыг **“Эс Жи Групп” ХХК /SG Group LLC/**, “Монгол Бажуу” ХХК ашигладаг юм байна. Энэ талаар судалгаа байна уу?

Мөн Толбо сумын Хөх-Адарын полиметалын орд гээд алт, зэс. Зэсийнх нь нөөцийг нь тогтоогоод Эрдэнэтээс 2.6 дахин өслөө гэсэн. 2009 онд ашиглалтын лиценз авсан. Одоо хүртэл байхгүй.

Одоо дам сонсогдож байх нь ер нь Хонг Конгийн бирж дээр, нөгөө Английн бирж дээр нөгөө зарагдсан сураг байх юм.

Үүнийг ерөөсөө та бүгд судалж үзсэн үү? Уул уурхайн сайд, Засгийн газар дээр мэдээлэл байна уу? Ер нь.

Энэ хэлэхгүй бол болохгүй болчхоод байна.

Мөн тэр Толбын хажуу талд нь Улаанхажуугийн мөн зэс, алтны орд байгаа. 2011 онд ашиглалтын лиценз авсан. Ийм ордуудаа төр эргүүлэн авч баялгийн санг арвижуулахад тус дөхөмтэй болмоор байна. Энэ талаар тодорхой мэдээлэл авъя.

Г.Занданшатар: Дашзэгвийн Амарбаясгалан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариулна. 3 номер.

Д.Амарбаясгалан: Асгатын мөнгөний талаар хариулъя.

1992 оноос хойш энэ Асгатын мөнгөний орд эзэмшил нь маш тодорхойгүй явж ирсэн. Төр эзэмших юм уу. Тэр үеийн хувьчлал хийгдсэн нэрээр, хөрөнгө оруулалт хийсэн нэрээр гадаад, дотоодын иргэдийн нийлсэн хөрөнгө оруулалтын асуудал нь ямар байдалтай

байх юм бэ гэдэг нь тодорхойгүйгээр явж ирсэн.

Үүнтэй холбогдуулаад өнгөрсөн жил “Эрдэнэс Монгол” нэгдлийн дүрмийг өөрчилж охин компаниудаасаа роялти авах, орлогоосоо энэ төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжийг нээсэн байгаа.

Тэгээд үүнтэй холбогдуулаад өнгөрсөн өвлөөс эхлэн энэ Асгатын мөнгөний ордын хайгуулыг нэмж хийх, стандартад нийцүүлэх алхам хийгдсэн. 10 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт одоогийн байдлаар хийгдээд явж байна.

Үндсэндээ “Эрдэнэс Монгол” дангаараа 100 хувь энэ Асгатын мөнгөний ордын хайгуулыг нэмж хийх, ашиглалтад оруулж, төслийг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж ажиллахаар боломжтой болсон байгаа гэдгийг бас таны асуултад хариулья.

Бусад тэр Цэнгэл сум болон Толбо сумтай холбоотой ордуудын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Уул уурхайн сайд нэмж хариулна.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Хариулт сая өгчихсөн л дөө. Тодруулж асуух юм уу? Тийм ээ. Тодруулж асууя. 1 минут.

Б.Бейсен: Тэр Цэнгэл сумын алтны уурхай “Эс Жи Групп” ХХК, “Монгол Бажуу” ХХК ингээд хамтраад том баяжуулах үйлдвэр байсан. Энэ талаар асууя.

Нөгөө талаар тэр Толбо сумын Хөх-Адарын полиметалын орд гээд зэсийн нөөц нь бараг Эрдэнэтээс 2.6 дахин.

Энэ гадаадын биржүүдээр зарагдсан сураг байх юм уу. Энэ үнэн үү, худлаа юу? Энэ талаар.

Ногоон нуурын Дулаанхарын хар тугалганы үйлдвэр гээд баяжуулах үйлдвэр барьсан. Энэ талаар асууя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар хариулья. Тэр орд газрууд хааччихсан бэ?

Ж.Ганбаатар: Баярлалаа.

Баян-Өлгий аймагт одоо яг хүчин төгөлдөр байгаа хайгуулын 65 тусгай зөвшөөрөл байна. Ашиглалтын 30.

Баян-Өлгий аймгийн нийт нутаг дэвсгэрийн 7.90 хувийг энэ тусгай зөвшөөрлүүд эзэлж байна.

Тэр алтны хувьд бид Засгийн газраас барьж байгаа бодлого бол шороон ордыг огт дэмжихгүй байгаа. Шороон ордоор өмнө нь ашиглаж байсан ордуудыг бид одоо үндсэн ордоор ашиглах ийм чиглэлийг өгч байгаа.

Шороон орд байгаль орчныг их бохирдуулдаг. Дээрээс нь хулгай зэлгий, одоо янз янзын байдлууд үүсдэг.

Тийм учраас үндсэн ордыг ашиглахыг яаж байгаа.

Ер нь танд гэж хэлэхэд бид бол ийм байна. Энэ лицензийг бид ингээд хүчингүй болгочихдог. Шүүх дээр очоод юм уу, арбитраг очоод дандаа сэргэдэг.

Тэгэхээр бид нар үүнээс яаж гарах вэ гэхээр би бас түрүүн хэлсэн. Энэ тусгай зөвшөөрлийн төлбөрийг олон улсын жишигт нийцүүлэх хэрэгтэй. Хайгуул бол гурав гурван жилээр авч байгаа шүү дээ.

Гурван жилээр аваад 4 удаа сунгах эрхтэй.
Дээд тал нь 12 жил гэсэн үг.

Тэгээд зарим тохиолдолд энэ лицензтэй зарим хүмүүс бол бараг өөрийнх нь өмч юм шиг байдлаар асуудалд хандаж байгаа.

Тэгээд хэн нэгэн хүн зарах гээд ч юм уу, аль нэгэн хөрөнгө оруулалт хайж байна гээд л бараг 20, 30 жил явдаг. Энэ байдлыг бид зогсооно. Та хэлж байна шүү дээ. Өөрийнхөө мэдэлд авч болдоггүй юм уу гэж.

Тэгэхээр тэр тусгай зөвшөөрлийн төлбөрийг нэмэхээс өөр гаргалгаа өнөөдрийн хуулиар алга байна. Өнөөдрийн хүчин төгөлдөр хуулиар.

Шинэ хууль хэлэлцэж байгаа тохиолдолд үүнийг бид маш олон талаас нь, нэг хүн дээр байгалийн баялаг төвлөрсөн. Тэрийгээ хөрөнгө оруулахгүй их удаагаар энэ зүйлүүдийг бид зогсооно.

Энэ бол шинэ хуулиар гаргалгаатай байгаа гэдгийг танд хариулья.

Тэр уурхайнуудын хувьд одоо би нэг минутын дотор бүгдийг нь хариулахгүй. Танд би тусгайлан мэдээлэл бүгдийг нь өгье.

Тэр Цэнгэл сумын уурхайн хувьд мэдээлэлтэй байгаа. Танд бүрэн мэдээллийг өгье.

Г.Занданшатар: Тэр их сонин орд газар байгаа юм. Эзэн нь алга болчихсон.

Ингээд Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа.

Тэгэхээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид энэ Үндсэн хуулийн 6.2-т баялгийн сантай байна. Баялгийн сан нь ард иргэдэд тэгш хүртээмжтэй байна гэдэг ийм нэг зарчмыг Үндсэн хуульдаа тунхаглаж өгсөн юм.

Түүнээс хойш л Баялгийн сангийн тухай хуулийг яриад байгаа юм.

Тэгээд Засгийн газраас бэлтгээд өргөн барьж байна.

Одоо бид энэ Баялгийн сангийн хуулийг мэдээж Их Хурал дээр хэлэлцэхдээ нэлээн чамбаараад цаашаа явах байх гэж бодож байгаа юм.

Баялгийн сангийн хуультай холбоотойгоор хоёр зүйлийг асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, Засгийн газар, хууль санаачлагчаас асууя гэж бодож байна.

Бидний ойлгож байгаагаар 1072 хувьцаа үргэлжлэх юм байна гэж ойлгож байна. Гол нь Баялгийн санд чинь зөвхөн “Эрдэнэс Тавантолгой” биш бүх л стратегийн ордууд нийлж баялгийн сангаа бүрдүүлж байгаа.

Энэ дотроосоо “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа нь тусдаа хувьцаагаар явах юм байна гэж би ойлгож байна. Тэгж ойлгож байгаа ойлголт зөв үү гэдэг асуудал байгаа юм.

Хоёрдугаарт, “Эрдэнэс Тавантолгой” дээр гардаг нэг асуудал юу байна вэ гэхээр 300 гаруй мянган иргэний асуудал байдаг юм.

Нөгөө сая төгрөгөөр хувьцаагаа өгчихсөн ахмадууд, оюутны сургалтын төлбөр суутган тооцуулчихсан хүмүүс гээд байдаг.

Эдгээр хүмүүсийн асуудлыг “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааныхаа хүрээнд авч үзэх гэж байна уу, эсвэл Баялгийн сангийн хуулийнхаа хүрээнд авч үзэх гэж байна уу гэдэг асуудал байгаа юм.

Гуравдугаарт нь, бид энэ Ашигт малтмалын хуульд нэг өөрчлөлт оруулах юм уу?

Ж.Ганбаатар сайдаас би асуух гээд байгаа юм.

Сүүлийн үед энэ стратегийн ордууд огт гарахаа больчихоод байгаа юм.

Энэ Ашигт малтмалын хуультай холбоотой байхгүй юу. Нөгөө 100 сая тонноос дээш нөөцтэй бол стратегийн орд, доош нөөцтэй бол зүгээр орд гээд ингэчихсэн чинь аль болохоор стратегийн ордод оруулахгүйн тулд нөөцөө нуун дарагдуулах, эсвэл нөөцөө хувааж хоёр, гурван компани болгох. Ингээд ийм сөрөг үр дагаврууд аягүй яваад стратеги ордууд огт бүртгэгдэхгүй байгаа юм.

Үүнээс аль болохоор зайлсхийж зугтаад байгаа юм.

Тэгэхээр Уул уурхай яам, бодлого боловсруулж байгаа яамны хувьд ер нь энэ заалтыг цаашид яаж өөрчилж гэж санал боловсруулж байгаа юм бэ?

Үүнийг бид өөрчилж нэг өөр болгохгүй бол цаашдаа стратегийн ордууд ерөөсөө нэмэгдэхгүй байгаа юм.

Бид нэг сайхан “Баялгийн сан” байгуулдаг. Хуучин стратегийн орд орсон хэдэн ордуудаа нухаад байдаг. Гэтэл нөгөө шинээр орж байгаа томоохон томоохон ордууд огт орохоо больчих гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хүрээнд нь Баялгийн сангийн хууль батлагдсаны дараа Ашигт малтмалын хуульд энэ чиглэлийн өөрчлөлтүүдийг хийж өгөхгүй бол цаашдаа иргэд биднээс тавих шаардлага нь

- стратегийн ордуудынхаа тоог нэмэгдүүл,
- компанийнхаа үр ашгийг сайжруул,
- иргэн хүнд ноогддог ногдол ашгийг нь нэмэгдүүл

гэдэг ийм л шаардлага тавина шүү дээ. Тийм.

Энэ шаардлагыг нь биелүүлэхийн тулд Ашигт малтмалын хуульд оруулах өөрчлөлтийн асуудал их чухал байгаа юм. Ийм хоёр зүйлийг асууя.

Г.Занданшатар: Дашзэгвийн Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: Д.Тогтохсүрэн гишүүний асуултад хариулья.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн энгийн 1072 хувьцаа “Баялгийн сан”, “Хуримтлалын сан”-тай ямар нэгэн байдлаар холбогдохгүй. Би түрүүн хариулсан байгаа.

Энэ 1072 хувьцаа бол хувьцаа эзэмшигчийн хөрөнгө болоод оччихсон байгаа.

Өнгөрсөн оны 12 дугаар сард Засгийн газар тогтоолын төсөл Улсын Их Хуралд өргөн барихдаа таны сая асуусан “Сайн хувьцаа” нэрээр хувьцаагаа зарчихсан байгаа 300 гаруй мянган иргэдийн хувьцааг тухайн үеийнх нь нэрлэсэн ханшаар худалдаж авах боломжтой хэлбэрээр тогтоолын төслийг өргөн барьж байсан.

Улсын Их Хурлаар 01 сарын 07-нд шийдэгдэхдээ тэр асуудал дэмжлэг аваагүйгээр шийдэгдсэн байгаа.

Мэдээж үүнтэй холбоотой иргэдээс “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани дээр энэ хувьцаагаа буцааж худалдаж авах боломж олгооч гэсэн хүсэлт бас тодорхой түвшинд ирж байгаа гэдгийг хэлмээр байна.

“Баялгийн сан” буюу түүн дотор байгаа “Хуримтлалын сан”-д төрийн өмчит уул уурхайн компаниудын 34 хувийн ногдол ашиг оногдохоор хуульчлагдахаар хуулийн төсөлд өргөн барьж байгаа.

Тэгэхээр төрийн өмчтэй л компаниудын ногдол ашгийн 34 хувь нь “Хуримтлалын сан” руу орно гэсэн үг. Жишээлбэл, “Оюу Толгой” компанийн 34 хувийг “Эрдэнэс Оюу Толгой” компаниар дамжуулж Монголын төр “Эрдэнэс Монгол” эзэмшиж байгаа бол тэр 34 хувь чинь тэр чигтээ “Хуримтлалын сан”-гийн орлогын эх үүсвэр болж орно.

Түүнтэй мөн адил одоо “Эрдэнэс Тавантолгой”, бусад төрлийн стратегийн ордуудын төрийн эзэмшилтэй компаниудын хувь орно.

Хувийн хэвшлийн уул уурхайн ордууд, байгалийн баялаг, одоо юу гэдэг юм уул уурхайн компаниуд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр “Ирээдүйн өв сан”, “Хөгжлийн сан” хэлбэр лүү АМНАТ хэлбэрээрээ ороод явдаг болно гэдгийг тайлбарлая.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч.

Жамбалын Ганбаатар сайд тэр нөөцийг нь дутуу бүртгээд стратегийн ордод бүртгэхгүй байна гэсэн. Танайх нөөц

тогтоохдоо тэгж тогтоогоод байгаа юм уу гээд.

Жамбалын Ганбаатар. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Тийм зүйл байхгүй. Д.Тогтохсүрэн дарга.

Тэр нөөц тогтоож байгаа асуудал манай Эрдэс баялгийн зөвлөл болоод Ашигт малтмалын газар ирүүлж байгаа нөөцийг маш зөв тогтоож байгаа. Энэ бол баталгаатай.

Таны хэлж байгаа тэр хуваасан байдалтай, эсвэл цагийг хүлээсэн байдалтай, эсвэл өөр өөр компаниудаар бүртгэж байгаа байдал байхыг үгүйсгэхгүй. Бид тантай санал нэг байна. Ийм зүйлүүд байгаа.

Энэ стратегийн ордыг цааш нь өргөжүүлэх дээр 2007 оны энэ Их Хурлын тогтоолын 2 дугаар хавсралтын асуудал байгаа л даа. Үүнийг Их Хурал шахаж ажилламаар байгаа юм.

2 дугаар хавсралт дээр 39 компанийг Засгийн газарт үүрэг өгөөд байршилтай. Компани юу байх вэ. Орд газруудыг стратегийн ордод хамруул гэдэг үүрэг өгсөн. Одоо хүртэл энэ биелээгүй явдаг юм билээ.

Үүнийг биелүүлэх талаар Уул уурхайн яам тодорхой ажлуудыг Засгийн газар “Эрдэс Монгол” компанитай хамтраад хийж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байна уу? Дэмжсэн 3, дэмжээгүй 3 л

гишүүн үг хэлнэ. 6 гишүүн бүртгэгдсэн байна.

Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Баялгийн сангийн хуулийг маш чухал хууль гэж хэлчхээд яагаад дэмжих боломжгүй гэж хэлээд байгаа юм бэ гэдэг дээр бас үндэслэл хэрэгтэй.

Тэгэхээр Ардчилсан намаас өргөн барьсан хуулиас тэгвэл энэ хууль яг ямар ямар ялгаатай байна вэ гэдэг асуудлууд энэ дээр гарч ирнэ. Засаглалын хувьд эрс ялгаатай.

Яамдын сайд нар буюу улс төрийн албан тушаалтнууд 4 жилийн томилгоотнууд биш үүнийг хараат бус мэргэжлийн олон улсын удирдлага үүнийг удирдах ёстой.

Шаардлагатай хугацаанд Дэлхийн банканд RAMP_[Reserves Advisory and Management Program] гээд хөтөлбөр байдаг. Итгэмжлэлээр дэлхийн баялгийн сангуудыг удирддаг ийм хөтөлбөр ч байдаг.

Энэ энэ зүйлүүдийг ашиглах ёстой. Засаглалын хувьд гэж бид бүгдийн хуулийн төсөл дээр өргөн барьсан.

3 дэд сангийнх нь нэг нь “Хөгжлийн сан” гээд сан байна. Энэ нь өөрөө энэ хуулийн төсөл дээр төсөвтэйгөө бүрэн дүүрэн холилчихсон. Төсвөөр санхүүжүүлэх ёстой ажлууд, төсвөөр санхүүжүүлэх ёстой төсөл, хөтөлбөрүүдийг бүгдийг нь эндээс хамаагүй санхүүжүүлнэ гээд заачихсан.

Улсын төсөв, “Хөгжлийн сан” гэдэг хоёрын нэрнээс өөр ямар ч ялгаагүй болгоод хаячихсан.

Ийм учраас “Хөгжлийн сан” гэдэг дэд сан нь утга учир муутай ийм сан болчихсон.

“Хуримтлал” гэдэг нэртэй санг нь Нийгмийн хамгааллын сайд удирдаад “Халамжийн сан”-гаас ямар ч ялгаагүй сан байхаар ийм нөхцөл байдалтай, ийм үзэл баримтлалтай хуулийн төсөл орж иржээ.

Мөн төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дээр байгаа тэр өөрчлөлт, шинэчлэл, нээлттэй болох олон ажлуудыг энэ хуулийн төсөл дээр хөндөлгүйгээр “Эрдэнэс Монгол” гээд ашигтай ашиггүй баахан зүйлийг нэгтгэчихдэг нэг компанийн энэ бүтэц, зохион байгуулалт, давуу эрхийн хувьцаа гэдэг олон зүйлүүдийг энд бүгдийг нь орхигдуулжээ.

Тэгээд энэ хуулийг үзэхэд 3 хуудас, 6 нүүр хууль байна л даа.

Уг нь хууль их байхдаа сайн биш байх. Товчхон байвал сайн байх. Гэтэл маш олон харилцааг зохицуулахгүй

- Засгийн газар шийднэ,
- Улсын Их Хурал тогтоолоор шийднэ.

Бараг 8 жил, бараг 4 жил боловсруулж Засгийн газраас оруулж ирж байгаа ийм анхдагч асар чухал хуулийн төсөл гэхэд 3-хан хуудас, 4-хөн хуудас хуулийн төсөл гэж үнэхээр асар хариуцлагагүй, ажиллаагүй, олон зарчмын зөрчилтэй асуудлуудыг тэр чигт нь шийдэл гаргахгүй орхисон, яаравчилсан нөхцөл байдалтай асар хариуцлагагүй ажилласан хуулийн төсөл энд ингээд орж иржээ.

Ийм учраас Ардчилсан намын бүлгийн зүгээс өргөн барьсан хуулийн төслийг бид яг Улсын Их Хурлаар бид үндсэндээ хэлэлцүүлэх хүсэлт тавихгүй. Яагаад гэвэл энэ хуулийн төсөлтэй

зарчмын хувьд бараг 90, 100 хувь нь өөр байна.

Энэ хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх зарчмын хувьд бололцоогүй учраас бид бүгдийн хувьд хэлэлцүүлэх хүсэлт нэгдүгээрт тавихгүй.

Хоёрдугаарт, яг энэ хууль дээр бас тэгэхдээ Ардчилсан намын бүлгийн зүгээс бид завсарлага авахгүй. Завсарлага авахгүй.

Яагаад гэвэл нэгэнт бүх зүйл зарчмын хувьд нийцэхгүй хуулийг бид саатуулаад энэ дээр ямар ч үр дүн байхгүй.

Олонхоороо батлаад яваг.

Мэдээж зарчмын олон асуудлуудыг хойш тавьсан, үндсэндээ социалист маягийн хууль орж ирж байгаа учраас энэ дээр хэзээ нэгэн цагт магадгүй 2024 онд Ардчилсан нам олонх болох цаг ирэх байх. Энэ үед бас эрүүл саруулаар зарчмын том өөрчлөлтийг энэ хуульд иж бүрнээр хийх ёстой юм байна гэж ойлгож байгаа.

Тэгээд “Баялгийн сан” гэдэг үнэхээр энэ хуульд. Энэ маш чухал үзэл баримтлал үгийг ингээд хайран зүйлийг яйран болгосон ийм дутуу хөтүү ийм хууль орж ирж байгаа нь үнэхээр харамсалтай.

Магадгүй яг энэ чигээрээ явбал “Үндэсний баялгийн сан” биш, магадгүй дахиад том үндэсний нэг тийм авлигалын сангийн асуудал гарч ирэх нөхцөл байдал бүрдсэн хуулийн төсөл орж ирж байгаад харамсаж байгаагаа илэрхийлье.

Тэгээд энэ хуулийг яг энэ чигээр нь бид бүгдийн хувьд дэмжих боломжгүй гэдгээ бас илэрхийлж байна.

Г.Занданшатар: Тилеуханы Аубакир гишүүн. Нэг дэмжихгүй үг хэллээ.

Т.Аубакир: Би дэмжиж үг хэлнэ.

Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Монгол Улсын иргэн бүр тэгш хүртээх утга агуулга бүхий хууль орж ирж байгаа.

Саяхан бид 1072 хувьцааны ашгийг иргэддээ бодитойгоор хүртээж эхэлсэн.

Мэдээжийн хэрэг өргөн барьж байгаа хуулийг хэлэлцүүлгийн явцад сайжруулах, цаг үетэйгээ нийцүүлсэн. Сая Улсын Их Хурлын гишүүдийн хэлж байгаа санал, санааг тусгаж сайжруулах боломж аль аль намын бүлгийн өмнө байж байгаа. Энэ хуулийн ажлын хэсэгт ороод хэлэлцүүлгийн явцад чамбайруулаад цаашдаа хөгжүүлээд энэ хуулийг бид гаргах нь чухал.

Ж.Батжаргал гишүүн хэллээ.
Д.Сарангэрэл гишүүн хэллээ.

Одоо энэ хуулийн энэ сангийн арвижуулах бодлогыг бид давхар энэ дээр тусгаад явах нь зөв шүү гэж. Энэ бол чухал санаа.

Одоогийн өргөн барьсан юун дээр “Ирээдүйн өв сан”-гийн мөнгөн хөрөнгийг Монголбанк дахь “Ирээдүйн өв сан”-гийн валютын дансанд байршуулна.

10.3 дээр хуримтлалын болон хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна.

Зүгээр нэг банкны дансанд байршуулаад орхих биш тэр мөнгийг цаашаа арвижуулах бодлогыг бид заавал цуг авч явах хэрэгтэй.

Энэ хэлэлцүүлгийн явцад гишүүд энэ дээр энэ санаа оноогоо тусгаад явах боломж бий.

Түрүүн Т.Энхтүвшин гишүүний хэлдэг, Ж.Ганбаатар гишүүн бас хэллээ.

Ер нь бид цаашдаа энэ газрын доорх баялгийнхаа нөөцийг тогтоох ажлыг бас чамбайруулах зайлшгүй шаардлагатай. Энэ маань эргээд баялгийн сангийн цаашдаа уртын хугацаанд амьдрах, энэ санд итгэл төрүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлж өгөх юм.

Одоо яг өнөөдөр ашиглаж байгаа стратегийн ордуудын маань нөөц дуусах үед бид залгуулаад дахиад нөөц тогтоогдсон ийм ийм нөөц бүхий стратегийн ордууд байна.

Тийм учраас баялгийн санг нь цаашаа залгаад эх үүсвэр нь эндээс дахиж гарч ирэх юм гэдэг итгэлийг төрүүлээд явах хэрэгтэй. Норвегийн сангийн бас нэг гол концепт тийм байдаг.

Тийм учраас энэ хуулийг дэмжиж байгаа. Цагаа олсон. Өнөөдөр оруулахгүй бол бид хойш нь тавих цаг хугацаа бидэнд байхгүй.

Тийм учраас энэ хуулийн төслийг дэмжиж байна.

Г.Занданшатар: Дэмжиж үг хэллээ. Нэг нэг болсон.

Сайнбуянгийн Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Хуулийн төслийг дэмжиж байгаа.

“Баялагтаа эзэн Монгол”
мөрийн хөтөлбөрийг дэвшүүлсэн.

Өнөөдөр Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлж байгаа.

Тэгээд энэ Үндэсний Баялгийн сангийн ач холбогдол асар өндөр.

Бидний өөрсдийн туулж ирсэн зам, ирээдүйн зорилго, энэ цаг үеийн хүндрэл, бэрхшээлүүдийг нарийн эргэцүүлж тооцож алсдаа тогтвортой хөгжлийг бий болгоход “Үндэсний баялгийн сан” Монгол Улсад эдийн засгийн бие даасан байдлыг бий болгоно.

Болзошгүй хямралт болон үзэгдэл, аливаа уналт, бүр цаашлах юм бол түүхий эдийн үнийн хэлбэлзлийг даван туулах санхүүгийн бат бөх суурь нөөцийг бүрдүүлнэ. Ингэснээр

- эдийн засгийг тогтворжуулна,
- улсын төсвийг эрүүлжүүлнэ,
- санхүүгийн гэнэтийн хямрал, цочролоос сэргийлнэ

гэсэн ийм боломжийг бүрэн бүрдүүлж байгаа юм.

Хоёрдугаарт, энэ сан бий болсноор баялгийн олборлолт болон бусад түүхий эд, эх үүсвэрээс олсон орлогын тодорхой хэсгийг “Үндэсний баялгийн сан”-д төвлөрүүлэх гол зорилго байгаа.

Ингэснээр хойч үедээ эх орныхоо байгалийн баялгийн үр шимийг бодитойгоор үлдээх хүртээх нөхцөлийг бүрдүүлж байгаа.

Энэ өөрөө угаасаа илүү тогтвортой, тэгш, хүртээмжтэй эдийн засгийг бий болгох бидний нөгөө яриад байдаг асуудлыг бодит ажил болгох ийм боломжтой.

Гуравдугаарт, манай улсад хөрөнгө оруулалтын, ялангуяа дэд бүтэц, нийгмийн

асуудлууд, тулгамдсан асуудал, том төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын багцыг төрөлжүүлэх боломж бүрдэнэ.

Ингэж нэг эх үүсвэрээс хамааралтай байдаг. Тэгээд төсөв алдагдалтай бол улсын эдийн засаг зогсдог. Төсөв нэмэгдвэл хүрэлцээгүй бүх зүйл дээр тараадаг тархай бутархай эдийн засгийн бодлого, хэвшмэл байдлаас ангижруулна.

Ингэж байж бид энэ улс орны эдийн засгийг аливаа гадаад орчны хямрал, цочрол, тэгээд дотоод нөхцөл байдлаас шалтгаалсан тогтворгүй байдлаас урьдчилан сэргийлэх боломжууд бүрдэнэ.

Дөрөвдүгээрт, мэдээж “Үндэсний баялгийн сан”-гийн хөрөнгийг эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, ажилгүйдэл, ядуурлын бууруулах, дэд бүтцийн төслүүдээ эрчимтэй богино хугацаанд хэрэгжүүлж, тогтвортой өсөлттэй, хүртээмжтэй эдийн засгийг бий болгох ийм зорилт бүрэн хэрэгжих юм байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол ажлын байр бий болно, хөдөлмөр эрх эрхлэлт нэмэгдэнэ. Бүр цаашлах юм бол энэ улс орны бүс нутаг олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Өөрсдийгөө таниулж оршин тогтнох тэр ур урт хугацааны эрх ашгийг хангана.

Хамгийн сүүлд энэ “Үндэсний баялгийн сан”-гаас эрүүл мэнд, боловсролын салбарыг хүртээмжтэй болгох, чанартай болгох, стандарттай нийцсэн эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлж, хүн төвтэй хөгжлийн бодлогын стратегия эрчимтэй хөгжүүлэх боломж нөхцөл бүрэн бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Энэ бүхэн бидний амьжиргааны түвшнийг дээшлүүлж, улс орны орлогын тэгш бус байдлыг арилгах халах ийм чухал үр нөлөөтэй.

Гэхдээ энэ дээр бас нэг зүйлийг анхаарах ёстой бид нар. Энэ баялгийн сан, хөгжлийн сан, тогтвортой хөгжлийнх ч бай, “Ирээдүйн өв сан” ч бай аль аль нь энэ санхүүгийн мэргэжлийн удирдлага, зохион байгуулалттай байх талаас. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, олон улсын санхүүгийн байгууллага, ижил төрлийн баялгийн сангийн бүтэц, зохион байгуулалт, тогтолцоо, үйл ажиллагааны дүрэм, журам гээд зүйлүүдээ эхнээс нь маш тодорхой бөгөөд ойлгомжтой, эзэнтэй, эргээд хариуцлага тооцох, зогсоолтоо тодорхой болгож өгөхгүй бол дуртай нь гарч ирж дүрмийг нь өөрчилдөг, дургүй үедээ хэрэгжилтийг нь зогсоодог.../минут дуусав/

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: “Үндэсний баялгийн сан”-гийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж байгаа.

Энэ цаг үеэ олсон маш чухал зүйл. Энэ цаг үед л хийх шаардлага хэрэгцээ үүсэж байгаа юм.

Тэгээд энэ эрдэс баялгийн салбарын орлогыг одоо болон ирээдүйд иргэддээ тэгш хүртээх, хуваарилах зорилгоор хэд хэдэн хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол төсөл, хөтөлбөрүүд батлагдаж гарч байсан.

“Хүний хөгжлийн сан”-гийн тухай хууль гарсан. “Ирээдүйн өв сан”-гийн тухай хууль гарсан.

Тэгээд эд нар маань эргээд үр дүнгээ өгсөн үү гэвэл өгөөгүй.

Эсрэгээрээ бүр “Хүний хөгжлийн сан”-гийн алдагдлыг Засгийн газар үнэт цаас гаргаж, Засгийн газрын зээл болон урьдчилгаа төлбөр зэргээр санхүүжүүлж явснаас болж “Хүний хөгжлийн сан” чинь өөрөө эргээд 1 их наяд гаруй төгрөгийн өр үлдээсэн.

Хөгжлийн банкны зээлийг дураар олгосноос болж санхүүгийн маш том алдагдалд орсон. Үүнийг тухайн үеийн Засгийн газар бие дааж шийдвэрлэж байсан.

Ийм учраас би энэ дээр юу хэлэх гээд байна вэ гэхээр нэгдүгээрт орлогын зарцуулалт их тодорхой байх ёстой юм.

Хоёрдугаарт, энэ “Ирээдүйн өв сан”-гийн тухай хууль юм бол хуримтлал үүсгэх ёстой юм.

Ингэж хуримтлал үүсгэхийн тулд үлдээсэн өр дардаг сан болчих вий дээ гэдэг дээр их санаа зовж байна. Энэ дээр ажлын хэсэг дараагийн хэлэлцэх явцдаа нэлээн онцгой анхаарна биз гэж бодож байна.

Хоёр дахь нь, энэ хуулийн танилцуулга дээр нэг зүйл байгаа юм.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.5-д заасан орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд энэ зүйлд заасны дагуу албан татвар ногдуулахгүй гээд.

Мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эцсийн эзэмшигч нь хуулийн этгээдийн хувьцаа, хувь

оролцоо, саналын эрхээ бэлэглэх, өв залгамжлалаар өвлүүлэх хэлбэрээр газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн бүрэн буюу хэсэгчилсэн бусдад шилжүүлсэн тохиолдолд 30 хувиар бууруулна гээд.

Хоёр дахь нь, энэ дээр би ямар санаа зовж байна гэхээр энэ маань лицензийн наймаа болоод хувирчих вий дээ. Үүнийгээ нэлээн сайн анхаарч харахгүй бол бас болохгүй шүү гэдэг ийм хоёр саналыг хэлье.

Төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа юм.

Г.Занданшатар: 1 гишүүн дэмжихгүй үг хэлж, 3 гишүүн дэмжих үг хэллээ.

Одоо дэмжихгүй гишүүн үг хэлнэ. М.Оюунчимэг гишүүн дэмжихгүй. Үндэсний баялгийн сангийн тухай хууль хэлэлцэх эсэхийг дэмжихгүй байгаа юм уу? Тийм ээ. Эсэргүүцэж байгаа юм байна. Тийм ээ. Тэгээд өөр үг хэлээд байдаг шүү.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн хуулийн төсөл хэлэлцэх эсэхийг дэмжихгүй үг хэлнэ. Эсэргүүцэж үг хэлэх гэж байгаа юм байна.

М.Оюунчимэг: Эсэргүүцэх, эсэргүүцэхгүйдээ асуудал нь гол биш.

Ер нь энэ хууль маш сайн хэрэгжээсэй гэж бодож байгаа. Учир нь гэвэл бидэнд бас өмнө нь “Ирээдүйн өв сан”-гийн тухай хууль, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт дээр бид алдаа гарсан.

Тэгэхээр энэ алдааг энэ Баялгийн сангийн хууль дээр бид давтаж болохгүй. Яагаад гэвэл “Баялгийн сан” бол

Монголын ард түмний өмч гэдэг утгаараа энэ ил тод, нээлттэй, шилэн байх ёстой. Үүнийг бид арвижуулах ёстой.

Тийм учраас өнөөдөр дэлхийн хэмжээнд 450 гаруй сан ажиллаж байгаа. Үүний 177 нь л ашигтай ажилладаг. Үүний 178 нь болоод манай “Баялгийн сан” ороосой гэж хүсэж байгаа.

Тийм учраас л энэ баялгийн сан өөрөө өнөөдөр эрсдэл их байгаа. Манайхан маш сайн тооцох хэрэгтэй.

Яагаад гэвэл бид сүүлийн 30 жилд төгрөгийн ханшийг бодоход л бараг 700 дахин унасан гэж хэлж болно.

Манай гадаад өр өнөөдөр 34 бараг тэрбум ам.доллар байгаа. Нийт өрийн тухайд аваад үзэхэд одоо энэ ингээд сүүлийн 30 жилээс хуримтлагдсан гээд. Бид өнөөдөр инфляц ямар байгааг бас бодолцох ёстой. Цаашдаа төгрөгийн ханшаа тогтвортой байлгах нь өөрөө “Баялгийн сан” амжилттай, эрсдэлгүй ажиллах гол нөхцөл болох учиртай юм.

Тийм учраас энэ зүйлүүд дээр бид өнөөдөр хэлэлцэхдээ маш сайн бодолцох ёстой гэсэн байр суурийг би илэрхийлмээр байгаа.

Харин бусад улс оронд “Баялгийн сан” нь ихэвчлэн 6 сангаасаа бүрдээд явчихдаг бол манайх харин 3 сангаар эхэлж байгаа юм байна. Тийм ээ. Хөгжлийн, хуримтлалын гээд. Энэ нь бас зөв болов уу. Яагаад гэвэл өнөөдөр манай хөгжлийн байгаа байдал, цаашид өмнөө тавьсан зорилт энэ тэрээсээ аваад үзэхэд 3 санг хөгжүүлээд үүнийгээ задлаад аваад явчихъя гэсэн бодлоготой орж ирж байгааг би бас дэмжиж байгаа.

Тэгээд хамгийн чухал зүйл нь бид хуулиа батлахдаа сая миний хэлээд байгаа

“Ирээдүйн өв сан”, Хөгжлийн банк дээр гарсан алдааг давтахгүйн тулд маш тодорхой маш сайн хэлэлцүүлэг хийж, ажлын хэсэг маш сайн ажиллах хэрэгтэй.

Ямар ч байсан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр гишүүнээр ажлын хэсэг ахлуулж байгаа нь сайн байна гэж би бодож байгаа. Б.Баттөмөр гишүүн ч өөрөө маш мундаг. Үүнийг судалдаг, ажлаа ярьдаг.

Тэгэхээр ажлын хэсэг хариуцлагатай сайн ажиллаад. Энэ хууль гарах нь зөв. Сая би иргэдтэйгээ уулзаад ирэхэд “Үндэсний баялгийн сан”, энэ “Хөгжлийн сан” гээд энэ ажлууд чинь бидэнд, ард түмэнд ямар ашигтай болох юм. Энэ эргээд саяын нүүрс болон бусад юм шиг явчихгүй байгаа байгаа даа гээд болгоомжлуулж байсан.

Тэгэхээр энэ өөрөө 1072 хувьцааны ашгаа хүртэж байгаадаа иргэд маш их баяртай байна.

Гэхдээ одоо цаашдаа хуримтлал үүсгээд бидний гэр хорооллийг дэд бүтцүүлэх юм уу, эсвэл өөр түвшинд хөгжилд хүрээсэй гэсэн хүлээлт байгаа. Энэ хүлээлтийг хөгжлийн сангаасаа бид санхүүжүүлээд явчих бүрэн бололцоо байгаа.

Тиймээс бид энэ хуулийг хэлэлцэхдээ маш нухацтай, хариуцлагатай хэлэлцээсэй. Иргэд үүнийг хүсэн хүлээж байна.

Гэхдээ энэ нь өөрөө үр дүнгээ өгөөсэй, өөрийн минь амьдралд, улс орны минь амьдралд үр дүн өгөөсэй гэж харж байгаа.

Тиймээс Норвегийн баялгийн сан шиг манайхан маш олон удаа явж туршлага судалсан. Тэгээд энэ бол Монголд

бодитоор энэ хөрсөн дээр хэрэгжээсэй гэсэн үүднээс байр сууриа илэрхийлж байна. Тэгээд дэмжиж байна.

Г.Занданшатар: Тийм. Ер нь хэлсэн үгэндээ л байж сурах хэрэгтэй байгаа юм.

Ингээд гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа сууна. Санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлдэж байна уу? Дэмжсэн, дэмжээгүй үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор Баагаагийн Батгөмөр гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулж ажиллана.

Ардчилсан намын бүлэг оруулах хүнийхээ нэрийг өгөх хэрэгтэй. Энд бүтээлчээр хандах хэрэгтэй. Тэр орох саналуудаа оруулаад үүнийг бүтээлчээр мэтгэлцэж хэлэлцээд шүүсийг нь шахаж байгаад сайн хууль болгоно гэж итгэж байна.

Үндсэн хуулийн 6.2-т байгалийн баялаг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлана гэж заасан.

Одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга, хүртээмжтэй болгох гэж чиглэгдэнэ гэж заасан.

Стратегийн орд газруудыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн Үндэсний баялгийн сангаас тэгш, шударга,

хүртээмжтэйгээр, нийт ард түмэнд дийлэнх үр өгөөж нь оногдож ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасан.

Энэ маань ингээд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бас удаан хэлэлцсэний эцэст одоо ингээд амьдралд хэрэгжих гэж байна.

Нэгдүгээрт, өсөж үржиж байх ёстой шүү гэж Д.Сарангэрэл гишүүнээс авхуулаад маш олон гишүүн хэлж байгаа.

“Норвегийн сан” ил тод байдаг.

Үржүүлэхийн хүрд шиг тоонууд нь байнга **“real time”**⁵[\[https://www.nbim.no\]](https://www.nbim.no) хөдөлгөөнтэй харагдаж байдаг. Тэгээд ямар бонд, юу худалдаж авсан бүх юм нь ил тод.

Ингэж байж ард түмний баялаг чинь жинхэнэ **“санхүүгийн баялаг”** болж хувирч байгаа юм.

Тэрний гол эрхэм зорилго, уриа нь юу гэж байна гэхээр **“Бид ирээдүй үеийнхээ санхүүгийн баялгийг бүтээж, хуримтлуулж, хамгаалахын төлөө ажиллаж байна”** гэсэн үг, агуулгатай.

Энэ газрын хэвлийн баялгийг санхүүгийн баялаг болгож хувиргаж байгаа байхгүй юу. Газрын хэвлийн баялгийг санхүүгийн баялаг болгож хувиргаад өсгөж үржүүлж байгаа юм.

Одоо сүүлийн үед бас энэ байгалийн баялгийн хараалд нэрвэгдсэн улсуудын туршлагад үндэслээд хайгуулыг улс өөрөө хийх хэрэгтэй.

⁵ Norges Bank Investment Management: The fund

Газрын доор юу байгаагаа мэдэх хэрэгтэй. Шинжлэх ухаан, технологи хөгжчихсөн.

Харин ашиглахдаа хувийн хэвшилд, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид зарах хэрэгтэй. Тэр хуримтлуулсан мөнгөө энэ санд хуримтлуулж байгаад нийт ард түмэндээ өгөөжтэй болох ийм модель илүү хүчтэй болж байгаа байхгүй юу.

Тэгээд л нөгөө хулгай зэлгий, энэ тэр байхгүй.

Энэ бол хамгийн сайн чиглэл гэж Нобелийн шагналт эрдэмтэд хүртэл сүүлийн үед байгалийн баялгийн итгэл дээр гарч байгаа юм.

Ийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг л амилуулах ажил удааширч байгаа боловч хэрэгжиж байна.

Хамгийн гол нь энэ ахиад нөгөө сангууд шигээ авлигын сан болж болохгүй.

Ийм учраас тэр “Ирээдүйн өв сан”-гийн хуулийг хэрэгжүүлээгүй алдагдсан боломжийн өртгийг тооцвол бас асар их асуудал гарна шүү дээ. Одоо чинь бид алдагдсан боломжийн өртөг аягүй их ярьдаг болчихсон.

Гэтэл тэр “Ирээдүйн өв сан”-гийн корпорацыг байгуулаад, доллароор нь хуримтлуулаад ингэж нэг өдөр л улс төрийн шийдвэрээр ашиглаж зарцуулаагүй байсан бол 10 тэрбум доллар хүрчих байсан байна гээд манай Төсвийн байнгын хорооны шинжээчдээс дүгнэлт, санал хүртэл гаргачихсан явж байгаа.

Ийм эрсдэлт нөхцөл байдлыг л ирээдүйд учруулж болохгүйд хамгийн гол нь чиглэгдэнэ.

Салхитын жижигхэн мөнгөний ордон дээр л гэхэд л АМНАТ-ын төлбөр, тэр хулгай, луйвар маш олон юм нь гурван шатын шүүхээр тогтоогдсон.

Ингээд авахад л 260 мянган ахмадын тэтгэвэр тэглээд, 240 мянган ахмадад 1 сая төгрөг өгөөд, маш олон асуудал хүртээмжтэй болгож чиглэж байсан нэг ийм жишээ бол нөгөө байгалийн баялгийн хулгай гэдэг юм чинь зөвхөн нүүрсний хулгайгаас өмнө тэнд бүх нүх сүвээр нь.

Тэр лабораторийн шинжилгээ, гаалийн татвар, АМНАТ бүх шатад нь хэдэн арав дахин бага татвар төлж тэгж гаргаж байдаг чинь нөгөө байгалийн баялаг ашиглахдаа бид энэ АМНАТ-ын тооллого гэдэг юм хийх ёстойг зайлшгүй харуулж байгаа юм.

Ийм учраас Ерөнхий сайд ч гэсэн хэллээ. Нээлтэй сонсголыг зохион байгуулна.

Эдийн засгийн байнгын хороо тэр ашигт малтмалын лицензийн ашиглалт АМНАТ-ын тооллогыг хийх ажлын хэсэг эхлүүлчихсэн байгаа. Маш сонин сонин дүр зураг, тоо баримтууд урьдчилсан хяналт шалгалтаар тогтоогдож байгаа.

Ашигт малтмалын лиценз эзэмшигчээсээ илүү дамлан худалдаалдаг хэсэг бүлэг байна гэсэн ийм дүгнэлт гарч байгаа.

32 удаа дамлаад худалдчихсан тийм хөрөнгө оруулдаггүй хэсэг бүлэг байх жишээтэй.

Ийм учраас **“Баялагтаа эзэн Монгол”** гэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг амьдралд хэрэгжүүлэхэд Үндэсний Баялгийн сангийн хууль ил тод,

нээлттэй, тэгш шударга шинэ эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэх ёстой.

Үүнээс хэн ч хойшоо сууж болохгүй. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт амилуулах ажил Улсын Их Хурлын тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгавруудыг үндэслэж байна.

Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулж байна.

Миний саналыг дэмжсэнд тооцоорой. Би юу ч гэж хэлсэн байсан гэсэн гишүүд хариуцлагатай байхыг дахин сануулъя.

Ер нь жоохон. Сүүлийн үед би ажиглаад байгаа шүү.

Та нар дандаа ард түмний саналыг эсэргүүцэж байгаа. Авлигачдын гар хөл болж байгаа хэсэг бүлэг байгаа гэж Ерөнхий сайд ч гэсэн зарласан.

Үүнийг бид авч хэлэлцэнэ. Чуулганыг тасалсан хуралдааны ирцийг чинь бүгдийг нь зарлах болно. Би.

Энэ асуудлыг дэмжсэнд тооцоод Эдийн засгийн байнгын хороонд эхний хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлээ.

Ахиад нэг мэдээлэл байна. Гишүүд сууж байгаарай.

Энэ гурилын үнийн өсөлт, үнийг зохиомлоор өсгөж байгаа асуудалтай холбогдуулаад Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан.

Ж.Бат-Эрдэнэ гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулсан.

Энэ ажлын хэсэг гурилын үйлдвэрүүд дээр энэ хагас, бүтэн сайнд бүх газрууд шалгалт хийж, үнийг зохиомлоор өсгөсөн эсэхийг үндэслэлийг нь тодорхой болгож, ингээд энэ гурилын үнийн өсөлтийн асуудлыг цэгцлэхэд анхаарлаа хандуулж ажиллана.

Тэгээд гаалийн татварын асуудлаа цэгцэлж шийдүүлнэ.

69.0 хувиар сая Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дэмжсэнд тооцсон.

Ингээд Ж.Бат-Эрдэнэ гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ирэх долоо хоног гэхэд гаалийн татвар, гурилын үнийг буулгах ажлаа цэгцэлсэн байна.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудал дууссан тул чуулган өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Ирээдүйн өв сан”-гийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Ирээдүйн өв сан”-гийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Хууль баталсантай холбогдуулан авах арга

хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хурааж 69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг

үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулган өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 50 минут үргэлжилж, 15 цаг 59 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД